МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.01.10 № 3Г-1/14

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.01.06 № ХЯ/76

танай ______ -ны № ______ -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 122 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

000225000851

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn
Вэбсайт:www.mof.gov.mn

2023.01.04 № 01/48

танай 2022.11.30-ны № 01/6080-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлэх бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б. ЖАВХЛАН

9761000007

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.01.04 № 1/63

танай 2022.12.30-ны № 01/6081-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

Танаас ирүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Х.НЯМБААТАР

151600148

А5 Файл.2022

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлд:

“XXIX.ХЭЛЭЛЦСЭН нь: Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
С.БЯМБАЦОГТ
9020050420 5919437 CBA7589

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Х.НЯМБААТАР

# ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 5.1-д “Бодлогод заасан зорилтыг хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрэхийн тулд түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ”, 5.2-т “Төмөр замын салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааны харилцааг хуульчлах замаар төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчинг сайжруулна”, 5.3-т “Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байж болох бөгөөд өмчийн олон төрөл, хэлбэрийн тээвэрлэгч бий болох орчин, нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 07/04 дүгээр “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” зөвлөмжөөр “Төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар даруй хэлэлцэж батлах арга хэмжээ авах”-ыг Монгол Улсын Их Хуралд зөвлөмж болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 72-т “Төмөр замын тээврийн үйлчилгээнд оролцогчдыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр зах зээлийн өрсөлдөөнд тэгш байдлаар оролцох боломжоор хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, тээврийн бусад салбарын уялдаа холбоог оновчтой зохицуулах, тээвэр логистикийн цогц үйлчилгээ бий болох эрх зүйн орчинг бүрдүүлэх” гэж заасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах, улсын эдийн засаг, нийгмийн нэгдмэл орон зайг бэхжүүлэх зорилгоор төмөр замын сүлжээ байгуулахад харгалзах хүчин зүйлийг тодорхойлж хуульд тусгах шаардлага үүссэн.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, хэрэглэгчийн тоо өссөн бөгөөд 2010 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч 1 байсан бол өдгөө суурь бүтэц

эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болсон байна. Иймд өмчийн олон хэлбэр бүхий төмөр замын суурь бүтэц эзэмшигчид болон тээвэрлэгчдийн хоорондын харилцаа, тэдгээрийн тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байх зүй ёсны шаардлага бий болоод байна.

Төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, суурь бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн тасралтгүй, хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангуулах, үйлдвэрлэл, техникийн үйлчилгээ засварыг өргөжүүлэх зориулалттай тусгай болон хамгаалалтын бүс, зурвас газрыг дур мэдэн, хууль бусаар эзэмших, ашиглах асуудал гарч, аюултай бүсийн асуудлыг бүрэн зохицуулах шаардлага гарч ирсэн.

Төмөр замын суурь бүтцийн өмчлөл, эзэмшил, төмөр замын үйлчилгээ, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлж, хэрэглэгчдэд найдвартай аюулгүй үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлага бий болсон.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Барилгын тухай хууль шинэчлэгдсэн болон шинээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай, Зөрчлийн тухай, Хууль тогтоомжийн тухай болон Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

***Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ***

Төсөлд хуулийн зорилтыг “төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, суурь бүтэц барих, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 11 бүлэгтэй бөгөөд дараах агуулгатай байхаар боловсруулна.

*Нэгдүгээр бүлэгт:* Нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёо;

*Хоёрдугаар бүлэгт:* Төмөр замын тээврийн талаарх төрийн зохицуулалт;

*Гуравдугаар бүлэгт:* Төмөр замын тээврийн дүрэм, журам, тусгай зөвшөөрөл;

*Дөрөвдүгээр бүлэгт:*Төмөр замын тээврийн зориулалттай газар;

*Тавдугаар бүлэгт:* Төмөр замын сүлжээ, суурь бүтцийн бүтээн байгуулалт;

*Зургадугаар бүлэгт:* Төмөр замын тээвэрлэлт, түүний төрөл;

*Долдугаар бүлэгт:* Хөдлөх бүрэлдэхүүн;

*Наймдугаар бүлэгт:* Төмөр замын тээврийн аюулгүй байдал;

*Есдүгээр бүлэгт*: Төмөр замын тээврийн тариф, даатгал;

*Аравдугаар бүлэгт:* Төмөр замын тээврийн ажилтны хөдөлмөрийн харилцааны онцлог зохицуулалт;

*Арваннэгдүгээр бүлэгт:* Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тус тус тусгана.

***Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлснээр гарах дүн***

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт дараах зэрэг үр дүн гарна:

Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой зарим суурь харилцаа хуулийн хүрээнд илүү тодорхой зохицуулагдаж, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын тэгш оролцоог хангаж, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ сайжирч, хөрөнгө оруулалт, тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Төмөр замын тээврийн зориулалттай газрыг хуульчилснаар төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, хамгаалалтын бүс тодорхой болж төмөр замын аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ.

Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил, ашиглалтын харилцаа тодорхой болж, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь хуулийн хүрээнд тэгш эрхийн зарчимд үндэслэн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Төмөр замын нийтийн зориулалттай зам, тусгай зориулалттай зам, салбар замын өмчлөл, эзэмшлийн асуудлыг тодорхой зохицуулснаар төмөр замын тээвэрлэлтийн харилцааг зохицуулах боломжтой болно.

Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй холбоотой ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, төмөр замын ажилтны нийгмийн баталгаа сайжирч, тэдний тогтвортой ажиллах нөхцөл бүрдэх юм.

Төмөр замын тээврийн эдийн засгийн зарим зохицуулалтыг хуульчилснаар төмөр замын тээврийн зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, тээврийн бодит өртөгт үндэслэсэн, ашгийн зохих түвшинг хангасан үнэ тарифийн уян хатан бодлого хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

***Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар***

Энэ хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцсэн байна.

Уг хуулийн төсөлтэй хамт Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төмөр замын тээврийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---

# ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 5.1-д “Бодлогод заасан зорилтыг хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрэхийн тулд түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ”, 5.2-т “Төмөр замын салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааны харилцааг хуульчлах замаар төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчинг сайжруулна”, 5.3-т “Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байж болох бөгөөд өмчийн олон төрөл, хэлбэрийн тээвэрлэгч бий болох орчин, нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 72-т “Төмөр замын тээврийн үйлчилгээнд оролцогчдыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр зах зээлийн өрсөлдөөнд тэгш байдлаар оролцох бололцоогоор хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, тээврийн бусад салбарын уялдаа холбоог оновчтой зохицуулах, тээвэр логистикийн цогц үйлчилгээ бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх” гэж заасан.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах, улсын эдийн засаг, нийгмийн нэгдмэл орон зайг бэхжүүлэх зорилгоор төмөр замын сүлжээ байгуулахад харгалзах хүчин зүйлийг тодорхойлж хуульд тусгах шаардлага үүссэн.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, хэрэглэгчийн тоо өссөн бөгөөд 2010 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч 1 байсан бол өдгөө суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болсон байна.

Төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, суурь бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн тасралтгүй, хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангуулах, үйлдвэрлэл, техникийн үйлчилгээ засварыг өргөжүүлэх зориулалттай тусгай болон хамгаалалтын бүс, зурвас газрыг дур мэдэн, хууль бусаар эзэмших, ашиглах асуудал гарч, аюултай бүсийн асуудлыг бүрэн зохицуулах шаардлага гарч ирсэн.

Төмөр замын суурь бүтцийн өмчлөл, эзэмшил, төмөр замын үйлчилгээ, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлж, хэрэглэгчдэд найдвартай аюулгүй үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлага бий болсон.

Иймд өмчийн олон хэлбэр бүхий төмөр замын суурь бүтэц эзэмшигчид болон тээвэрлэгчдийн хоорондын харилцааг зохицуулах, тэдгээрийн тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байх зүй ёсны шаардлага бий болоод байна.

**Хуулийн төсөлд шинээр болон шинэчлэн оруулсан онцлох зохицуулалтууд:**

- Хуулийн төсөлд тодорхойгүй байсан төмөр замын нийтийн зориулалттай болон тусгай зориулалтын зам, салбар замын өмчлөл, эзэмшлийн асуудлыг зохицуулсан.

- Төмөр замын зориулалттай газрыг тодорхойлж, төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, хамгаалалтын бүсийн талаарх зохицуулалтыг тодорхой болгосон.

- Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл, барилгын ажил, суурь бүтцийг ашиглалтад оруулах талаар зохицуулсан.

- Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ, түүнд тавигдах шаардлага, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүргийн талаар тусгаж, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч тэгш эрхийн үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

- Төмөр замын суурь бүтцийн өмчийн хэлбэрийг нарийвчлан тодорхойлсон. Мөн нийтийн бус хэрэглээний суурь бүтцийг төмөр замын бодлого хөтөлбөртэй уялдуулан нийтэд зорчигч, ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэх боломжтойгоор харилцааг зохицуулсан.

- Төмөр замын тээвэрлэгчийн эрх үүргийг нэмэгдүүлж, тээвэрлэгч нь өөрийн гэсэн хөдлөх бүрэлдэхүүнтэй байх болон өөрийн зүтгүүргүй тохиолдолд зүтгүүрээр үйлчлүүлэх гэрээ байгуулсан байх, мөн суурь бүтцийн үйлчилгээний гэрээ байгуулсан байх зэрэг шаардлагыг тодорхойлсон.

- Төмөр замын суурь бүтцийг барих, засварлах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгийн 0.4 хувиар тооцсон орлогыг төвлөрүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Төмөр замын төслийг хэрэгжүүлэх явцад төмөр замтай холбоотой боловсруулсан норм, нормативын баримт бичиг байхгүй учраас бусад салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй норм нормативыг ашигласан боловч салбарын онцлогт тохирохгүй, хүндрэлтэй байсан. Иймээс төмөр замын салбарын норм, нормативын баримт бичгийг орчуулах, боловсруулах, сурталчлах зэрэгт зарцуулах санг бий болгох шаардлага үүссэн.

**Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:**

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төмөр замын байгууллагуудаас санал авч, нийт 170 санал ирснээс үндэслэл бүхий 39 саналыг хуулийн төсөлд тусгасан болно.

Зам, тээврийн хөгжлийн яам, төмөр замын байгууллагын холбогдох төлөөллийг оролцуулан хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогч талуудаас өгсөн нийт 15 санал зөвлөмжөөс 10 саналыг хуулийн төсөлд тусгасан.

**Төсөл батлагдсанаар гарах үр дүн:**

Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой зарим суурь харилцаа хуулийн хүрээнд илүү тодорхой зохицуулагдаж, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын тэгш оролцоог хангаж, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ сайжирч, хөрөнгө оруулалт, тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Төмөр замын тээврийн зориулалттай газрыг хуульчилснаар төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, хамгаалалтын бүс тодорхой болж төмөр замын аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ.

Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил, ашиглалтын харилцаа тодорхой болж, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь хуулийн хүрээнд тэгш эрхийн зарчимд үндэслэн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Төмөр замын нийтийн зориулалттай зам, тусгай зориулалттай зам, салбар замын өмчлөл, эзэмшлийн асуудлыг тодорхой зохицуулснаар төмөр замын тээвэрлэлтийн харилцааг зохицуулах боломжтой болно.

Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй холбоотой ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, төмөр замын ажилтны нийгмийн баталгаа сайжирч, тэдний тогтвортой ажиллах нөхцөл бүрдэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дүгээр сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ
**/Шинэчилсэн найруулга/**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, суурь бүтэц барих, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж

2.1.Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын тээвэртэй холбоотой харилцааг зохицуулахад өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй үйлчилнэ.

3.2.Метро, трамвай, соронзон болон тусгай загвар бүхий түүнтэй адилтгах нийтийн тээврийн төмөр замыг барих, ашиглахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төмөр замын тээвэр” гэж төмөр замын тээвэрлэлт болон түүнд зориулагдсан суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, бусад байгууламж, тоног төхөөрөмж бүхий үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний технологийн иж бүрдлийг;

4.1.2.“төмөр замын тээвэрлэлт” гэж зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэхэд бэлтгэх, тээвэрлэх, тээвэрлэлтийг дуусгахтай холбоотой технологийн харилцан уялдаатай цогц ажил үйлчилгээг;

4.1.3.“тээвэрлэгч” гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу төмөр замаар зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

4.1.4.“төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч” гэж төмөр замын суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

4.1.5.“төмөр замын тээврийн байгууллага” гэж тээвэрлэгч, төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийг;

4.1.6.“төмөр замын суурь бүтэц” гэж төмөр замын дээд, доод бүтэц, гүүр, хоолой, өртөө, зөрлөг, эрчим хүч, усан хангамж, дохиолол, холбоо, мэдээлэл, сүлжээ, техник, технологи бүхий инженерийн байгууламжийг;

4.1.7.“нийтийн зориулалттай төмөр зам” гэж төмөр замын суурь бүтэц бүхий нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой, нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай төмөр замыг;

4.1.8.“тусгай зориулалтын төмөр зам” гэж төмөр замын суурь бүтэц бүхий аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан, гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр замыг;

4.1.9.“салбар зам” гэж ачаа ачих, буулгах зам талбай, хүлээн авах, олгох, хадгалах үйлчилгээ үзүүлэх болон бусад зориулалттай байгууламж бүхий төмөр замыг;

4.1.10.“хөдлөх бүрэлдэхүүн” гэж тээвэрлэлтэд ашиглаж байгаа зүтгүүр, ачааны болон зорчигчийн вагон, төмөр замаар явагч тусгай зориулалтын техник хэрэгслийг;

4.1.11.“хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч” гэж энэ хуулийн 4.1.10-д заасан техник хэрэгслийг эзэмшиж байгаа хүн, хуулийн этгээдийг;

4.1.12.“галт тэрэг” гэж чиглэлийн дугаар, зүтгүүр бүхий хөдлөх бүрэлдэхүүнийг;

4.1.13."зорчигч" гэж төмөр замаар зорчиж буй зорчих тасалбар, түүнтэй адилтгах баримт бичигтэй хүнийг;

4.1.14.“ачаа” гэж вагон, чингэлгээр тээвэрлэхээр зохих журмын дагуу хүлээн авсан эд зүйлсийг;

4.1.15.“аюултай ачаа” гэж төмөр замын тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулах, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, үхэл, хордлого, түлэгдэлт, өвчин, осол үүсгэж болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлсийг;

4.1.16.”төмөр замын чиглэл” гэж төмөр замын эхлэл, төгсгөлийг тогтоосон байршлыг;

4.1.17."төмөр замын чиг" гэж төмөр замын чиглэлийн дагуух солбилцлын цэгүүдийг;

4.1.18."төмөр замын цариг" гэж төмөр замын хос зам төмрийн дотор талын ажлын ирмэг хоорондын зайг;

4.1.19."галт тэрэгний хөдөлгөөний зурмаг" гэж галт тэрэгний явах, өнгөрөх, ирэх хугацааг заасан технологийн баримт бичгийг;

4.1.20."төмөр замын объект" гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зурвас газар, суурь бүтэц, салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон техник, тоног төхөөрөмжийг;

4.1.21."төмөр замын аюулгүй байдал алдагдах" гэж төмөр замын технологийн горим зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, хүн, хуулийн этгээдийн өмчид хохирол учруулах осол, зөрчлийг;

4.1.22."төмөр замын өртөө" гэж галт тэрэг хүлээн авах, явуулах, зөрүүлэх, зорчигчдод үйлчлэх, ачаа, тээш, ачаан тээшийг хүлээн авах, олгох болон сэлгээний ажлыг хэвийн гүйцэтгэх зам, төхөөрөмж, байгууламж бүхий төмөр замын суурь бүтцийн хэсгийг;

4.1.23."төмөр замын гарам" гэж төмөр зам авто замтай нэг түвшинд огтлолцсон уулзварыг;

4.1.24."тусгай зориулалтын багаж, хэрэгсэл" гэж төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах хатуу бүртгэл, дугаар, хяналттай ашиглах багаж, хэрэгслийг;

4.1.25."ачаан тээш" гэж хүн, хуулийн этгээдээс тээшийн вагоноор тээвэрлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн эд зүйлсийг;

4.1.26." "ачаан тээш" гэж хүн, хуулийн этгээдээс тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн эд зүйлсийг;

4.1.27."тээш" гэж тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн зорчигчийн эд зүйлсийг.

**5 дугаар зүйл.Төмөр замын тээвэрт баримтлах зарчим**

5.1.Төмөр замын тээвэрт дараах зарчмыг баримтална:

5.1.1.хөдөлгөөний нэгдсэн зохицуулалттай, тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулсан байх;

5.1.2.үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангасан, тогтвортой байх;

5.1.3.зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлийг бий болгож, тэгш оролцоог хангасан байх.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

**6 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1.Улсын Их Хурал төмөр замын тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж батлах, түүний биелэлтийг хянан шалгах;

6.1.2.төмөр замын тээврийн талаарх олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3. нийтийн зориулалттай төмөр замын чиглэл тогтоох;
6.1.4.энэ хуулийн 7.1.7-т заасан царигийн асуудлыг шийдвэрлэх.

**7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

7.1.Засгийн газар төмөр замын тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах, хяналт шалгалт хийх;

7.1.2.техник, эдийн засгийн судалгаанд үндэслэн төмөр замын суурь бүтцийн чиг тогтоох;

7.1.3.төмөр замын зурвас газрын ашиглах хугацааг тогтоох;
7.1.4.төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

7.1.5.Монгол Улсын Хилийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-т заасан хилийн бүсэд төмөр замын суурь бүтэц барихтай холбоотой асуудлыг шийдвэрлэх;

7.1.6.тусгай зориулалтын төмөр замын чиглэлийг тогтоох;
7.1.7.нийтийн зориулалттай төмөр замын царигийн асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх.

7.2.Энэ хуулийн 7.1.4-т заасан түдгэлзүүлэх, сэргээх эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-т заасны дагуу төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлж болно.

**8 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

8.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах;

8.1.2.төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

8.1.3.төмөр замын тээврийн салбар дахь төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг төлөөлөх болон төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагааг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу төрийг төлөөлөн хэрэгжүүлэх;

8.1.4.төмөр замын суурь бүтэц, салбар замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбоотой ажлыг зохион байгуулах;

8.1.5.энэ хуулийн 14.1.2-14.1.6-д заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

8.1.6.төмөр замын осол, зөрчлийг шинжлэн шалгах;

8.1.7.улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой зарим төрлийн ачаанд Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу тээвэрлэлтийн давуу байдал олгох.

**9 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

9.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга төмөр замын тээвэртэй холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.тухайн нутаг дэвсгэрт орших төмөр замын зурвас газар, түүний гадна байрлах төмөр замын байгууламжид нийгмийн хэв журам сахиулах ажлыг төмөр замын тээврийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

9.1.2.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг цэргийн албанд татахаас бусад Дайчилгааны тухай хуулийн 3.1.14-т заасан дайчилгаанд хамруулахгүй байх;

9.1.3.төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсаны улмаас учирсан хор уршгийг арилгахад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал, мод, ус ашиглах зөвшөөрлийг олгох;

9.1.4.төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсаны улмаас учирсан хор уршгийг арилгахад Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.9-д заасан үйл ажиллагааг зохион байгуулах.

9.1.5.төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой газар олгох, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоожид нийцүүлэн шийдвэрлэх.

**10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

10.2.Төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.2.1.төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт боловсруулах, сурталчлах;

10.2.2.төмөр замын техник технологитой холбоотой журам, аргачлал, горим, заавар, техникийн даалгавар, жагсаалт, загвар батлах;

10.2.3.төмөр замын суурь бүтцүүдийн хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих;

10.2.4.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах;

10.2.5.төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвийг нэгдсэн удирдлагаар хангах;

10.2.6.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах;

10.2.7.төмөр замын тээврийн тарифыг хянах, санал, дүгнэлт гаргах;

10.2.8.төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх□, хэрэгжилтийг хангуулах;

10.2.9.төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийн зэрэг, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох;

10.2.10.төмөр замын тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацийг нэвтрүүлэх төлөвлөгөө, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

10.2.11.төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг барих, өргөтгөх ажиллагаанд хяналт тавих;

10.2.12.хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, дугаар, гэрчилгээ олгох;

10.2.13.төмөр замын суурь бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх;

10.2.14.төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх;

10.2.15.төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох;

10.2.16.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, гэрчилгээ олгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах.

10.3.Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь энэ хуулийн 10.2.8 дахь заалтад заасан хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан байцаагчийн эрхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ДҮРЭМ, ЖУРАМ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ

### 11 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн дүрэм, журам

11.1.Төмөр замын тээврийн салбарт дараах дүрэм, журам, аргачлал, нормыг баталж мөрдүүлнэ:

11.1.1.төмөр замын техник ашиглалтын дүрэм;

11.1.2.төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм;

11.1.3.төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм;

11.1.4.галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;

11.1.5.төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам;

11.1.6.төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам;

11.1.7.төмөр замын осол, зөрчлийг шинжлэн шалгах журам;

11.1.8.төмөр замын дохиолол, холбооны журам;

11.1.9.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг зохицуулалтын журам;

11.1.10.төмөр замын зориулалттай газарт объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, огтлолцох журам;

11.1.11.хөдлөх бүрэлдэхүүн ашиглах журам;

11.1.12.Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох журам;

11.1.13.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцөл, сахилгын тусгай журам;

11.1.14.төмөр замын гарам ашиглах журам;

11.1.15.төмөр замын тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах журам;

11.1.16.төмөр замын тээврийн мэдээлэл бүртгэх, солилцох журам;

11.1.17.төмөр замын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийн зэрэг болон хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох журам;

11.1.18.төмөр замын ажилтан албаны хувцас хэрэглэх журам;

11.1.19.төмөр замын суурь бүтэц, салбар замын үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийг ашиглах журам;

11.1.20.төмөр замын тээврийн тариф тогтоох аргачлал;

11.1.21.төмөр замын барилгын ажлын төсвийн суурь норм;

11.1.22.тусгай тээвэрлэлтийн журам;

11.1.23.төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам;

11.1.24.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн тэргүүн зорчих тусгай галт тэрэгний аялах журам;

11.1.25.Төмөр замын техник, технологийн баримт бичиг, норм, стандартын сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам;

11.1.26.Төмөр замын ажилтанд эрүүл мэндийн үзлэг хийх журам;

11.1.27.Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам.

11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.20, 11.1.21, 11.1.25, 11.1.27-д заасан журмыг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-т заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.

11.3.Төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 11.1.22, 11.1.23-т заасан журмыг тагнуулын байгууллагатай, энэ хуулийн 11.1.24-т заасан журмыг төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай, энэ хуулийн 11.1.26-д заасан журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тус тус хамтран батална.

11.4. Энэ хуулийн 11.1.15-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тагнуулын байгууллагатай хамтран батална.

**12 дугаар зүйл.Төмөр замын стандарт, тохирлын үнэлгээ**

12.1.Төмөр замын тээврийн стандарт, тохирлын үнэлгээтэй холбоотой харилцааг энэ хууль болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар зохицуулна.

12.2.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахад зориулагдсан хэмжилт, оношлогооны багаж, техник, хэрэгсэлийн баталгаажуулалтыг Хэмжил зүйн тухай хуулиар зохицуулна.

**13 дугаар зүйл.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сан**

13.1.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах, хэвлэж олшруулах, сурталчлах болон эдгээрийг зохион байгуулах зориулалт бүхий сантай /цаашид “сан” гэх/ байна.

13.2.Сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

13.2.1.төмөр замын суурь бүтцийг барих, засварлах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгийн 0.4 хувиар тооцсон орлого;

13.2.2.төмөр замын техникийн баримт бичиг, норм борлуулсны орлого;

13.2.3.төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгох зорилгоор өгсөн хандив, тусламж.

13.3.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

**14 дүгээр зүйл.Төмөр замын тусгай зөвшөөрөл**

14.1.Төмөр замын тусгай зөвшөөрөл дараахь төрөлтэй байна:

14.1.1.төмөр замын суурь бүтэц барих;

14.1.2.төмөр замын суурь бүтэц ашиглах;

14.1.3.төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

14.1.4.төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх;

14.1.5.төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ;

14.1.6.төмөр замын техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ.

14.2.Зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгээс гадна тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадвартай эсэх, төмөр замын объект, үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.1, 5.4, 5.6, 5.7, 5.12, 5.13-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах нөхцөл шаардлагыг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

14.4.Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох, сунгах өргөдлийг хүлээн авч магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлж, шийдвэр гаргуулахаар ажлын 2 өдөрт багтаан Засгийн газарт хүргүүлнэ. Засгийн газар зөвшөөрөл олгох, сунгах саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэрийг гаргана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАР

**15 дугаар зүйл.Төмөр замын тээврийн зориулалттай газар**

15.1.Төмөр замын тээврийн зориулалттай газарт тусгай бүс, зурвас газар, хамгаалалтын бүс хамаарна.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан газрын хэмжээг стандартаар тогтооно.

15.3.Төмөр замын тээврийн зориулалттай газарт объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх харилцааг энэ хуулийн 11.1.10-д заасан журмаар зохицуулна.

**16 дугаар зүйл.Төмөр замын тусгай бүс**

16.1.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг тусгай тэмдэг, тэмдэглэгээ бүхий дэвсгэр газрыг төмөр замын тусгай бүсэд хамааруулна.

16.2.Төмөр замын тусгай бүсэд энэ хуулийн 11.1.10-т заасан журмаар тогтоосон дэглэмээс бусад үйл ажиллагаа явуулах, нэвтрэх, объект байрлуулахыг хориглоно.

**17 дугаар зүйл.Төмөр замын зурвас газар**

17.1.Төмөр замын шугамын дагуух технологийн үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах газар нь төмөр замын зурвас газарт хамаарна.

17.2.Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.

17.3.Төмөр замын аюулгүй байдалд саад учруулах, үзэгдэх орчинд сөрөг нөлөө үзүүлэхээр бол төмөр замын зурвас газрын мод, бут, өвс, ургамлыг шилжүүлэн суулгах, хадах арга хэмжээ авна.

17.4.Төмөр замын зурвас газарт төмөр замын тээврийн үйл ажиллагаанаас бусад үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

**18 дугаар зүйл.Төмөр замын хамгаалалтын бүс**

18.1.Төмөр замын суурь бүтцийг гадны сөрөг хүчин зүйл, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, төмөр замын аюулгүй байдал алдагдах, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалах зориулалт бүхий газар нь төмөр замын хамгаалалтын бүсэд хамаарна.

18.2.Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах болон төмөр замыг өргөтгөх зориулалтаар хамгаалалтын бүсийг нэмэгдүүлж болно.

**19 дүгээр зүйл.Төмөр замын цариг**

19.1.Монгол Улсын төмөр замын сүлжээ, түүнд холбогдох буюу огтлолцох төмөр замын цариг ижил байна.

19.2.Хил дамнасан төмөр замын царигийн асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн шийдвэрлэнэ.

19.3.Энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд царигийн асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ, СУУРЬ БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

### 20 дугаар зүйл.Төмөр замын сүлжээ

20.1.Тээвэрлэлтийн төлөвлөлт, зохицуулалтын нэгдмэл системтэй, харилцан холбогдсон төмөр замын суурь бүтцүүдийг төмөр замын сүлжээ гэнэ.

20.2.Төмөр замын суурь бүтцүүдийг холбоход дараах шаардлагыг хангана:

20.2.1.галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт нэгдмэл, төвлөрсөн байх;
20.2.2.зорчигч, ачаа тээвэрлэлтийн нэгдсэн бичиг баримттай байх;
20.2.3.цахим мэдээлэл солилцох нэгдмэл технологи, сүлжээтэй байх;

20.3.Төмөр замын сүлжээг хөгжүүлэхэд дараах хүчин зүйлийг харгалзана:

20.3.1.улсын нийгэм, эдийн засаг болон бүс нутгийн хөгжлийн бодлого;
20.3.2.хүн амын суурьшил, хот, суурин газрын байршил, ирээдүйн хөгжлийн төлөв;

20.3.3.ашигт малтмалын орд газрын байршил, нөөц, түүнийг ашиглах боломж;

20.3.4.олон улсын болон хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв;

20.3.5.аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл, аялал жуулчлалын газар, нөөц газар, амралт, сувиллын газрын бүс нутгийн байршил;

20.3.6.эрчим хүч, холбоожуулалтын нэгдсэн тогтолцоо, тэдгээрийн хөгжлийн хэтийн төлөв;

20.3.7.газрын гадаргын хэв шинж, газар зүйн байршил, бартаажилт, инженер-геологийн нөхцөл;

20.3.8.тусгай хамгаалалтай газар нутгийн байршил, ирээдүйн төлөв.

### 21 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл

21.1.Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл нь төмөр замын суурь бүтцийг барих, засварлахад шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, геологийн дүгнэлт, ус зүйн судалгаа, геодезийн хэмжилтийн тайлан, археологи, палеонтологийн судалгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, судалгаа, инженерийн тооцоо, нарийвчилсан зураг, төсөв, техникийн шаардлага зэргээс бүрдэнэ.

21.2.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулах төмөр замын суурь бүтцийн зураг төслийг гадаадын хуулийн этгээд боловсруулах тохиолдолд Монгол Улсын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй хамтран гүйцэтгэнэ.

21.3.Төмөр замын суурь бүтцийн зураг төслийг Монгол Улсын эрх бүхий этгээдээр магадлуулсан байна.

21.4.Төмөр замын суурь бүтцийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавихтай холбоотой харилцааг энэ хуулийн 11.1.6-д заасан журмаар зохицуулна.

**22 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажил**

22.1.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн зохицуулалт стандартын дагуу барьж гүйцэтгэнэ.

22.2.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага, захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

**23 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах**

23.1.Төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах ажиллагааг энэ хуулийн 11.1.5-д заасан журмаар зохицуулна.

23.2.Ашиглалтад оруулах төмөр замын суурь бүтэц нь холбогдох хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

23.3.Захиалагч нь төмөр замын суурь бүтцийг Улсын комисс ажиллахаас өмнө дараах үүрэг бүхий техникийн комиссыг томилон ажиллуулна:

23.3.1.гүйцэтгэлийн зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг шалгах;

23.3.2.тухайн төмөр замын суурь бүтэц батлагдсан зураг, төсөл, төсөв болон түүнд оруулсан өөрчлөлтийн дагуу баригдсан, суурилуулагдсан эсэхийг шалгах;

23.3.3.төмөр замын суурь бүтэц, түүний бүрдлийг шалгах, турших, акт, баримт, тайлан бүрдүүлж дүгнэлт гаргах.

23.4.Захиалагч нь төмөр замын суурь бүцийг ашиглалтад оруулахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

23.4.1.төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын үе шатны гүйцэтгэлийн тайлан;

23.4.2.барилгын ил, далд ажлын акт;

23.4.3.зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

23.4.4.захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

23.4.5.төмөр замын суурь бүтцийн инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл;

23.4.6.төмөр замын суурь бүтцэд хийгдсэн хийц, бүтээцийн шинжтэй өөрчлөлтийн зураг төсөл, түүний зохиогчийн зөвшөөрөл, магадлалын дүгнэлт;

23.4.7.төмөр замын суурь бүтцийн гүйцэтгэлийн зураг;
23.4.8.техникийн комиссын үүрэг даалгаврын биелэлт;
23.4.9.төмөр замын суурь бүтцийн бүрдэл хэсгийн тоног төхөөрөмж угсарсан акт, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилуулсан эсэхэд хийсэн туршилтын дүгнэлт;

23.4.10.эрх бүхий байгууллагын гүйцэтгэсэн техник ашиглалтын түвшин тогтоох шалгалтын дүгнэлт;

23.4.11.бусад холбогдох баримт бичиг.

23.5.Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 23.4-т заасан баримт бичиг нь шаардлага хангасан тохиолдолд төмөр замын суурь бүтцийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг томилно.

23.6.Энэ хуулийн 23.2-т заасан шаардлага хангасан төмөр замын суурь бүтцийг өртөө, зөрлөг хооронд хэсэгчлэн ашиглалтад оруулж болно.

23.7.Энэ хуулийн 23.6-д заасан төмөр замын суурь бүтцийг хэсэгчлэн ашиглалтад оруулахтай холбоотой харилцааг энэ хуулийн 11.1.5-д заасан журмаар зохицуулна.

23.8.Ашиглалтад оруулаагүй төмөр замаар хүн тээвэрлэх, зорчигчийн галт тэрэг аялуулахыг хориглоно.

**24 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийн өмчлөл**

24.1.Нийтийн зориулалттай төмөр зам нь төрийн өмчит буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байна.

24.2.Улсын хилийн боомт чиглэлийн болон хил дамнасан төмөр зам нь нийтийн зориулалттай төмөр замд хамаарна.

24.3.Төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих тохиолдолд төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншлэлийн гэрээнд тусгасан байна.

24.4.Тусгай зориулалтын төмөр зам нь өмчийн аль ч хэлбэртэй байж болно.

**25 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ**

25.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:

25.1.1.галт тэрэгний хөдөлгөөнийг диспетчерийн удирдлагаар хангах;

25.1.2.хөдлөх бүрэлдэхүүнийг сэлгэх, найруулах;

25.1.3.хөдлөх бүрэлдэхүүнд зэхэлт /эрчим хүч, түлш, шатахуун, ус, хийгээр хангах/ хийх;

25.1.4.хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг, үйлчилгээ хийх;

25.1.5.аюултай, овор ихтэй, хамгаалалттай ачаатай хөдлөх бүрэлдэхүүн, хүнд жинтэй болон урт бүрэлдэхүүнтэй галт тэргэнд хяналт тавих;

25.1.6.галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл солилцох, хангах;

25.1.7.төмөр замын тээврийн ашиглалттай холбоотой дохиолол холбоо, мэдээлэл, сүлжээ, програм хангамжаар хангах.

**26 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд тавигдах шаардлага**

26.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд дараах шаардлага тавигдана:

26.1.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, техникийн баримт бичиг, стандартын шаардлагад нийцсэн байна.

26.1.2.Суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид хоорондоо энэ хуулийн 10.2.6-т заасан галт тэрэг чөлөөтэй нэвтрүүлэхэд чиглэгдсэн тээвэрлэлттэй холбоотой нөхцөлийг тусгасан гэрээ байгуулсан байна.

26.1.3.Суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь хөдлөх бүрэлдэхүүний эргэлтийг зохион байгуулах, засвар үйлчилгээ болон тээвэрлэлттэй холбоотой харилцааг зохицуулсан суурь бүтцийн үйлчилгээний гэрээ байгуулсан байна.

26.1.4.энэ хуулийн 26.1.2, 26.1.3-т заасан гэрээний үлгэрчилсэн загварыг энэ хуулийн 11.1.19-т заасан журмаар батална.

26.1.5.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвтэй байна.

26.1.6.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тухайн суурь бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн өргөтгөл, шинэчлэлийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хөтөлбөрийг агуулсан дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй байна.

26.2.Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, нэгдсэн технологийн горимыг энэ хуулийн 11.1.9-т заасан журмаар зохицуулна.

26.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь суурь бүтцийн үйлчилгээг тэгш эрхийн зарчмыг баримтлан гэрээний үндсэн дээр нийтэд үзүүлнэ.

26.4.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах, аливаа этгээдэд давуу байдал олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд саад учруулах, өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглоно.

26.5.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байна.

**27 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг**

27.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхтэй:

27.1.1.төмөр замын суурь бүтцийн төлбөртэй үйлчилгээ үзүүлэх;

27.1.2.өөрийн төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг батлах, хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал өгөх;

27.1.3.тээвэрлэгчийн тээвэрлэлтийн технологи, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, техникийн байдал нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахгүй, суурь бүтцийн хүчин чадлаас хэтэрсэн тохиолдолд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

27.1.4.энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн дотооддоо үйлчлэх техник, технологийн дүрэм, журам, зааврыг баталж мөрдүүлэх;

27.1.5.өөрийн төмөр замын суурь бүтцийг шинэчлэх, засварлах, өргөтгөх ажлыг гүйцэтгэх зорилгоор галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарлах, түр хаах эрхтэй.

27.2.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэгтэй:

27.2.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, холбогдох бусад хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартыг дагаж мөрдөх;

27.2.2.энэ хуулийн 26.1.2, 26.1.3-т заасан гэрээ байгуулах;

27.2.3.галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмагт нийцүүлэн зохион байгуулах;

27.2.4.салбар зам эзэмшигчтэй гэрээ байгуулж, сэлгээний хөдөлгөөнийг зохион байгуулах;

27.2.5.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;

27.2.6.төмөр замын аюулгүй байдал, тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа хангах;

27.2.7.энэ хуулийн 11.1.16-д заасан журмын дагуу шаардлагатай мэдээ, тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

27.2.8.энэ хуулийн 27.1.5-т заасан галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарласан, түр хаасан тохиолдолд нийтэд мэдээлэх;

27.2.9.тусгай зориулалтын төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үндсэн дээр суурь бүтцийн үйлчилгээг нийтэд үзүүлэх.

27.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандарт, тохирлын үнэлгээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих эрх бүхий нэгжтэй байна.

**28 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн хувийн хэрэг**

28.1.Төмөр замын суурь бүтэц нь гүйцэтгэлийн зураг, төсөл, төсөв, барилгын ил, далд ажлын акт, суурь бүтэц барих ажлын явцын баримт бичиг, чанарт холбогдох эрх бүхий байгууллагын акт, дүгнэлт, магадлалын ерөнхий дүгнэлт, ашиглалтад хүлээлгэн өгсөн баримт бичгээс бүрдсэн хувийн хэрэгтэй байна.

28.2.Төмөр замын суурь бүтэц өмчлөгч суурь бүтцийн хувийн хэргийг төмөр замын тээврийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

**29 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийн хөдөлгөөнийг хаах, нээх**

29.1.Төмөр замын суурь бүтцийн хөдөлгөөнийг хаах, нээх асуудлыг энэ хуулийн 11.1.19-д заасан журмаар зохицуулна.

29.2.Олон улсын тээвэрт төмөр замын чиглэлийг нээх, хаах асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

**30 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах**

30.1.Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах ажлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

**31 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийг бусад дэд бүтэц, байгууламжтай уялдуулах**

31.1.Төмөр замын суурь бүтцийг шинээр барих, шинэчлэн сайжруулахад авто зам болон бусад төрлийн суурь бүтэцтэй ижил түвшинд огтлолцуулахгүй, ашиглаж буй төмөр замын суурь бүтцийн чиг, хэвгийг өөрчлөхгүй байх зарчим баримтална.

31.2.Төмөр замын суурь бүтэц нь бусад дэд бүтэцтэй огтлолцох тохиолдолд төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

31.3.Төмөр замын зориулалттай газарт баригдах хий, газрын тос дамжуулах хоолой, инженерийн шугам сүлжээ, авто зам, барилга байгууламж нь төмөр замын сүлжээний төлөвлөлттэй уялдсан байна.

**32 дугаар зүйл.Салбар зам**

32.1.Салбар замын үйлчилгээнд ачилт буулгалтын зам, талбайд хөдлөх бүрэлдэхүүн татах, тавих, сэлгээний ажил хийх, ачаа, чингэлэг ачих, буулгах, шилжүүлэх, хадгалах зэрэг үйл ажиллагаа хамаарна.

32.2.Салбар замтай холбоотой харилцааг 11.1.19-т заасан журмаар зохицуулна.

32.3.Салбар замын холболтын цэгийг төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

32.4.Салбар зам, түүний байгууламж, тоноглол, ачаа ачих, буулгах зам, талбай нь галт тэрэгний хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага, холбогдох төмөр замын тээврийн дүрэм, журам техникийн баримт бичиг, норм, стандартын шаардлагыг хангасан байна.

32.5.Салбар зам эзэмшигч болон төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хоорондын харилцааг тэдгээрийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

32.6.Салбар зам нь зам болон ачих, буулгах тоног төхөөрөмжийн техникийн паспорт, замын дагуу огтлолцлын гүйцэтгэлийн зураг, хиймэл төхөөрөмжийн зураг, эрх бүхий байгууллагын дүгнэлт, байнгын ашиглалтад хүлээж авсан болон ашиглалтын явцын засвар үйлчилгээний талаарх бичиг баримтаас бүрдсэн хувийн хэрэг хөтөлнө.

32.7.Салбар зам өмчлөгч, эзэмшигч нь хүн, хуулийн этгээдэд салбар замын үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүй татгалзах, өөрийн салбар замаар дамжин холбогдож байгаа бусад салбар зам эзэмшигчийн үйл ажиллагаанд саад учруулах, давуу байдал олгохыг хориглоно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

### 33 дугаар зүйл. Төмөр замын тээвэрлэлтийн төрөл

33.1.Төмөр замын тээвэрлэлт дараах төрөлтэй байна:

33.1.1.зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт;
33.1.2.ачаа тээвэрлэлт;
33.1.3.тусгай тээвэрлэлт.

33.2.Төмөр замаар зорчигч тээвэрлэх харилцааг энэ хуулийн 11.1.3-т заасан, ачаа тээвэрлэх харилцааг энэ хуулийн 11.1.2-т заасан дүрмээр, тусгай тээвэрлэлт хийх харилцааг энэ хуулийн 11.1.22-т заасан журмаар тус тус зохицуулна.

### 34 дүгээр зүйл.Тээвэрлэгчид тавигдах шаардлага

34.1.Тээвэрлэгч нь дараах шаардлагыг хангасан байна.

34.1.1.төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;

34.1.2.зүтгүүртэй байх;
34.1.3.вагонтой байх;
34.1.4.салбар замтай байх;
34.1.5.засвар, үйлчилгээний газартай байх;

34.2.Тээвэрлэгч нь энэ хуулийн 34.1.2, 34.1.4, 34.1.5-т заасныг түрээсийн эсхүл ашиглалтын гэрээгээр хэрэгжүүлж болно.

34.3.Тээвэрлэгч нь гэрээний дагуу суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн ашиглах, тээвэрлэлтийг зохион байгуулах эрхтэй.

34.4.Тээвэрлэгч нь энэ хуулийн 26.1.3-т заасан суурь бүтцийн үйлчилгээний гэрээ байгуулах, хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон ашиглалтын аюулгүй байдлыг хангах, шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх зорилгоор хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгохгүй байх үүрэгтэй.

34.5.Тээвэрлэгч нь төмөр замын ачаа эргэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх дунд хугацааны төлөвлөгөөтэй байна.

34.6.Тээвэрлэгч нь өөрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандарт, тохирлын үнэлгээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих эрх бүхий нэгжтэй байна.

34.7.Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад ачаа илгээгч, хүлээн авагчийн зөвшөөрөлгүй хаяг солихыг хориглоно.

34.8.Тээвэрлэгч нь энэ хууль болон төмөр замын тээврийн дүрэм, журамд зааснаас бусад үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

34.9.Тээвэрлэгч нь ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хүн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн вагоныг зөвшөөрөлгүй тээвэрлэлтэд ашиглахыг хориглоно.

**35 дугаар зүйл.Тээвэрлэлтийн явцад үүссэн хохирол барагдуулах**

35.1.Төмөр замын тээвэрлэлтийн явцад үүссэн хохирол барагдуулах, түүнтэй холбоотой маргааныг Иргэний хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам болон гэрээгээр зохицуулна.

**36 дугаар зүйл.Тээврийн акт тогтоох**

36.1.Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад ачаа дутах, гэмтэх, муудах тохиолдолд ачаа илгээгч, ачаа хүлээн авагчтай хамтран бодит хохирлын хэмжээг тээврийн актаар тогтооно.

36.2.Энэ хуулийн 36.1-д зааснаас бусад тохиолдолд тээвэрлэгчийн тээврийн акт тогтоох ажиллагаанд хөндлөнгийн этгээдийг оролцуулж болно.

36.3.Тээвэрлэгчийн тээврийн актын загвар, түүнийг үйлдэх зааврыг энэ хуулийн 11.1.2, 11.1.3-т заасан дүрмээр тогтооно.

36.4.Тээвэрлэгч дараах нөхцөлд ачаа, тээш, ачаан тээшийг олгох үед тээврийн акт тогтооно:

36.4.1.тээвэрлэлтийн бичиг баримтад заасан жин, байрын тоо, нэр зөрсөн;

36.4.2.ачаа, тээш, ачаан тээш гэмтсэн, муудсан, үрэгдсэн;

36.4.3.бичиг баримтгүй ачаа, тээш, ачаан тээш илэрсэн;

36.4.4.ачаа, тээш, ачаан тээшгүй тээвэрлэлтийн бичиг баримт илэрсэн;

36.4.5.хулгайлагдсан ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэгчид буцаан өгсөн;

36.4.6.хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгээс ачаа олгох бичиг баримт үйлдсэнээс хойш 24 цагийн дотор тээвэрлэгч ачааг буулгалтын замд тавиагүй тохиолдолд ачаа хүлээн авагчийн шаардлагаар.

**37 дугаар зүйл.Тусгай тээвэрлэлт**

37.1.Тусгай тээвэрлэлтэд цэргийн, онцгой нөхцөл байдлын үеийн тээвэрлэлт хамаарна.

37.2.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан онцгой нөхцөл байдал үүссэн үед Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

**38 дугаар зүйл.Аюултай ачааны тээвэрлэлт**

38.1.Төмөр замаар аюултай ачааг тээвэрлэлтэд бэлтгэх, ачих, тээвэрлэх, буулгах, шилжүүлэх, хадгалах үйл ажиллагааг энэ хуулийн 11.1.23-т заасан журмаар зохицуулна.

38.2.Аюултай ачааны ачилт, буулгалт хийх зориулалттай өртөөг сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллага тодорхойлно.

38.3.Аюултай ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг зориулалтын тоног төхөөрөмж бүхий зам, талбайд стандартын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

38.4.Зорчигчийн галт тэргэнд аюултай ачаа биедээ авч явахыг хориглоно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН

**39 дүгээр зүйл.Хөдлөх бүрэлдэхүүнд тавигдах шаардлага**

39.1.Хөдлөх бүрэлдэхүүн нь төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн зохицуулалт, норм, стандартад нийцсэн байна.

39.2.Хөдлөх бүрэлдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлж, дугаар, гэрчилгээ авсан байна.

39.3.Хөдлөх бүрэлдэхүүн нь технологийн болон хөдөлгөөний хяналтын системд холбогдох боломжоор хангагдсан байна.

39.4.Хөдлөх бүрэлдэхүүн нь тогтоосон хугацаанд засвар, үйлчилгээнд хамрагдсан байна.

39.5.Хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах ажлыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

39.6.Энэ хуулийн 39.5-д заасан эрх бүхий этгээд нь хийсэн засвар, үйлчилгээндээ чанарын баталгаа гаргана.

**40 дүгээр зүйл.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүрэг**

40.1.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь хөдлөх бүрэлдэхүүнийг гэрээний үндсэн дээр тээвэрлэгчид ашиглуулах, тээвэрлэлтийн ажлын технологи, төмөр замын суурь бүтцийн техникийн байдал нь хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд сөргөөр нөлөөлөх бол үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

40.2.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хөдлөх бүрэлдэхүүнд засвар, техникийн үйлчилгээ хийх үүрэгтэй.

40.3.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглаагүй үед байрлуулах өөрийн эзэмшлийн болон түрээсээр ашиглах салбар замтай байна.

**41 дүгээр зүйл.Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт**

41.1.Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой харилцааг энэ хуулийн 11.1.11-т заасан журмаар зохицуулна.

41.2.Хөдлөх бүрэлдэхүүний хийц бүтээцийг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй өөрчлөхийг хориглоно.

## НАЙМДУГААР БҮЛЭГ
## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**42 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах**

42.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдал нь төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, зорчигч аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, ачаа, тээш, ачаан тээшийг бүрэн бүтэн тээвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

42.2.Төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомж, төмөр замын дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартын хэрэгжилт болон төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулна.

42.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь байгалийн гамшиг, төмөр замын аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, суурь бүтцийг сэргээн босгох зориулалтын машин механизм, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, материалын нөөцийг бүрдүүлсэн байна.

42.4.Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам эзэмшигч нь хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түргэн шуурхай хэрэгжүүлнэ.

42.5.Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

42.6.Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

42.6.1.зорчигч аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;
42.6.2.галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
42.6.3.ачааг аюулгүй, бүрэн бүтэн, найдвартай тээвэрлэх;
42.6.4.төмөр замын тээврийн байгууллагын ажилтны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

42.6.5.хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй ажиллах.

42.7.Төмөр замын суурь бүтцийг эрчим хүчээр тасалдалгүй хангах онцгой объект гэж үзнэ.

**43 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын шаардлага**

43.1.Төмөр замын суурь бүтэц, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгсэл нь энэ хууль болон төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, стандарт, норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байна.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шаардлагыг хангаагүй суурь бүтэц, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгслийг ашиглахыг хориглоно.

43.3.Төмөр замын зориулалтын гарам, гарцгүй газраар нэвтрэх, зурвас газарт мал бэлчээхийг хориглоно.

43.4.Төмөр замын гармын аюулгүй байдлыг төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон салбар зам эзэмшигч хариуцна.

43.5.Төмөр замын тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах харилцааг энэ хуулийн 11.1.15-д заасан журмаар зохицуулна.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАРИФ, ДААТГАЛ

**44 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тариф**

44.1.Төмөр замын тээврийн байгууллага нь энэ хуулийн 11.1.20-т заасан аргачлалын дагуу тариф тогтооно.

44.2.Төмөр замын тээврийн байгууллага нь Өрсөлдөөний тухай хуулийн 6.1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн

төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн тарифт өөрчлөлт оруулахыг хориглоно.

44.3.Тарифын өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

44.4.Төмөр замын тээврийн байгууллага нь зорчигч болон ачаа тээврийн тарифыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр мөрдөхийг хориглоно.

**45 дугаар зүйл.Төмөр замын тээврийн даатгал**

45.1.Төмөр замын тээврийн байгууллага нь дараах ажилтныг гэнэтийн ослын даатгалд заавал хамруулна:

45.1.1.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой;
45.1.2.төмөр замын аюултай бүсэд ажилладаг;
45.1.3.галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцэд хяналт, шалгалт хийдэг;
45.1.4.төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг турших, оношлох ажилд оролцдог.

45.2.Энэ хуулийн 45.1-т заасан даатгалын зардлыг ажил олгогч хариуцна.
45.3.Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг, төмөр замаар тээвэрлэх ачааг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу даатгалд хамруулж болно.

## АРАВДУГААР БҮЛЭГ
## ТӨМӨР ЗАМЫН АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

**46 дугаар зүйл.Төмөр замын тээврийн байгууллагын ажилтны хөдөлмөрийн харилцаа**

46.1.Төмөр замын тээврийн салбарын ажилтныг ажил, чиг үүргээс нь хамааруулан галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд ба шууд бус холбоотой гэж ангилах бөгөөд ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцөлийг энэ хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон энэ хуулийн 11.1.13-т заасан журмаар зохицуулна.

46.2.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан ажилд анх орохдоо эмнэлгийн урьдчилсан үзлэгт, ажил гүйцэтгэх явцад хугацаат үзлэгт хамрагдах үүрэгтэй.

46.3.Төмөр замын ажилтан дүрэмт хувцас хэрэглэх бөгөөд энэ хуулийн 11.1.18-т заасан журмаар зохицуулна.

**47 дугаар зүйл.Ажилтны нийгмийн баталгаа**

47.1.Төмөр замын тээврийн байгууллагын ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

47.1.1.төмөр замын тээврийн байгууллагад 25 болон түүнээс дээш жил ажилласан эрэгтэй, 20 болон түүнээс дээш жил ажилласан эмэгтэй ажилтан төмөр замын тээврийн байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол арваас доошгүй сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;

47.1.2.энэ хуулийн 47.1.1-д заасан нийгмийн баталгаатай холбогдон гарах зардлыг ажил олгогч хариуцах бөгөөд буцалтгүй тэтгэмж олгох асуудлыг тухайн төмөр замын тээврийн байгууллага дотоод журмаар зохицуулах;

47.2.Төмөр замын ажилтанг мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг дээшлүүлэхэд ажил олгогч дэмжлэг үзүүлж болно.

## АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД

### 48 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

48.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

48.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### 49 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

49.1.Энэ хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/14.10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хууль зөрчих**

"1.Төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсан үйл явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй буюу зохих ёсоор аваагүй, мэдээлээгүй, ангиллыг буруу тогтоосон, сэргээн босгох, шинжлэн шалгах үйл ажиллагаанд саад учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Төмөр замын тээврийн талаарх олон улсын гэрээг зөрчсөн бол буруутай этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд заасныг зөрчиж:

3.1.Төмөр замын тусгай бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, үйл ажиллагаа явуулсан, галт тэрэгний хөдөлгөөнийг саатуулсан, зогсоосон, хөдлөх бүрэлдэхүүний дээвэр, гишгүүр дээр зорчсон, төмөр зам дээр эд зүйл байрлуулсан, мал, ердийн хөсөг, тээврийн хэрэгслийг төмөр замын гарамгүй гарцаар гаргасан;

3.2.төмөр замын тээврийн зориулалттай газарт мал бэлчээсэн, төмөр замын тээвэрт холбогдолгүй ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн, зориулалтын бус барилга, байгууламж барьсан, Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх ачиж, буулгах, хадгалах журмыг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хуулиар хориглосон төмөр замын суурь бүтэц, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, технологийг төмөр замын тээвэрт ашигласан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам эзэмшигч нь бусдын үйл ажиллагаанд саад учруулсан бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Тээвэрлэгч нь бусдын эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээвэрт ашигласан, ачилтад авсан бол учруулсан хохирол, нөхөн

төлбөрийг гаргуулж хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Төмөр замын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа эрхлэхдээ:

7.1.тусгай зөвшөөрөлгүй;
7.2.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангаагүй;
7.3.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8. Төмөр замын тээврийн тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар сарын ...-ний өдөр | Улаанбаатар хот

## УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/29 дүгээр зүйлийн 29.1.12 дахь заалт**

“29.1.12.төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах болон техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгоход тус тус 5.000.000 төгрөг;”

**2 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт**

“29.1.1.төмөр замын суурь бүтэц барих болон ашиглах тусгай зөвшөөрөл олгоход тус тус 16.000.000 төгрөг;”

**2/29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт**

“29.1.2.төмөр замын суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тус тус 5.000.000 төгрөг.”

“29.1.3.төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 16 000 000 төгрөг;

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт дор дурдсан заалтыг тус тус нэмсүгэй:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 5.12.төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.13.төмөр замын техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

**2 дугаар зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.4 дэх заалтын “хөдлөх бүрэлдэхүүнийг” гэснийг “хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг” гэж, мөн зүйлийн 5.7 дахь заалтын “тээвэрлэлтийн” гэснийг “тээвэрлэгчийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20.... оны ... дугаар сарын ...-ний өдөр | Улаанбаатар хот

**АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Авто замын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.1.8 дахь заалтын “төмөр зам” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтын “төмөр зам” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дүрэм, журам, норм, стандарт, аргачлалыг боловсруулж, батлах, хууль тогтоомжийг сурталчлах, бүтэц орон тоо батлуулах, удирдлага зохион байгуулалтын болон техник хэрэгсэл, санхүү, эдийн засгийн холбогдох арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулна.

**2 дугаар зүйл.**Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгосон суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл нь зөвшөөрөлд заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

**3 дугаар зүйл.**Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгосон төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд олгосон гэрчилгээ нь гэрчилгээнд заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

**4 дүгээр зүйл.**Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тусгай зөвшөөрөл, гэрчилгээ хүссэн шилжилтийн үеийн хүсэлтийг Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу шийдвэрлэнэ.

**5 дугаар зүйл.**Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг 2024 оны улсын төсөвт тусгаж шийдвэрлэнэ.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төмөр замын тээврийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

# ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

## Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

2022 он

Улаанбаатар хот

# ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**2022.12.10** Улаанбаатар хот

## УДИРТГАЛ ХЭСЭГ

Төмөр замын тээврийн тухай хууль 2007 оноос өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэдий ч энэхүү 15 жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид олноор бий болж, салбарын үйл ажиллагаа өргөжин хөгжих тусам хуулиар зохицуулах шаардлагатай олон асуудал, хүндрэл гарч байгаа тул салбарын эрх зүйн орчныг сайжруулах, шинэчлэх шаардлага зүй ёсоор бий болсон.

Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

## 1. ЗОРИЛГО:

Төмөр замын тээврийн тухай хууль нь хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 15 жил болохдоо эрх зүйн шинэчлэлт, сайжруулалт хийгдээгүй, тус хуулийн зорилт нь “төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлон тусгасан. Энэхүү хуулиар зөвхөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зарим харилцааг зохицуулж ирсэн. Монгол Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой тус салбарт өмчийн олон хэлбэрийн суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид олноор бий болж, олон талт харилцаа болон үйл ажиллагаа өргөжихийн хирээр эдгээрийг хуулиар зохицуулах шаардлагатай асуудлууд үүсч, тухайн хуулийн зохицуулалт нь цаг үетэйгээ нийцэхгүй зэрэг хүндрэлүүд гарч байгаа тул салбарын эрх зүйн орчныг сайжруулах, шинэчлэх шаардлага зүй ёсоор бий болоод байна.

Иймд төмөр замын тээврийн тухай хуульд тээвэрлэлтийн үйл ажиллагаа, төмөр замын дэд бүтцийн ангилал, өмчлөл, барьж ашиглах, зурвас газрын эзэмшил, төрийн захиргааны байгууллага байгуулах, төмөр замын барилгын ажлыг ашиглалтад оруулах, судалгаа шинжилгээнд суурилсан дэвшилтэд техник, технологи, засвар, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдмэл удирдлагаар зохицуулах, осол гологдлыг судлан шинжлэн тогтоох харилцааг шинээр томьёолон зохицуулах шаардлагатай болсон.

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасан “...хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, давхардал, хийдэл, нийгэмд үзүүлж байгаа сөрөг байдал болон зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох” гэж заасан, МУ-ын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний цогц бодлого”-ын 5.3.1.1-д заасан “Зам, тээврийн салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд “Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох эрх зүйн баримт бичгийг хянан сайжруулах” гэж заасан.

Энэхүү үндэслэл, шаардлагын хүрээнд хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6

дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, давхардал, хийдэл, нийгэмд үзүүлж байгаа сөрөг байдал болон зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбар зэргийг тодорхойлон зөвлөмж гаргах”-аар үнэлгээг хийхдээ “Төлөвлөх”, “Хэрэгжүүлэх”, “Үнэлэх” гэсэн гурван шаттайгаар гүйцэтгэв.

## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах алхмуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- Харьцуулах хэлбэрийг сонгох
- Шалгуур үзүүлэлтийг томьёолох
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

### а. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага:

Төмөр замын тээврийн тухай хууль батлагдснаас хойш 15 жилийн хугацаанд нийт 3 удаа буюу 2012 онд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй, 2015 онд Зөрчлийн тухай хууль батлагдсантай, 2017 онд Гамшгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон болович төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож чадаагүй болно.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 5.1-д “Бодлогод заасан зорилтыг хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрэхийн тулд түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ”, 5.2-т “Төмөр замын тээврийн салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааны харилцааг хуульчлах замаар төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчныг сайжруулна”, 5.3-т “Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байж болох бөгөөд өмчийн олон төрөл, хэлбэрийн тээвэрлэгч бий болох орчин, нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Өнгөрсөн хугацаанд уг хуулийн зохицуулалт нь төрийн бодлого шийдвэр, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төмөр замын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг хөгжлийн шинэ шатанд гаргах, салбарт төр, хувийн хэвшлийн харилцааг зохицуулах, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтыг хийхэд учир дутагдалтай байснаас гадна уг хуулиар зохицуулж буй харилцаа нь салбарын хөгжлөөс хоцрох хандлага ажиглагдаж, түүнээс улбаалсан сөрөг үр дагавар гарах болсон тул хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн.

Өөрөөр хэлбэл, Төмөр замын тээврийн тухай хуулиар суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг шинэчлэн сайжруулах, тээврийн сүлжээг өргөжүүлэх, үйлдвэрлэл, судалгаа, шинжилгээ болон олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг тогтмол хангах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зохицуулалт, төмөр замын тээврийн үйлчилгээнд оролцогч өмчийн олон хэлбэрийн хуулийн этгээдийн зах зээлийн өрсөлдөөний тэгш байдлыг хангуулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг бататгах бизнесийн эрх зүйн орчинг бүрдүүлэх зүй ёсны шаардлага гарсан.

Эндээс үзэхэд "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын 3.2.2-т заасан зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй гэсэн шалтгаан, үндэслэлийг хангасан гэж үзэж байна. Иймд тус үнэлгээг үргэлжлүүлэн хийв.

**b. Үнэлгээ хийх хүрээ:**

Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь тус хуулийг бүхэлд нь хамарч байгаа хэдий ч Төмөр замын тээврийн салбарын байгууллагууд, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, ажилтан, албан хаагчдын төлөөлөл, судлаач, эрдэмтэд, үйлчлүүлэгчдийн төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагын тэмдэглэл, тэдний санал, хүсэлтийг судлан үзээд үнэлгээний хүрээг Төмөр замын тээврийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн 1, 4, 6, 7 дугаар зүйлийг хамруулан тодорхойлсон.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-д заасан үнэлгээний шалгуураас дараах 2 үзүүлэлтийг сонгосон. Үүнд:

1. Зорилгод хүрсэн төвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

**Нэгдүгээр хүснэгт**

**Төмөр замын тээврийн тухай хуульд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн ялгаа, онцог**

| Д/д | Шалгуур | Ойлголт, онцлог | Жишээ тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Зорилгод хүрсэн төвшин | Тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно. | Төмөр замын тээврийн тухай хуулийн үндсэн зорилгыг "төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлсон боловч хуулийн зорилгыг хуульчлаагүй. Төмөр замын тээврийн тухай хуулийг бүхэлдээ болон сонгосон зохицуулалтаар зорилгодоо хүрч чадсан эсэхийг үнэлэх шаардлагатай. Хуульд үндсэн зорилгоос гадна бүлэг, хэсэг, зүйл бүрт тодорхойлсон дагалдах зорилго байж болох бөгөөд үүнийг давхар шалгаж болно. |
| 2 | Практикт нийцэж байгаа байдал | Хуулийг хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно. | Төмөр замын тээврийн тухай хуулийн ойлгомжтой байдал, хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэх зэргийг тодорхойлно. |

**Төмөр замын тээврийн хуульд үнэлгээ хийсэн шалгуур үзүүлэлтүүд**

- ***Зорилгод хүрсэн төвшин*** шалгуур үзүүлэлтээр Төмөр замын тээврийн тухай хуулийн 1, 4, 6, 7 дугаар зүйлийн зохицуулалтын зорилго болон зорилтдоо хүрсэн түвшинг үнэлж, эдгээр зүйлийн зохицуулалт хангалттай үйлчилж чадаж байна уу, үгүй юу гэдгийг тодорхойлоход чиглэгдсэн болно.

- ***Практикт нийцэж байгаа байдал*** шалгуур үзүүлэлтээр Төмөр замын тээврийн тухай хуулийн 1, 4, 6, 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд үүсч буй эерэг, сөрөг үр дагавар, хүндрэл бэрхшээл, хэрэгжүүлэх боломж, бололцоо практикт байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгдсэн болно.

▪ **Үнэлгээний харьцуулах хэлбэр**

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно:

- ▪ Байх ёстой болон одоо байгаа;
- o Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойшхи;
- ▪ Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи;
- ▪ Тохиолдол судлах.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 1, 4, 6, 7 дугаар зүйлийг Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш болон Тохиолдол судлах хэлбэрээр харьцуулан үнэлнэ.

Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш харьцуулах хэлбэрийн хүрээнд Төмөр замын тээврийн тухай хуулийн зорилт, энэхүү хуулиар тээвэрлэлтийн тариф, хөлс тогтоох, обьектын өмчлөл, төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн, энэ хугацаанд эрх зүйн орчин сайжирсан эсэхийг тогтооно.

**Хоёрдугаар хүснэгт**

**Харьцуулах хэлбэр тус бүрийн онцлог**

| Д/д | Харьцуулах хэлбэр | Ойлголт, онцлог |
|---|---|---|
| 1 | Байх ёстой болон одоо байгаа | Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна. |
| 2 | Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш | Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараа буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна. |
| 3 | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдснийг он дараалалаар тогтоон харьцуулна. |
| 4 | Тохиолдол судлах | Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна. |

Тохиолдол судлах хэлбэрийн хүрээнд сонгон авсан зохицуулалтыг “Олон улсын төмөр замын ОХУ, Казкастан Улс, БНХАУ, Польш, Молдов Улсад хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар харьцуулж, дүн шинжилгээ хийнэ.

**Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

***Хуулийн нэгдүгээр зүйл: Хуулийн зорилт***

- Хуулийн нэгдүгээр зүйл буюу хуулийн зорилт нь хангалттай түвшинд зохицуулагдсан эсэхийг тодорхойлно.
- Хуулийн дөрөвдүгээр зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээ зорилгодоо хэрхэн хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.
- Хуулийн зургадугаар зүйл буюу Төмөр замын обьектын өмчлөлтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хэрхэн хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.
- Хуулийн долоодугаар зүйл буюу Төмөр замын тээврийн тариф, хөлсийг тогтоох зохицуулалт зорилгодоо хэрхэн хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.

**Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

- Хуулийн нэгдүгээр зүйл буюу хуулийн зорилт нь практикт нийцэж байна уу, хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.
- Хуулийн дөрөвдүгээр зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээ практикт нийцэж байна уу, үйлчлэх хүрээг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.
- Хуулийн зургадугаар зүйл буюу Төмөр замын обьектын өмчлөлтэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байна уу, өмчлөлийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.
- Хуулийн долоодугаар зүйл буюу Төмөр замын тээврийн тариф, хөлсийг тогтоох зохицуулалт практикт нийцэж байна уу, тариф тогтоох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

**Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:**

**Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Төмөр замын тээврийн тухай хуультай холбогдон гарсан статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг, өгүүлэл төмөр замын тээврийн салбарт эхлүүлсэн томоохон төслүүдийн хэрэгжилтийн явцын мэдээлэл.

**Холбогдох субъектээс судалгаа авах:**
Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч “УБТЗ” ХНН, “МТЗ”ТӨХК, “БТЕГ” ХХК зэрэг суурь бүтэц эзэмшигчид, “ГТХЗНТ” УТҮГ-аас судалгаа авах.

Төлөвлөх үе шатанд хийгдсэн ажлыг гуравдугаар хүснэгтэд үзүүлэв.

Гуравдугаар хүснэгт

## Үнэлгээний үзүүлэлт, хэлбэр, томьёолол

| Д/д | Үнэлгээний хүрээнд | Шалгуур үзүүлэлт | Харьцуулах хэлбэр | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Мэдээлэл цуглуулах арга |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хуулийн нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл **1 дүгээр** зүйл. Хуулийн зорилт | Зорилгод хүрсэн төвшин,<br><br>Практикт нийцэж байгаа байдал | ▪ Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br>▪ Тохиолдол судлах | **Зорилгод хүрсэн төвшин:**<br>хуулийн 1-р зүйлийн зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ?<br><br>**Практикт нийцэж байгаа байдал:**<br>хуулийн зорилт нь практикт нийцэж байна уу, хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно. | ▪ Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах,<br><br>▪ Холбогдох субъектээс судалгаа авах, |
| 2 | **4 дүгээр зүйл.**<br><br>Хуулийн үйлчлэх хүрээ | ▪ Зорилгод хүрсэн түвшин;<br><br>▪ Практикт нийцэж байгаа байдал. | ▪Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br><br>▪Тохиолдол судлах | **Зорилгод хүрсэн төвшин**: хуулийн үйлчлэх хүрээ зорилгодоо хэрхэн хүрсэн эсэх.<br><br>**Практикт нийцэж байгаа байдал:** хуулийн үйлчлэх хүрээ практикт нийцэж байна уу, үйлчлэх хүрээг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх. | ▪ Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах,<br><br>▪ Холбогдох субъектээс судалгаа авах, |
| 3 | **6 дугаар зүйл.**<br><br>Төмөр замын обьектын өмчлөл | Зорилгод хүрсэн төвшин;<br><br>▪ Практикт нийцэж байгаа байдал.<br>▪ | ▪Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br><br>▪Тохиолдол судлах, | **Зорилгод хүрсэн төвшин**:<br>▪ Төмөр замын обьектын өмчлөлтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хэрхэн хүрсэн эсэх<br><br>**Практикт нийцэж байгаа байдал**:<br>▪ Төмөр замын обьектын өмчлөлтэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа | ▪ Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах,<br><br>▪ Холбогдох субьектээс судалгаа авах, |
| 4 | **7 дугаар зүйл.**<br><br>Төмөр замын тээврийн тариф, хөлс | ▪ Прак-тикт нийцэж байгаа байдал.<br>▪ Зорилгод хүрсэн төвшин; | ▪Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br><br>▪Тохиолдол судлах, | **Зорилгод хүрсэн төвшин:**<br>Төмөр замын тээврийн тариф, хөлс тогтоох зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх<br>**Практикт нийцэж байгаа байдал**:<br>Төмөр замын тээврийн тариф, хөлс тогтоох зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх | ▪ Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах,<br><br>▪ Холбогдох субьектээс судалгаа авах, |

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

### 2.1 Бэлэн байгаа мэдээллийг цуглуулсан тухайд:

#### *2.1.1. Эрх зүйн баримт бичиг*

- Монгол Улсын Үндэс хууль 1992 он;
- Монгол Улсын Иргэний хууль 2002 он (35 дугаар бүлэг, 380-398 дугаар зүйл);
- Төмөр замын тээврийн тухай хууль 2007 он;
- Авто тээврийн тухай хууль 1999 он;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль 2015 он;
- Захиргааны ерөнхий хууль 2015 он;
- Хууль тогтоомжийн тухай хууль 2016 он;
- Авто замын тухай хууль 2017 он;
- Наушкаас Улаанбаатар хүртэл төмөр замыг байгуулж ашиглахын тулд Монгол Зөвлөлтийн хувьцаат нийгэмлэг байгуулах БНМАУ-ын Засгийн газар, ЗХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1948 он;
- Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр 1956 он;
- Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2004 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Украйн улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1995 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1996 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Турк улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2001 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Беларусь улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2003 он;
- Олон Улсын төмөр замын ачаа харилцааны хэлэлцээр 1951 он;
- Олон Улсын төмөр замын зорчигч харилцааны хэлэлцээр 1956 он;
- Монгол Улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Дамжин өнгөрөх журмын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”;
- Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “ Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
- Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “2018 онд Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”.

#### 2.1.2. Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг, өгүүлэлүүд:

- Шүүхийн ерөнхий зөвлөл 2007-2017 онуудад төмөр замын тээврийн хуультай холбоотой асуудлаар иргэн болон эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн статистик судалгаа;

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх хүний эрхийн үндэсний комиссын 10 дахь илтгэл 2011 он 3 дугаар бүлэг;

- Монгол Улсын Их Хурлын даргын 2013 оны 119 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын газар зүйн байрлалын давуу талыг ашиглан төмөр

зам, авто зам, авто тээвэр, агаарын тээврийн дамжин өнгөрөх зорчигч, ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, нэгдсэн тээврийн ложистикийн сүлжээг бий болгох, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгаан дамжуулах шугамын талаар нэгдсэн бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс зохион байгуулсан "Монголын төмөр замын хөгжлийн асуудлууд" эрдэм шинжилгээний бага хурал, "Төмөр замын тээвэр ложистикийн өнөөгийн байдал, цаашдын хөгжил" онол, практикийн бага хурал, "Евро-Азийн тээвэр болон бүс нутгийн оролцоо" олон улсын бага хурлын илтгэлийн хураангуй, "Дамжин өнгөрөх тээвэр-хөгжлийн гарц" илтгэл 2013 он.

- "*Хөгжлийн үр дүнд хүргэх удирдлага*: Төмөр замын суурь бүтцийн тариф-Монгол Улсын төмөр замын салбарт хувийн хэвшлийн төлөвшлийг дэмжих нь" судалгааны тайлан. Азийн хөгжлийн банк 2014 он.

- Монгол Улсын далайд гарах нөхцөл боломжийн талаарх мэдээлэл судалгааны тойм. Далайн захиргаа 2017.

- Зам, тээврийн хөгжлийн яам, Шинжлэх ухааны академи хамтран зохион байгуулсан "Төмөр замын тээврийн эрх зүйн орчин, хөгжлийн асуудлууд" сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд, хурлаас гарсан зөвлөмж.

*Холбогдох субъектээс судалгаа авах:* Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч "УБТЗ" ХНН, "МТЗ"ТӨХК, "Таван толгой төмөр зам" ХХК, "БТЕГ" ХХК, "БТЗ" ХХ зэрэг суурь бүтэц эзэмшигчид, "ГТХЗНТ" УТҮГ-ын тайлан, судалгаа.

## ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төмөр замын тээврийн тухай хууль нь 2007 онд батлагдсанаас хойш 15 жил өнгөрчээ. Энэ хугацаанд төмөр замын тээврийн салбарт суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид олноор бий болж салбарын үйл ажиллагаа өргөжих тусам хуулиар зохицуулах шаардлагатай олон харилцаа бий болсон байна.

Уг хуулийн хэрэгжилттэй холбоотой зарим тулгамдсан асуудал Тухайлбал: төмөр замын тээврийн аюулгүй байдал, үйл ажиллагааг хангах зориулалттай эдэлбэр газар, аюулгүйн бүс, зурвас газрыг дур мэдэн эзэмших, ашиглах асуудал гарч байгаа нь төмөр замын зурвас газар, аюултай бүсийн зохицуулалтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

### 3.1 "Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төмөр замын тээврийн тухай хууль нь зорилгыг тодорхойлж зохицуулаагүй зөвхөн зорилт тодорхойлсон хууль болжээ. Хуулийн зорилгыг "Төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" хэмээн уг хуулийн нэгдүгээр зүйлд заасан байна.

**<u>Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1</u>**. Хуулийн нэгдүгээр зүйл буюу хуулийн зорилт нь хангалттай түвшинд зохицуулагдсан уу?

| **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт** |
|---|
| 1.1. Төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |

Уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэгдэх учиртай. Гэвч уг хуулийн зорилт нь төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын

зарчмыг тодорхойлж, зөвхөн хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулахаар тусгасан болов ч, уг хуулиар дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

5-р зүйл: Төмөр замын тээврийн үйл ажиллагааны үндсэн зарчим;
6-р зүйл: Төмөр замын обьектын өмчлөл;
7-р зүйл: Төмөр замын тээврийн тариф, хөлс;
8-17 р зүйл: Төмөр замын тээврийн талаархи төрийн зохицуулалт;
18-р зүйл: Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, иргэн, тэдгээрийн эрх, үүрэг;
22-р зүйл: Төмөр замын обьект;
24-р зүйл: Төмөр замын тээврийн аюулгүй байдлын үндсэн шаардлага;
29-31-р зүйл: Төмөр замын байгууллагын ажилтны хөдөлмөр зохицуулалт, нийгмийн баталгаа;
32-33-р зүйл: Төмөр замын тээврийн зохион байгуулалтын бусад асуудал;
34-р зүйл: Төмөр замын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.** Хуулийн дөрөвдүгээр зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээ зорилгодоо хэр хүрсэн бэ?

| |
|---|
| **4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**<br>4.1. Энэ хуулиар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна. |

Төмөр замын тээврийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд "төмөр замын тээврийн салбарт өмчийн төрөл хэлбэр харгалзахгүйгээр бүх төрлийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулна" гэсэн болов ч тус хуулиар төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадахгүй байна.

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3.** Хуулийн зургадугаар зүйл буюу Төмөр замын обьектын өмчлөлтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хэрхэн хүрсэн бэ?

| |
|---|
| **6 дугаар зүйл. Төмөр замын обьектын өмчлөл**<br>6.1. Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.<br>6.2. Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно.<br>6.3. Төмөр замын зурвас газар болон улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцээс бусад төмөр замын обьект, салбар болон дагнасан хэрэглээний зам нь өмчийн аль ч төрөл, хэлбэрийн байж болно.<br>6.4. Ашиглалтын тодорхой хугацааны дараа суурь бүтцийн тодорхой хувийг энэ хуулийн 6.2-д заасны дагуу төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг суурь бүтэц эзэмшигчтэй тохиролцож, суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөлд тусгана. |

"Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна" гэж тусгасан болов ч төмөр замын шугамын дагуух технологийн онцлог бүхий үйл ажиллагаа явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий газрыг иргэд аж ахуй нэгж байгууллагуудад олгохыг хориглосон зохицуулалт байхгүй.

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4.** Хуулийн долдугаар зүйл буюу Төмөр замын тээврийн тариф, хөлс тогтоох зохицуулалт зорилгодоо хэрхэн хүрсэн бэ?

| |
|---|
| **7 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тариф, хөлс** |

7.1. Төмөр замын байгууллага нь зүй ёсны монопол болон зах зээл дээр давамгайлсан ажил, үйлчилгээтэй холбоотой төмөр замын тээврийн үйлчилгээний хөлс, тарифыг энэ хууль болон Өрсөлдөөний тухай хуульд нийцүүлэн тогтооно.
7.2. Төмөр замын олон улсын тээвэрлэлтийн тарифыг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн тогтооно.
7.3. Тарифын өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

Өнөөдрийн байдлаар Хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам" буюу дан ганц суурь бүтэц эзэмшигч төмөр замын тээврийн үйлчилгээний хөлс, тарифыг тогтоож бусад төмөр замын тээвэрлэлтэд оролцогч иргэн, аж ахуй нэгж байгууллага мөрдөж байна.

***"Практикт нийцэж буй эсэх" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:***
***<u>Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.</u>***

Хуулийн нэгдүгээр зүйл буюу хуулийн зорилт нь практикт нийцэж байна уу, хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**
Төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэгдэх учиртай. Гэвч уг хуулийн зорилт нь төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зарчмыг тодорхойлж, зөвхөн хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулахаар тусгасан байгаа нь учир дутагдалтай байна. Тухайлбал: бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн тасралтгүй, хэвийн, найдвартай ажиллагааг хангах, техник, технологи, засвар, үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах шаардлагатай байна.

***<u>Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2.</u>***
▪ Хуулийн дөрөвдүгээр зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээ практикт нийцэж байна уу, үйлчлэх хүрээг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх.

**4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**
4.1. Энэ хуулиар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна.

Энэхүү дөрөвдүгээр зүйлд "төмөр замын тээвэрлэлтийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна" гэсэн боловч Төмөр замын тээврийн тухай хуульд зөвхөн үйл ажиллагааны зарчим, тээвэрлэлтийн аюулгүй байдлын зарим зохицуулалтыг хуульчилсан.

***<u>Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3.</u>***
▪ Хуулийн зургадугаар зүйл буюу Төмөр замын обьектын өмчлөлтэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байна уу, өмчлөлийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх.

**6 дугаар зүйл.Төмөр замын обьектын өмчлөл**

6.1. Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.
6.2. Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний

өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно.
6.3. Төмөр замын зурвас газар болон улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцээс бусад төмөр замын обьект, салбар болон дагнасан хэрэглээний зам нь өмчийн аль ч төрөл, хэлбэрийн байж болно.
6.4. Ашиглалтын тодорхой хугацааны дараа суурь бүтцийн тодорхой хувийг энэ хуулийн 6.2-д заасны дагуу төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг суурь бүтэц эзэмшигчтэй тохиролцож, суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөлд тусгана.

"Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна" гэж хуульд тусгасан боловч тус газрыг дур мэдэн эзэмших, ашиглах асуудал гарч, төмөр замын зурвас газар, аюултай бүсийг эзэмших ашиглахтай холбоотой маргаан үүсч байна. Хуулийн энэхүү зохицуулалт нь зөвхөн зурвас газар гэж тодорхойлж, аюултай бүсийн талаарх зохицуулалтыг хамтад нь зохицуулаагүйгээс эзэмшил ашиглалтын талаарх маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхэд энэхүү зохицуулалт хангалттай эрх зүйн хамгаалалт болж чадахгүй байна.

***<u>Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4.</u>***
Хуулийн долоодугаар зүйл буюу Төмөр замын тээврийн тариф, хөлсийг тогтоох зохицуулалт практикт нийцэж байна уу, хүндрэл бэрхшээл байгаа эсэх

**7 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тариф, хөлс**

7.1. Төмөр замын байгууллага нь зүй ёсны монопол болон зах зээл дээр давамгайлсан ажил, үйлчилгээтэй холбоотой төмөр замын тээврийн үйлчилгээний хөлс, тарифыг энэ хууль болон Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд нийцүүлэн тогтооно.
7.2. Төмөр замын олон улсын тээвэрлэлтийн тарифыг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн тогтооно.
7.3. Тарифын өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

Уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Төмөр замын байгууллага нь зүй ёсны монопол болон зах зээл дээр давамгайлсан ажил, үйлчилгээтэй холбоотой төмөр замын тээврийн үйлчилгээний хөлс, тарифыг энэ хууль болон Өрсөлдөөний тухай хуульд нийцүүлэн тогтооно" гэсэн зохицуулалт нь практикт нийцэхгүй дараах хүндрэл бэрхшээлийг бүрдүүлж байна. Тухайлбал: Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн үйл ажиллагаа нь МУ-ын болон ОХУ-ын Засгийн газрын хоорондын 1949 оны хэлэлцээрээр зохицуулагддаг бол бусад төмөр замын байгууллагуудын үйл ажиллагаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомжоор зохицуулагддаг нь Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж, төмөр замын тээврийн тариф тогтоох, улмаар шударга өрсөлдөөнийг зохицуулах асуудалд сөргөөр нөлөөлж байна.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Төмөр замын тээврийн тухай хууль дахь сонгосон зүйл, заалтад үнэлгээ хийж гүйцэтгэв. Үнэлгээний төгсгөлд үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт болон үнэлгээнд тулгуурлан хууль тогтоомжийн хүртээмжтэй, үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх талаар зөвлөмж гаргасан болно.

### 4.1 Үнэлгээний дүгнэлт

Төмөр замын тээврийн тухай хуулийн 1, 4, 6, 7 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагазарт "Зорилгод хүрсэн төвшин", "Практикт хэрэгжсэн байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв. Үнэлгээний үр дүнг, зүйл бүрээр дүгнэхэд дараах байдалтай байна.

***1 дүгээр зүйл. Хуулийн зорилт***

**Зорилгод хүрсэн төвшин:**

Хуулийн зорилтод "төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулах" гэж тодорхойлсон нь хөдөлгөөний аюулгүй байдлаас бусад төмөр замын тээврийн салбарын олон харилцааг орхигдуулсан байгаа нь хуулийн зохицуулалтыг өөрчлөн зорилго, зорилтыг тус тусад нь тодорхой тусгах шаардлагатайг илэрхийлж байна. Төмөр замын тээврийн тухай хуульд төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, галт тэргэний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах 123 зүйл заалт буюу нийт заалтын 52,11 %, бусад зохицуулалт нь 40.86%-ийг хамаарч байгаа нь зөвхөн Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг тодорхойлжээ гэж үзэхээр байна.

**Практикт хэрэгжсэн байдал:**

Хуулийн зорилтод "төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулах" гэж тусгасан нь төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль мэт ойлгогдож байна. Төмөр замын тээврийн тухай хууль нь зөвхөн төмөр замын тээврийн харилцааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан тул төмөр салбарыг олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг аюулгүй, чанартай, хүртээмжтэй үйлчилгээгээр хангах, ирээдүйд өсөн нэмэгдэх тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг үр дүнтэй, найдвартай үйлчилгээгээр хангах үр ашигтай тогтолцоог бэхжүүлэх, дамжин өнгөрүүлэх тээврийн чадавхийг дээшлүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилан инноваци болон үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг зорилгыг дэвшүүлж, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

***4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ***

**Зорилгод хүрсэн төвшин:**

Энэхүү дөрөвдүгээр зүйлд "төмөр замын тээвэрлэлтийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна" гэсэн боловч зөвхөн үйл ажиллагааны зарчим, тээвэрлэлтийн аюулгүй байдлын зарим зохицуулалтыг хуульчилсан байгаа нь хуулийн хамрах хүрээнд нийцүүлэн төмөр замын тээвэрлэлтийн бүх төрлийн үйл ажиллагааг нэмж зохицуулах шаардлагатай.

**Практикт хэрэгжсэн байдал:**

Энэхүү 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулиар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна" гэж төмөр замын тээврийн салбарт өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр үйл ажиллаагаа эрхлэх боломжийг бий болгож, төр, аж ахуйн чиг үүргийг заагласан ач холбогдолтой.

Уул уурхай, барилга, бусад салбарын хөгжил эрчимжсэнээр төмөр замын тээврийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, төмөр замын тээврийн салбарт өмчийн олон

хэлбэрийн хуулийн этгээдүүд олноор байгуулагдаж, одоо суурь бүтэц эзэмшигч 3, тээвэрлэгч 3, суурь бүтэц барих, угсрах, засварлах эрх бүхий 62, дагнасан болон салбар зам, талбай эзэмшигч 297, төмөр замын тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэгч 171 зэрэг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд 2007 онд 2800 хөдлөх бүрэлдэхүүнтэй байж, 14,1 сая тн ачаа хоногийн дундаж ачаалал 494 вагон, нэг голд ноогдох, статик даац 51.1тн, ачаа тээвэрлэт 14072.6, ОХУ-65327 вагон, БНХАУ-31126 вагон, зорчигч эргэлт 4410.7, зорчигч тээвэрлэлт 1406 сая зорчигч байв. 2016 онд 8403 хөдлөх бүрэлдэхүүн болж, 19.9 сая тн ачаа тээвэрлэжээ.

Эдгээр тоон үзүүлэлтээс үзэхэд төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогчид болон хөдлөх бүрэлдэхүүний өссөн тоо, хэмжээ, замын нэвтрүүлэх чадварын гүйцэтгэсэн ажлын хэмжээтэй харьцуулахад чанарын өсөлт төдийлөн гараагүйгээс гадна өмчийн олон хэлбэрийн төмөр замын байгууллага, тээврийн үйл ажиллагаанд оролцогчдын харилцааг хангалттай зохицуулж чадахгүй байна.

***6 дугаар зүйл. Төмөр замын обьектын өмчлөл***

**Зорилгод хүрсэн түвшин:**

Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна гэж тусгасан зохицуулалт нь хэт ерөнхий бөгөөд төмөр замын зурвас газрын хэмжээ, аюултай бүсийн эзэмшил, ашиглалттай холбоотой зохицуулалтыг тодорхой хуульчлах шаардлагатай.

**Практикт хэрэгжсэн байдал:**

Мөн хуульд зурвас газрын хэмжээ, аюултай бүсийн дэглэмийг тодорхой тусгаагүйгээс иргэд, аж ахуйн нэгж зурвас газар, аюултай бүсэд газар эзэмших, ашиглах асуудал гарч төмөр замын тээврийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

***7 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тариф, хөлс***

**Зорилгод хүрсэн түвшин:**

Төмөр замын байгууллага нь зүй ёсны монопол болон зах зээл дээр давамгайлсан ажил, үйлчилгээтэй холбоотой төмөр замын тээврийн үйлчилгээний хөлс, тарифыг өөрсдөө тогтоож байгаа нь улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, хэрэглэгчийн ашиг сонирхлыг харгалзсан тарифт үйлчилгээг авахад хүндрэлтэй байна.

**Практикт хэрэгжсэн байдал:**

Монгол Улсын төмөр замын тээврийн салбарт “Улаанбаатар төмөр зам” ХНН монопол байдлаар оршин тогтож, орчин үеийн өндөр бүтээмжтэй ашиглалтын болон шатахууны зардал бага бусад тээвэрлэгчийн зүтгүүрийг гол замаар явуулдаггүй, мөн төр хувийн хэвшлийн вагонууд сул зогсож байхад тээвэрлэлтийн гэрээ хийж явуулах, санал тавихаар зөвшөөрөхгүй эсхүл бага тарифаар явуулах зэрэг бэрхшээлтэй асуудлууд гарч байна. Мөн хөдлөх бүрэлдэхүүний засварын газарт нь төр, хувийн хэвшлийн вагоныг засуулахад өндөр тарифаар тооцдог, тээвэрлэлт хийх тарифын үнэ хатуу зэрэг зөрчил байнга гарч байна.

**4.2 Зөвлөмж**

Үнэлгээний үр дүнд буюу үнэлгээг илэрхийлсэн дүгнэлтэд тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү өндөр хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах санал зөвлөмж гаргаж байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн холбогдох зүйлд хийсэн дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн, ажлын хэсгийн зүгээс Төмөр замын тээврийн тухай хуулийг шинэчлэн найруулах санал гаргаж байна. Түүнчлэн хуулийг шинэчлэн найруулахдаа дараах зохицуулалтыг тусгахыг мөн санал болгож байна. Үүнд:

1.1. Хуулийн зорилгыг тодорхойлох;

1.2. Төмөр замын зурвас газар төрийн өмч байх зайлшгүй шаардлагатай нөхцөлийг тодорхой хуульчлан зохицуулах;

1.3. Төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой төмөр замын дэд бүтцийг төлөвлөх, барих, ашиглах, өмчлөхтэй холбоотой зохицуулалт;

1.4. Төмөр замын салбарыг дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн технологи, бизнесийн өөрчлөлтөд зохицох чадвартай, үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэсэн, хөрөнгө оруулалтад эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон эко системийн тэнцвэртэй байдлын шаардлагыг хангасан эрх зүйн зохицуулалттай болгох;

1.5. Салбарт техникийн шаардлага, стандартчилал, тохирлын үнэлгээ, хяналт бүхий техникийн зохицуулалтын сайн тогтолцоог бий болгох замаар хөгжлийг эрчимжүүлэх, улмаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

1.6. Шинжлэх ухаанч, судалгаа тооцоонд үндэслэгдсэн зөв шийдвэр гарахад жинтэй хувь нэмэр оруулж байсан, салбарын хөгжлийг түүчээлэгч "Тээврийн судалгааны институт"-ын үгүйлэгдэж буй орон зайд салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг эргэн сэргээх, ингэхдээ бодлогын болон технологийн чиглэлээр дагнасан судалгааны институцийн тогтолцоог хуульчлах;

1.7. Төмөр замын салбарын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн бүхий л хүрээнд инновацийн соёлыг нэвтрүүлэх, тэдгээрийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;

1.8. Төрийн байгууллага, албан тушаалтны оролцоо, чиг үүргийг оновчтой зөв хуваарилж журамлах, улмаар тэдгээрийн чиг үүргийн давхцал, хийдэлийг багасгаж, харилцан уялдаа, хуваарилалт бүхий салбарын төрийн зохицуулалтын эрх зүйн орчинг бий болгох;

1.9. Салбарын "шинжлэх ухаан-боловсролын болон шинжлэх ухаан-үйлдвэрлэл-аж ахуй"-н уялдааг тэнцвэртэй хангаж, эдгээрийн тасралтгүй, цогц хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ зах зээлийн хөгжлийн чиг хандлага, эрэлт шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өндөр мэргэшил, чадвартай инженер, судлаач, мэргэжилтэн бэлтгэх зохицуулалт;

1.10. Төмөр замын хөгжлийн төслүүд, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ тэдгээрийн ач холбогдол, үр дүнг эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон эко системийн тэнцвэртэй байдлын шалгууруудыг хэрхэн хангасныг харгалзан үзэж байхтай холбоотой зохицуулалт;

1.11. Салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлогын залгамж чанар, уялдаа холбоог хангуулах, хэрэгжилт, үйл ажиллагааг нь улс төрийн сөрөг нөлөөллөөс ангид байлгах зарчмыг баримтлах талаарх зохицуулалт;

1.12. Төмөр замын үндсэн сүлжээг улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

1.13. Монгол Улс өөрийн газар зүйн байрлалын давуу талаа ашиглан, зах зээлийн бодит хэрэгцээнд суурилсан, тээвэр зуучийн байгууллагуудын оролцоотой транзит тээвэр, логистикийн салбарыг дэмжин хөгжүүлэх зохицуулалт;

1.14. Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөнгөвчлөх, дэмжин хөгжүүлэх зохицуулалт;

1.15. Төмөр зам голлосон бусад тээврийн төрлүүд хосолсон "малтимодал" тээврийг хөгжүүлэх зохицуулалт;

1.16. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг чанартай, хүртээмжтэй үйлчилгээгээр хангахад чиглэсэн маркетингийн цогц үйл ажиллагаанд тулгуурласан бодлого баримтлах талаарх зохицуулалт;

1.17. Тээвэр зуучийн үндэсний чадавхийг бэхжүүлэх, тогтвортой хөгжлийн орчин нөхцлийг бүх талаар дэмжсэн эрх зүйн зохицуулалт;

1.18. Төмөр замын тээврийн хэвийн үйл ажиллагааг хангах, мөн хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, байгаль экологийг тээврийн аюул ослоос хамгаалах зорилго агуулсан төмөр замын аюултай бүс, зурвас газар, аюулгүйн бүсийн халдашгүй байдал, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нь өргөтгөх боломжийг хязгаарлаж болох эрсдлүүдийг тооцсон, эдгээрээс сэргийлсэн, алдагдсан орон зайг нөхөх, эргүүлэн авах боломжийг нээсэн заалтуудыг хуулинд тусгах;

1.19. Төмөр замын суурь бүтэц нь хүчин чадлын дээд хязгаар бүхий хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байхыг хуульчлах;

1.20. Тухайн хуулиар зохицуулах эдийн засаг, нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгаж, хуулийн үйлчлэх хүрээ, төмөр замын салбарын эрх зүйн харилцаанд оролцогч этгээдийн эрх, үүрэг, хариуцлага, төрийн зохицуулалтын хэм хэмжээг нарийвчлан тогтоож тэдгээрийг харгалзан үзэх нөхцөл байдал, түүнийг биелүүлэх журмуудыг боловсронгуй болгох;

1.21. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр зах зээлийн өрсөлдөөнд тэгш байдлаар оролцох бололцоогоор хангах;

1.22. Үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх;

1.23. Тээврийн бусад салбарын уялдаа холбоог оновчтой зохицуулах;

1.24. Тээвэр логистикийн цогц үйлчилгээ бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх;

1.25. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төмөр замын тээврийн тухай хуулийн хоёрдмол утга, өөр хоорондоо зөрчилдсөн утга бүхий зохицуулалтуудыг нэг мөр, ойлгомжтой болгох;

1.26. Салбарын зах зээлд шинэ тутам үүссэн зохицуулалтгүй байгаа дараах асуудлын зохицуулалтыг тусгах:

- Төмөр замын зам, барилгын үйл ажиллагаа болон шинэ бүтээн байгуулалт,
- Техник технологийн шинэчлэлтийн асуудал;
- Үүйлдвэрлэлийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин,
- Улсын хилийн аюулгүй байдал;
- Улсын үндэсний аюулгүй байдлын зохицуулалтын асуудлууд болох хилийн өртөө, хилийн төмөр замууд болон тэдгээрийн удирдлага нь гагцхүү төрийн өмч, удирдлагад байх зарчмыг хангах;
- Цаашид төмөр замын салбарын шинэчлэлтийн хүрээнд эрдэм, шинжилгээний судалгаа, туршилт хийх эрх зүйн орчин;
- Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, нормын баримт бичгийг шинээр буюу шинэчлэн боловсруулах, тэдгээрийг мөрдөж хэрэгжүүлэхтэй холбоотой цогц арга хэмжээг зохион байгуулахад хөрөнгийн эх үүсвэр болох “Сан”-ийн асуудлыг тусгах;
- Төрийн захиргааны байгууллага байгуулах;
- Төмөр замын нийгмийн асуудлыг оновчтой зохицуулах; Төмөр замын салбарын сургалт, мэргэшүүлэх асуудлын эрх зүйн орчинг хуульчлах зэрэг хэрэгцээ, шаардлагатай байна.

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

**Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт:**

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он;
- Төмөр замын тээврийн тухай хууль 2007 он ;
- Хууль тогтоомжийн хууль 2016 он ;
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачла л”
- Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр” /ОУАХХ/;
- Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын зорчигчийн харилцааны хэлэлцээр” /ОУЗХХ/;
- Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын харилцааны зорчигчийн вагон эдэлгээний дүрэм” /ЗВЭД/;
- Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын харилцааны ачааны вагон эдэлгээний дүрэм” /АВЭД/;
- .Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын зорчигчийн галт тэрэгний зурмаг тохирох хурал”-ын протокол;
- Монгол-Оросын хилийн төмөр замын хамтарсан комиссын зөвлөгөөний протокол;
- Монгол-Хятадын хилийн төмөр замын хамтарсан комиссын зөвлөгөөний протокол;
- Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөний протокол;
- Монгол Улсын хилийн төмөр замын өртөөгөөр “Тусгай зориулалтын, олон голт, хүнд даацын, хортой аюултай ачаа тээвэрлэх” дүрэм;
- Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам;
- Төмөр замаар хэтрүү овортой, хүнд жинтэй, урт ачаа тээвэрлэх журам;
- Зорчигчийн галт тэрэг дамжуулах технологийн процесс;
- Хилийн төмөр замын өртөөний нэгдсэн технологийн процесс;
- Хилийн төмөр замын өртөөнд вагонд үзлэг, шалгалт, техникийн үйлчилгээ хийх технологийн процесс;
- Төмөр замын тээврийн салбарт нийтээр дагаж, мөрдөхөөр тогтоосон нийтлэг багц дүрэм, журам;
- Төмөр замын салбарт мөрдөгдөж байгаа үндэсний стандартууд.

**Хоёр. Судалгааны арга зүйн материалууд:**

2.1 “УБТЗ” ХНН-ийн статистикийн эмхтгэл-2007 он;
2.2 “УБТЗ” ХНН-ийн “Тайлангийн эмхэтгэл-2014, 2015”, УБ,2014, 2015 он;
2.3 Авдай.Ч, Энхтуяа.Д “Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй”, УБ.2010, 367 х.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

# “ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА”-ЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Улаанбаатар хот**
**2022 он**

## ГАРЧИГ


**УДИРТГАЛ** ........ 3

**НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ** ........ 3

Зорилгод хүрэх байдал ........ 3

Практикт хэрэгжих боломж ........ 4

Харилцан уялдаа ........ 4

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ** ........ 4

2.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал ........ 4

2.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүоүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал ........ 5

2.3. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал ........ 7

**ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ** ........ 7

3.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтээр хүрээнд хийсэн үнэлгээ: ........ 7

3.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ ........ 9

3.3. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ ........ 15

**ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ** ........

4.1. Үнэлэлт, дүгнэлт ........ 24

4.2. Зөвлөмж ........ 26

**ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ** ........ 22

Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт ........ 22

Хоёр. Судалгаа, тайлан, төсөл, эмхэтгэл, ном, сэтгүүл ........ 28

# “ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## УДИРТГАЛ

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6. дахь хэсэгт заасан аргачлалын дагуу Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан батлуулсан. Тус үзэл баримтлалыг үндэслэн боловсруулсан “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төсөлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу үнэлэв.

“Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төслийг суурь судалгаанд тулгуурлан Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар төмөр замын тээврийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал:

***Зорилгод хүрэх байдал:*** Хуулийн төслийн зохицуулалтууд нь тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадах эсэх; хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлагад нийцсэн эсэх; хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэх;

***Практикт хэрэгжих боломж:*** Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх; мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, ямар асуудал бэрхшээл учирч болох зэрэг нөхцөл байдлыг шалгах;

***Харилцан уялдаа:*** Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хуультай нийцэж байгаа эсэх; хуулиар үүрэг хүлээсэн ч субъектүүдийн чиг үүрэг давхацсан эсхүл зөрчигдөж байгаа эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж, тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

## ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий шинээр нэмж орж буй, голлох заалтыг сонгож, түүний үр нөлөөг судална.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл гэрчилгээжүүлэлт, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой суурь бүтцийн өмчлөл, эзэмшил, үйлчилгээ, зураг төсөл болон ашиглалтын талаарх зохицуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны төрөл, зориулалт, бодлого зохицуулалтыг тодорхойлон, төмөр замын төрийн болон тээвэрлэгч байгууллагад хүлээлгэх чиг үүрэг, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Энэхүү тайлангийн нэгдүгээр хэсэгт сонгон авсан шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

### *2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал*

“Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үндсэн зорилго нь Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах, нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршиж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд хуулийн төслөөр дараах зорилтуудыг сонгон дэвшүүлэн үнэлнэ.

Нэгдүгээр хүснэгт

**Хуулийн төслийн зорилтуудыг сонгон үнэлэх**

| Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд | Сонгосон зүйл заалт |
|---|---|
| Төмөр замын суурь бүтцийн өмчлөл, ашиглалтад оруулах | Хуулийн төслийн 23, 24 дүгээр зүйл. |
| Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт | Хуулийн төслийн 41 дүгээр зүйл. |

## *2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал*

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэгтэй холбоотой заалтууд, 2/Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, 3/Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ, ашиглалт зэрэг зохицуулалтыг сонгон авч “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв.

Хоёрдугаар хүснэгт

**Хуулийн төслийн зорилтуудыг сонгон үнэлэх**

| Д/д | Практикт хэрэгжих боломж | Сонгосон зүйл заалт |
|---|---|---|
| 1 | Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэгтэй холбоотой заалтууд | **27 дугаар зүйл. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг:**<br><br>27.1 **Төмөр замын суурь бүтэц эзэмшигч нь дараах эрхтэй:**<br>27.1.1.төмөр замын суурь бүтцийн төлбөртэй үйлчилгээ үзүүлэх;<br>27.1.2.өөрийн төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг батлах, хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал өгөх;<br>27.1.3.тээвэрлэгчийн тээвэрлэлтийн технологи, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, техникийн байдал нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахгүй, суурь бүтцийн хүчин чадлаас хэтэрсэн тохиолдолд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;<br>27.1.4.энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн дотооддоо үйлчлэх техник, технологийн дүрэм, журам, зааврыг баталж мөрдүүлэх;<br>27.1.5.өөрийн төмөр замын суурь бүтцийг шинэчлэх, засварлах, өргөтгөх ажлыг гүйцэтгэх зорилгоор галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарлах, түр хаах эрхтэй.<br>**27.2 Төмөр замын суурь бүтэц эзэмшигч нь дараах үүрэгтэй:**<br>27.2.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, холбогдох бусад хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартыг дагаж мөрдөх;<br>27.2.2.энэ хуулийн 26.1.2, 26.1.3-т заасан гэрээ байгуулах;<br>27.2.3.галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмагт нийцүүлэн зохион байгуулах; |

| | | |
|---|---|---|
| | | 27.2.4.салбар зам эзэмшигчтэй гэрээ байгуулж, сэлгээний хөдөлгөөнийг зохион байгуулах;<br>27.2.5.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;<br>27.2.6.төмөр замын аюулгүй байдал, тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах;<br>27.2.7.энэ хуулийн 11.1.16-д заасан журмын дагуу шаардлагатай мэдээ, тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;<br>27.2.8.энэ хуулийн 27.1.5-т заасан галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарласан, түр хаасан тохиолдолд нийтэд мэдээлэх;<br>27.2.9.тусгай зориулалтын төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үндсэн дээр суурь бүтцийн үйлчилгээг нийтэд үзүүлэх. |
| 2 | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг | **10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төмөр замын тээвэр дэх галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зохицуулалттай холбоотой чиг үүрэг**<br>10.2.3.төмөр замын суурь бүтцүүдийн хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих;<br>10.2.4.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах;<br>10.2.5.төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвийг нэгдсэн удирдлагаар хангах;<br>10.2.6.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах;<br>10.2.7.төмөр замын тээврийн тарифыг хянах, санал, дүгнэлт гаргах;<br>10.2.8.төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах; |
| 3 | Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ | **25 дугаар зүйл. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ**<br>25.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:<br>25.1.1.галт тэрэгний хөдөлгөөнийг диспетчерийн удирдлагаар хангах;<br>25.1.2.хөдлөх бүрэлдэхүүнийг сэлгэх, найруулах;<br>25.1.3.хөдлөх бүрэлдэхүүнд зэхэлт /эрчим хүч, түлш, шатахуун, ус, хийгээр хангах/ хийх; |

| | | |
|---|---|---|
| | | 25.1.4.хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг, үйлчилгээ хийх;<br>25.1.5.аюултай, овор ихтэй, хамгаалалттай ачаатай хөдлөх бүрэлдэхүүн, хүнд жинтэй болон урт бүрэлдэхүүнтэй галт тэргэнд хяналт тавих;<br>25.1.6.галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл солилцох, хангах;<br>25.1.7.төмөр замын тээврийн ашиглалттай холбоотой дохиолол холбоо, мэдээлэл, сүлжээ, програм хангамжаар хангах. |

***2.3. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал***

"Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 11 бүлэг, 49 зүйлтэй/

## ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Энэхүү тайлангийн Хуулийн төслийн 2,3,4,5,6,7 дугаар бүлгүүдээс сонгосон зүйлүүдийн шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ.

Гуравдугаар хүснэгт

**Хуулийн төслийн сонгон авсан бүлэг, зүйлийг үнэлэх**

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|---|---|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал | Хуулийн төслийн 11,15, 22, 38, 42 дугаар зүйл | Зорилгод дүн шинжилгээ хийх |
| 2 | Практикт хэрэгжих боломж | Хуулийн төслийн 13, 16, 22, 25 дугаар зүйл | Практикт туршилт хийх, практикт тухайн төрлийн харилцаа, гарч болох хүндрэлийг судлах. |
| 3 | Харилцан уялдаа | Хуулийн төслийг бүхэлд нь тооцно | Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах |

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

### 3.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтээр хүрээнд хийсэн үнэлгээ

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилгыг аргачлалын дагуу төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэх болно.

Дөрөвдүгээр хүснэгт

**Хуулийн төслийн зорилго нь төслийн зохицуулалт, арга хэмжээнүүдэд хүрэх боломжтой эсэхийг үнэлэх**

| |
|---|
| Төмөр замын тээврийн тухай хуулийн зорилгын хүрээнд хуулийн төслийн 18, 24 дахь заалтад дүн шинжилгээ хийсэн байдал. |

Хуулийн нэгдүгээр зүйлд "Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, суурь бүтэц барих, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино." хэмээн ерөнхий зорилтыг тодорхойлж өгсөн байна.
Дээрх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Төмөр замын суурь бүтэц дараах бүрдэл хэсэгтэй байна" гэж төмөр замын суурь бүтцийг 4-н бүрдэлтэй байхаар хуульчилсан. Хуулийн төслийн 24 дугаар зүйлийн 24.1-д "Нийтийн төмөр зам нь төрийн өмчит буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байна.", 24.2-д "Улсын хилийн боомт чиглэлийн болон хил дамнасан төмөр зам нь нийтийн төмөр замд хамаарна.", 24.3-д "Төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих тохиолдолд төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншлэлийн гэрээнд тусгасан байна." гэж хуулийн төсөлд тус тус тусгаж хуулийн зорилгод нийцүүлсэн байна.

Тавдугаар хүснэгт

**Хуулийн төслийн 39 дүгээр зүйлийг үнэлэх**

**39 дүгээр зүйл. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгт тавигдах шаардлага**

39.1.Хөдлөх бүрэлдэхүүн нь төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн зохицуулалт, норм, стандартад нийцсэн байна.

39.2.Хөдлөх бүрэлдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлж, дугаар, гэрчилгээ авсан байна.

39.3.Хөдлөх бүрэлдэхүүн нь технологийн болон хөдөлгөөний хяналтын системд холбогдох боломжоор хангагдсан байна.

39.4.Хөдлөх бүрэлдэхүүн нь тогтоосон хугацаанд засвар, үйлчилгээнд хамрагдсан байна.

39.5.Хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах ажлыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

39.6.Энэ хуулийн 39.5-д заасан эрх бүхий этгээд нь хийсэн засвар, үйлчилгээндээ чанарын баталгаа гаргана.

**41 дүгээр зүйл. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт**

41.1.Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой харилцааг энэ хуулийн 11.1.11-т заасан журмаар зохицуулна.

41.2.Хөдлөх бүрэлдэхүүний хийц бүтээцийг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй өөрчлөхийг хориглоно.

Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн үйл ажиллагаа, хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, дугаар, гэрчилгээ олгохыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулахаар тусгасан.

### 3.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуульчилж байгаа зохицуулалт нь дагаж мөрдөж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх болно.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага, төмөр замын тээврийн төр, хувийн хэвшлийн байгууллага, тээвэрт оролцогч, эрх нь хөндөгдөх этгээд, судлаач нараас төсөлд санал авах, Төмөр замын тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, албан ёсны цахим хуудасны мэдээлэл, Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүнийг нэвтрүүлэх, бүртгэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар шалгасан.

Эдгээрийг практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн заалтуудыг сонгон судлах болно. Дээрх заалтуудын практикт хэрэгжих боломжийг судлахдаа Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгчийн эрх үүрэг, үйл ажиллагааг жишиг болгон авч үзсэн. Практикт хэрэгжих боломжийг дараахь асуултад хариулахыг эрмэлзлээ. Үүнд:

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх

Долдугаар хүснэгт

**Хуулийн төслийн 17, 30 дугаар зүйлийг үнэлэх**

| |
|---|
| Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилгын хүрээнд Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, ашиглах зорилгын хүрээнд хуулийн төслийн 17, 30 дугаар зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал. |

**3.2.1 Хэрэгжүүлэх субьект байгаа эсэх:**

Төмөр замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий субъект болох Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын талаар Хуулийн төслийн 8 дугаар зүйлд төмөр замын тээврийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төмөр замын суурь бүтэц, салбар замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбоотой ажлыг зохион байгуулах; төмөр замын осол, зөрчлийг шинжлэн шалгах; улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой зарим төрлийн ачаанд тээвэрлэлтийн давуу байдал олгох зэрэг эрх, үүрэгтэй байхаар тусгажээ.

Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг хуулийн төслийн 10 дугаар зүйлд “төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт боловсруулах, сурталчлах; төмөр замын суурь бүтцүүдийн хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих; галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах; төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвийг нэгдсэн удирдлагаар хангах; суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах; төмөр замын тээврийн тарифыг хянах, санал, дүгнэлт гаргах; төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах; төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийн зэрэг, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох; төмөр замын тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацийг нэвтрүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх; төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг барих, өргөтгөх ажиллагаанд хяналт тавих; хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, дугаар, гэрчилгээ олгох; төмөр замын суурь бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх; төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх; төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох; төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, гэрчилгээ олгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах.”-аар хуульчилсан байна.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлд “Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ”-ний талаар “суурь бүтцийн өмчлөгч, эзэмшигч нь өмчийн хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор нь гэрээний үндсэн дээр суурь

бүтцийн үйлчилгээ үзүүлэх" зохицуулалтыг тусгасан байна. Мөн суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, суурь бүтцийг тэгш эрхийн зарчмыг баримтлан, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглуулахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан байна.

### 3.2.2 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг "Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд суурь бүтцийг оновчтой зохицуулж, түүний тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэн, хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг зохицуулж дугаар олгох, бүртгэх, ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийх" гэж тусгасан нь Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, ашиглах боломжийг бүрдүүлжээ.

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийг байгуулж, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны дүрмийг батлан, хуульчилсан.

Төмөр замын тээврийн тухай 2007 оны хуулийн 12 зүйлд "Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүний бүрэн эрх"-ийн талаар зохицуулсныг 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болгосон. Энэхүү Төрийн захиргааны байгууллагыг дахин шинээр байгуулахаар хуулийн төслийн 10 дугаар зүйлд дараах байдлаар тусгасан байна.

Наймдугаар хүснэгт

**Хуулийн төслийн 10 дугаа зүйлийг үнэлэх**

| |
|---|
| **10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**<br>10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.<br><br>10.2.Төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.<br>10.2.1.төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт боловсруулах, сурталчлах;<br>10.2.2.төмөр замын техник технологитой холбоотой журам, аргачлал, горим, заавар, техникийн даалгавар, жагсаалт, загвар батлах;<br>10.2.3.төмөр замын суурь бүтцүүдийн хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих;<br>10.2.4.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах;<br><br>10.2.5.төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвийг нэгдсэн удирдлагаар хангах; |

10.2.6.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах;

10.2.7.төмөр замын тээврийн тарифыг хянах, санал, дүгнэлт гаргах;

10.2.8.төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах;

10.2.9.төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийн зэрэг, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох;

10.2.10.төмөр замын тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацийг нэвтрүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

10.2.11.төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг барих, өргөтгөх ажиллагаанд хяналт тавих;

10.2.12.хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, дугаар, гэрчилгээ олгох;

10.2.13.төмөр замын суурь бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх;

10.2.14.төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх;

10.2.15.төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох;

10.2.16.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, гэрчилгээ олгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах.

10.3.Энэ хуулийн 10.2.8-д заасан хяналт шалгалтыг хийхэд ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан байцаагчийн эрхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

**Хуулийн төслийн 27 дугаар зүйлд:** "Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өмчийн хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор болон бусад этгээдэд гэрээний үндсэн дээр суурь бүтцийн үйлчилгээг үзүүлнэ. Суурь бүтцийн үйлчилгээ нь тэгш эрхийн зарчмыг баримтлан, төмөр замын тээврийн аюулгүй байдал, техникийн зохицуулалт, стандартын шаардлагад нийцүүлсэн байна." гэж хуульчилсан.

Төмөр замын тээврийн салбарт 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 177 зүтгүүр, 260 зорчигчийн вагон, 11938 ачааны вагон, 71 машин механизм нийт 12269 хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ гүйцэтгэж байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу 2007 онд үндэсний 8 стандарт, 2012 онд үндэсний 21 стандартыг мөрдөж байсан бол 2013 оноос евростандартыг нэвтрүүлэх зорилтот төслийг хэрэгжүүлснээр 2022 оны 12 дугаар сарын байдлаар төмөр замын тээврийн салбарт MNS-54, MNS ISO-3, MNS EN-97, MNS ГОСТ-R-4, MNS TB-4, MNS GB-1, MNS CEN/TS-2 буюу нийт 163

стандарт 5167 нүүр техник, технологийн зохицуулалтын баримт бичигтэй болсон байна.

Хуулийн төсөл батлагдснаар төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өмчийн төрөл хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор болон бусад этгээдэдийн харилцааг зохицуулах боломжтой болно.

Улсын хэмжээнд 2007 онд 2800 хөдлөх бүрэлдэхүүнтэй, 14,1 сая тн ачаа хоногийн дундаж ачаалал 494 вагон, нэг голд ноогдох, статик даац 51.1тн, ачаа тээвэрлэт 14072.6, ОХУ-65327 вагон, БНХАУ-31126 вагон, зорчигч эргэлт 4410.7, зорчигч тээвэрлэлт 1406 сая зорчигч байв. 2018 онд 8403 хөдлөх бүрэлдэхүүнтэй болж, 25.1 сая тн ачаа, 2565890 зорчигч тээвэрлэсэн байсан.

Хуулийн төслийн 27 дугаар зүйлд "Төмөр замын суурь бүтэц эзэмшигчийн эрх, үүргийг хуульчилсан нь төмөр замын суурь бүтцийг эзэмших нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Уул уурхай, барилга, бусад салбарын хөгжил эрчимжсэнээр төмөр замын тээврийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэрийн хуулийн этгээдүүд олноор байгуулагдаж, 2022 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах, засварлах эрх бүхий 253, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болсон байна. Төмөр замын тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэгч 206 зэрэг аж ахуйн нэгж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцон, төмөр замын суурь бүтцийг эзэмшиж байна.

Есдүгээр хүснэгт

**Хуулийн төслийн 25, 31, 40 дүгээр зүйлийг үнэлэх**

| |
|---|
| Нэгдсэн зурмагаар зорчигч, ачааг төмөр замаар тээвэрлэх зорилгын хүрээнд хуулийн төслийн **25, 31, 40** дүгээр зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал. |

### 3.2.3 <u>Хэрэгжүүлэх субьект байгаа эсэх</u>

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дагаад Төмөр замын тээврийн суурь бүтцийг ашиглаж, тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг хангахад тээврийн үндсэн үзүүлэлтийн өсөлтийг дараах байдлаар үзүүлэв.

**Төмөр замын тээврийн 1990-2019 оны үндсэн үзүүлэлтүүд**




Хуулийн төсөл батлагдснаар төмөр замын сүлжээ нь олон улсын болон хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжиж, төмөр замаар ачаа, зорчигч, тээш, ачаан тээшийн тээвэрлэлт өсөн нэмэгдэж, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасган, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах боломж бүрдэнэ.

Хуулийн төслийн 25, 31, 40 дүгээр зүйл заасан зохицуулалт нь төмөр замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах, тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалтыг бий болгон төмөр замын тээврийн дотоодын нэгдсэн сүлжээг өргөжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төмөр замын тээврийн салбарын менежментийг боловсронгуй болгож, техник, технологийн шинэчлэлт хийгдэнэ. Мөн ашигт малтмалын томоохон ордуудтай төмөр замаар холбогдсон аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, ашигт малтмалыг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн эргэлтийг хангах, экспортыг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Аравдугаар хүснэгт

**Төмөр замын тээврийг 2030 он хүртэл дээшлүүлэх боломжит хувилбар, үзүүлэлт**

| Үзүүлэлтүүд | 2010 он | 2011 он | 2012 он | 2013 он | 2030 оны төлөвлөлт | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1-р хувилбар | 2-р хувилбар | 3-р хувилбар |
| Дотоодын тээвэр | 8.3 | 8.6 | 9.9 | 10.7 | 17 | 17 | 21.4 |
| Экспорт | 4.6 | 6 | 6.6 | 6.1 | 11.8 | 23.8 | 39.1 |
| Импорт | 1.6 | 2 | 2.4 | 2.5 | 2.7 | 3.2 | 3.2 |
| Транзит | 2.3 | 1.9 | 1.5 | 1.7 | 3.1 | 4.2 | 10 |
| Бүгд | 16.8 | 18.5 | 20.4 | 21 | 34.6 | 48.2 | 73.7 |




**1-р график.** Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг сайжруулах нөхцөл

## <u>Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж боломж бололцоо байгаа эсэх</u>

Хуулийн төслийн 11.1.3-т заасан “Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм”-д зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтийн талаар тусгаж, зорчигч болон тээвэрлэгч гэрээний үндсэн дээр тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хамтран оролцож, зорчигч тасалбарын үнийг төлөх, тээвэрлэгч нь зорчигч, ачаа, ачаан тээшийг тогтоосон газарт нь хүргэх үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Мөн хуулийн төсөлд “Суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй, найдвартай байдлыг хангах, өөрийн суурь бүтцийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах” үүргийг тусгасан байна. Төмөр замын тээврийн салбарын зорчигч тээвэрлэлтийг суурь бүтэц эзэмшигч, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн хувьцаат компани дангаараа зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Төмөр замын тээврийн тухай хууль батлагдснаас хойш тээвэрлэсэн зорчигчийн тоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Арванхоёрдугаар хүснэгт

**Төмөр замын зорчигч тээвэрлэлтийн 2007-2019 оны үзүүлэлт**

| Үзүүлэлт | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорчигчид, мян.хүн | 4 482.4 | 4 358.8 | 3 118.3 | 3 516.3 | 3 832.1 | 4 000.0 | 3 759.7 | 3 305.8 | 2 794.7 | 2 645.5 | 2 630.3 | 2 565.89 | 2 325.89 |

Төмөр замын тээврийн салбарт 2007 оны байдлаар ганц суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч буюу "УБТЗ" ХНН байсан бол өдгөө өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4 болж нэмэгдсэн, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250, төмөр замын тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэгч 206 болсон байна.

Зорчигч нь бүх төрлийн галт тэрэг, вагонд тасалбар худалдан авч, тасалбарын дагуу суудал авах, нийтийн хэв журмыг сахин биелүүлэх, тээвэрлэгчийн эд хөрөнгөнд ариг гамтай хандах, галын аюулгүй байдлыг хангах зарчмаар төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцож байна.

Хуулийн төслийн 11.1.2-т заасан "Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм"-д "Ачаа тээвэрлэлтийн гэрээнд заасны дагуу тээвэрлэгч нь хүлээн авсан ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, тээвэрлэлтийн нөхцөлийг мөрдөх, хүрэх өртөөнд ачаа хүлээн авагчид хугацаанд нь хүргэх, ачаа илгээгч нь ачаа тээвэрлэлтийн хөлс төлөх, ачаа хүлээн авах үүрэг хүлээнэ" гэж тусгасан нь ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Ачаа тээвэрлэлтийн гэрээнд заасны дагуу тээвэрлэгч нь хүлээн авсан ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, тээвэрлэлтийн нөхцөлийг мөрдөх, хүрэх өртөөнд ачааı хүргэх үүрэг, ачаа тээвэрлэлтийн гэрээг нотлох баримт түүний иж бүрдэл, төлбөр хураамжийн талаарх зохицуулалтыг тусгасан байна.

Хуулийн төслийн 11.1.2-т заасан "Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм"-д "Ачаа тээвэрлэлт зохион байгуулах гэрээний дагуу ачаа илгээгч нь ачааг тээвэрлэгчид хүлээлгэн өгөх, тээвэрлэгч нь ачааг хүлээж авах, хүргэх үүрэгтэй, мөн тээвэрлэгч болон ачаа илгээгч нь байнгын тогтмол тээвэрлэлт хийх зорилгоор тээвэрлэлтийг зохион байгуулах урт хугацааны гэрээ байгуулах"-аар тусгасан. Энэ нь тээврийн хэмжээ, хугацаа, тээвэрлэлтийн чанар, ачааг тээвэрлэлтэд бэлтгэх нөхцөл зэргийг бүрдүүлж, нэгдсэн зурмагаар тээвэрлэлтийг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

# ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

**4.1 Үнэлэлт, дүгнэлт:**

Хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төмөр замын тээврийн тухай хууль нь 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан бөгөөд 8 бүлэг, 34 зүйл, 341 заалттай. төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчлагдсан байна.

Энэхүү хууль нь 2007 оноос хойш өнөөг хүртэл мөрдөгдөх явцад Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 08 дугаар сарын 17-ны, 2015 оны 12 дугаар сарын 04-ний, 2017 оны 02 дугаар сарын 02-ны, 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн хуулиар тус тус нийт 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт өөрчлөлтөөр 2 зүйл заалт нэмсэн, 8 зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан, 2 зүйл заалтыг өөрчлөн найруулж, 9 зүйл заалтыг өөрчлөн, 2 зүйл заалтыг хүчингүй болгосон байна

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 197 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дэд бүрэлдэхүүн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг үндэслэн, төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг1 бүлэг, 49 зүйлтэй боловсруулж, хуулийн зорилгыг "төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, суурь бүтэц барих, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах"-аар боловсруулсан.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараахь байдлаар үнэлж, дүгнэлээ.

**4.2 Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр үнэлэхэд:

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас гурван төрлийн зорилгыг сонгон авч, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад үнэлгээ хийсэн. Төмөр замын суурь бүтэц түүний өмчлөл, эзэмшил, хөдлөх бүрэлдэхүүн, зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт, ачаа тээврийн төлөвлөлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьсон.

Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах зорилгын хүрээнд 18, 19, 42, 43 дугаар зүйлд хийгдсэн үнэлгээг харахад төмөр замын суурь бүтцийн төрлийг:

- төмөр замын дээд байгууламж, төмөр, дэр, чигжээс, суман шилжүүлэг болон бусад дээд байгууламж;
- нэг болон өөр түвшний огтлолцол, төмөр замын доод байгууламж (гүүр, хоолой, ус зайлуулах, чиглүүлэх төхөөрөмж, тогтоох хана, хамгаалалт, хана болон бусад), хашаа, хамгаалалтын байгууламж;
- ногоон байгууламж, төмөр замын өртөө, хэсэглэх газар, төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламж;

- сум дохионы харилцан хамаарлын болон диспетчерийн удирдлага зохицуулалтын систем зэрэг галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууламжууд;
- төмөр замын харилцаа холбооны сүлжээ, агаарын болон газар доорх төмөр замын цахилгаан, ус хангамжийн шугам, контактны сүлжээ, трансформатор болон татах дэд станцууд;
- төмөр замын суурь бүтцийн байгууламжийн ашиглалт, засвар, арчлалтын зориулалттай барилга байгууламж;
- төмөр замын зурвас газар, зурвас газрын дагуух агаарын орон зай гэж төрөлжүүлэн тусгажээ.

Нийтийн зориулалттай төмөр замын суурь бүтэц төрийн өмчид байх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд эзэмшиж, тусгай зориулалтын төмөр замын суурь бүтэц төрийн болон хувийн өмчийн аль ч хэлбэрийн байж болохоор тусгаж өмчлөгч, эзэмшигчийн эрхийг тогтоожээ. Мөн төмөр замын суурь бүтцийг концессын барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр барьж байгуулсан бол уг гэрээний хугацаанд концесс эзэмшигч нь тухайн суурь бүтцийн эзэмшигч байхаар зохицуулсан байна.

Нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилтын хүрээнд зорчигч, тээш, ачаан тээш, тээвэрлэлтийг гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх талаар тусгаж, зорчигч, тээвэрлэгчийн эрх үүргийг тодорхойлсон байдал нь хуулийн зорилготой бүрэн нийцсэн гэж үзэж байна.

***Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:***

***Уг хуулийн төслийн хүрээнд сонгон авсан*** Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг, бүрэн эрх, Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ, Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүргийн талаарх зүйл заалтууд нь практикт хэрэгжих боломж байгаа эсэхийг судлаад дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар тухайн хуулийг хэрэгжүүлэх байгууллага, хүн, хуулийн этгээдийн талаарх зохицуулалт хангалттай тусгасан.

- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийтийн зориулалттай төмөр замын суурь бүтэц төрийн өмчид байх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд эзэмшиж болохоор тусгаж, хуулийн үйлчлэлд хамаарах субъектыг тодорхойлж, практикт хэрэгжих боломжийг хангасан гэж үзлээ.

*Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултыг тодруулж, хуулийн төслийн дотоод болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон.

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шааардлагатай байх 14 төрлийн асуултаас Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь асуулгын хариултыг бүрэн хангасан, уялдаа холбоотой болсон байна гэж дүгнэлээ.

Хуулийн төсөлд хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан, төрийн байгууллагын чиг үүргийг давхацуулсан зохицуулалт байхгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт хийгдээгүй, авилга хүнд суртал бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй гэж дүгнэлээ.

| I. **Давхардал** | II. **Зөрчил** | III. **Хийдэл** |
|---|---|---|
| 1.1 Хуулийн төсөлд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх; 1.2 Хуулийн төсөлд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;<br>1.3 төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;<br>1.4 Хуулийн төсөлд тодорхой зохицуулалтыг дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардал, зөрчил, хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх. | 2.1 Хуулийн төслийн тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх, нэр томъёог бусад хуулийн нэр томъётой зөрчилдөж байгаа эсэх;<br>2.2 Хуулийн төсөлд тодорхой асуудлыг гагцхүү тухайн хуулиар зохицуулахаар заасан болөвч уг асуудлаар Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, бусад хуульд өөрөөр заасан эсэх, ишлэл, зохицуулалт нь холбогдох хуультай нийцэж байгаа эсэх;<br>2.3 Хуулийн төсөлд өмчлөх эрхийг хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх;<br>2.4 Хуулийн төслийн тодорхой зохицуулалтыг дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх. | 3.1 Хуулийн төсөлд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх, нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;<br>3.2 Хуулийн төсөлд заасан процессын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэх, тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх тодорхойлох;<br>3.3 Хуулийн төсөлд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан тодорхой зохицуулалтыг дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх;<br>3.4 Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх. |

2.5 Хуулийн төслийг татвараас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

2.6 Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх;

## 4.2. ЗӨВЛӨМЖ

Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна.Үүнд:

1. Хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн агуулгатай нийцүүлж, дахин боловсруулах;

2. Хуулийн төслийн зорилгыг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн батлагдсан үзэл баримтлалд тусгасан хуулийн зорилготой уялдуулах;

3. Хуулийн төслийн агуулгатай нийцүүлэн хуулийн төслийн нэр томъёог дахин боловсруулах;

4. Хуулийн төслийн агуулгыг анхаарч, зүйл хэсэг, заалтын доторх агуулга хоорондоо зөрүүтэй байгааг залруулах.

5. Хуулийн төслийн бичвэрийг Хууль тогтоомжийн тухай хууулийн 29 дүгээр зүйл "Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага"-тай нийцүүлэх;

6. Хуулийн төслийн бусад хуультай давхацсан заалтыг ишлэл хийж оруулах;

7. Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний актын нэрийг тусгаж, батлах эрх бүхий этгээдийг тодорхой тусгах ;

8. Хуулийн төслөөс журамласан шинжтэй, нэг удаагийн үйлдэлтэй холбоотой заалтуудыг хасах;

9. Хуулийн төслөөс хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тусгах;

10. Хуулийн төслийн утга найруулга, зүйл заалтын хоорондын уялдаа холбоог анхаарч залруулах талааар арга хэмжээ авах.

11. Хуулийн төслийг дагалдаж гарах бусад хуульд орох нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;

12. Санал авах, хэлэлцүүлэг явуулах явцад илрүүлсэн санал, хэлэлцүүлэгт оролцогчдоос хуулийн төслийг ойлгомжтой болгох талаар гаргасан саналыг харгалзан үзэж, боломжит зохицуулалтыг томъёолж тусгах.

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомж, эрх зүйн акт, онолын ном, сурах бичиг, холбогдох вэб сайтуудын мэдээллийг ашигласан болно.

**Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ, бусад эрх зүйн акт**

### *1.1 Эрх зүйн баримт бичиг*

- Монгол Улсын Үндэс хууль 1992 он;
- Монгол Улсын Иргэний хууль 2002 он (35 дугаар бүлэг, 380-398 дугаар зүйл);
- Төмөр замын тээврийн тухай хууль 2007 он;
- Авто тээврийн тухай хууль 1999 он;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль 2015 он;
- Захиргааны ерөнхий хууль 2015 он;
- Хууль тогтоомжийн тухай хууль 2016 он;
- Авто замын тухай хууль 2017 он;
- Наушкаас Улаанбаатар хүртэл төмөр замыг байгуулж ашиглахын тулд Монгол Зөвлөлтийн хувьцаат нийгэмлэг байгуулах БНМАУ-ын Засгийн газар, ЗХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1948 он;
- Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр 1956 он;
- Монгол, Орос, Хятадын төмөр замын харилцааны хэлэлцээр 19 он;
- Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2004 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Украйн улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1995 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1996 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Турк улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2001 он;
- Төмөр замын салбар дахь харилцааны тухай Монгол Улсын болон Беларусь улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2003 он;
- Олон Улсын төмөр замын ачаа харилцааны хэлэлцээр 1951 он;
- Олон Улсын төмөр замын зорчигч харилцааны хэлэлцээр 1956 он;
- Монгол Улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Дамжин өнгөрөх журмын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 1992 он;
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”;
- Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “ Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;

- Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “2018 онд Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”

### 1.2 *Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг, өгүүлэлүүд:*

- Шүүхийн ерөнхий зөвлөл 2007-2017 онуудад төмөр замын тээврийн хуультай холбоотой асуудлаар иргэн болон эрүүгийн хэргийг шүүхээр шийвэрлэсэн статистик судалгаа;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх хүний эрхийн үндэсний комиссын 10 дахь илтгэл 2011 он 3 дугаар бүлэг;
- Монгол Улсын Их Хурлын даргын 2013 оны 119 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын газар зүйн байрлалын давуу талыг ашиглан төмөр зам, авто зам, авто тээвэр, агаарын тээврийн дамжин өнгөрөх зорчигч, ачаа тээвэрлэлийг нэмэгдүүлэх, нэгдсэн тээврийн ложистикийн сүлжээг бий болгох, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгаан дамжуулах шугамын талаар нэгдсэн бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс зохион байгуулсан “Монголын төмөр замын хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний бага хурал, “Төмөр замын тээвэр ложистикийн өнөөгийн байдал, цаашдын хөгжил” онол, практикийн бага хурал, “Евро-Азийн тээвэр болон бүс нутгийн оролцоо” олон улсын бага хурлын илтгэлийн хураангуй, “Дамжин өнгөрөх тээвэр-хөгжлийн гарц” илтгэл 2013 он.
- “Хөгжлийн үр дүнд хүргэх удирдлага:Төмөр замын суурь бүтцийн тариф-Монгол Улсын төмөр замын салбарт хувийн хэвшлийн төлөвшлийг дэмжих нь” судалгааны тайлан. Азийн хөгжлийн банк 2014 он.
- Зам, тээврийн хөгжлийн яам, Шинжлэх ухааны академи хамтран зохион байгуулсан “Төмөр замын тээврийн эрх зүйн орчин, хөгжлийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд, хурлаас гарсан зөвлөмж.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

# "ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА"- ЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ**
**2022 он**

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

### Нэг. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэж, захиргааны зардлыг нэмэгдүүлэх зохицуулалт нэмж тусгагдаагүй болно. Харин одоо хэрэгжиж буй хуулийн төслийн зохицуулалтыг дэлгэрэнгүй нарийвчилж задалж өгсөн болно.

1

### ХОЁР. "ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА" БУЮУ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДАЛ

Төмөр замын тээврийн салбарын 2012 оны үйл ажиллагааны тоон үзүүлэлт харьцуулахад **25-50%**-иар өсөж, салбар дахь аж ахуйн нэгжийн тоо, ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүний тоо нэмэгдэж байгаа нь салбар дахь төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Хуулийн төслийн 10 дугаар бүлэгт "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв"- ийн үйл ажиллагааны гүйцэтгэх үүргийг илүү тодорхой болгож, эрх үүргийг нэмэгдүүлэн байгууллагыг өргөжүүлж Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгож төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байхаар хуулийн төсөлд  тусгаад байна.

**Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага** нь хуулийн төсөлд тусгаснаар төмөр замын салбарт төрийн бодлого, зохицуулах, хянах үйлчилгээ үзүүлнэ.

Гүйцэтгэх үүрэгт төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт боловсруулах, сурталчлах, төмөр замын техник технологитой холбоотой журам, аргачлал, горим, заавар, техникийн даалгавар, жагсаалт, загвар батлах, төмөр замын суурь бүтцүүдийн хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих, галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах, төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвийг нэгдсэн удирдлагаар хангах, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах, төмөр замын тээврийн тарифыг хянах, санал, дүгнэлт гаргах, төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах, төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийн зэрэг, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох, төмөр замын тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацийг нэвтрүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх, төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг

барих, өргөтгөх ажиллагаанд хяналт тавих, хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, дугаар, гэрчилгээ олгох, төмөр замын суурь бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх, төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх, төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, гэрчилгээ олгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

**Урьдчилсан тооцооллоор галт тэрэгний нэгдсэн төвд нь одоогийн орон тоо 26, Төмөр замын төрийн захиргааны төв байгууллага орон тоо 16, Зам, тээврийн хөгжлийн яамны хяналтын газарт төмөр замын байцаагчийн орон тоо 5 байгаа бөгөөд энэхүү орон тоог шинээр байгуулагдах агентлаг руу шилжүүлэн 47 орон тоотойгоор ажиллана. Өмнө нь 2012 онд татан буугдсан агентлаг 45 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байсан ба шинэчлэн батлагдах хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг 47 орон тоотойгоор хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.**

## 2.1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАХИРГААНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хүчин төгөлдөр мөрдөж буй хуулинд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 29, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвд 10 бүрэн эрх буюу нийтдээ 39 бүрэн эрхийн хүрээнд төмөр замын салбарын үйл ажиллагааг зохицуулж байгаа бол шинэчилсэн найруулгын төсөлд Төрийн захиргааны төв байгууллагад 7 бүрэн эрх, төрийн захиргааны байгууллагад 18 бүрэн эрх буюу нийт 25 бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой.

“Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага”- ын хувьд дараах үүргүүдийг биелүүлэхэд нэмэлт орон тоо, түүнтэй холбоотой зардал шаардлагагүй болно.

Иймд Зам, тээврийн хөгжлийн яам болон “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын орон тоо болон материалаг нөөцийг ашиглан төсөвт дарамт учруулахгүйгээр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан төрийн зохицуулалт, үйлчилгээ болон хяналтыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

Нэгдүгээр хүснэгт 1

**Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн харьцуулалт**

| д/д | Шинэчилсэн найруулгын төсөл | Хүчин төгөлдөр хууль |
|---|---|---|
| Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх | **8 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**<br><br>8.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>8.1.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах;<br><br>8.1.2.төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;<br><br>8.1.3.төмөр замын тээврийн салбар дахь төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг төлөөлөх болон төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагааг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу төрийг төлөөлөн хэрэгжүүлэх;<br><br>8.1.4.төмөр зам суурь бүтэц, салбар замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбоотой ажлыг зохион байгуулах;<br><br>8.1.5.энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4, 14.1.5, 14.1.6, 14.1.7-д заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;<br><br>8.1.6.төмөр замын осол, зөрчлийг шинжлэн шалгах;<br><br>8.1.7.улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой зарим төрлийн | **10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**<br><br>10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>10.1.1.төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;<br><br>10.1.2.төмөр замын тээврийн салбар дахь төрийн өмчийн ашиглалт болон төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаанд төрийн төлөөллийг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх;<br><br>10.1.3.төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг батлах;<br><br>10.1.4.төмөр замын тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, гэрээний өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах;<br><br>10.1.5.суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;<br><br>10.1.6.төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл |

| | | |
|---|---|---|
| | ачаанд тээвэрлэлтийн давуу байдал олгох. | ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;<br><br>10.1.7.төмөр замын объект, салбар замыг өргөтгөх, шинээр барих ажиллагаанд хяналт тавих;<br><br>10.1.8.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах;<br><br>10.1.9.төмөр замын техникийн осол, сүйрлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилох;<br><br>10.1.10.төмөр замын тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах;<br><br>10.1.11.төмөр замын мэргэжлийн ажилтан ажиллах албан тушаалын жагсаалт, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалын жагсаалтыг батлах;<br><br>10.1.12.төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх;<br><br>10.1.13.төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг Тагнуулын ерөнхий газартай хамтран батлах;<br><br>10.1.14.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн тэргүүн зэрэг төрийн өндөр албан тушаалтны зорчих тусгай галт тэрэгний аялах журмыг Тагнуулын ерөнхий газартай зөвшилцөн батлах;<br><br>10.1.15.төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;<br><br>10.1.16.зарим төрлийн /зорчигч, шуудан, улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач |

| | | |
|---|---|---|
| | | холбогдолтой ачааны г.м./ тээвэрлэлтэд давуу байдал олгох;<br><br>10.1.17.тусгай тээвэрлэлт болон цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий байгууллагатай зөвшилцөн батлах;<br><br>10.1.18.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.<br><br>10.3.Төрийн захиргааны төв байгууллагын харьяанд төмөр замын тээврийн хяналтын алба, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв ажиллана.<br><br>10.4.Төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгаа шинжилгээний байгууллагатай байж болно. |

| | | |
|---|---|---|
| Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг | **10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**<br><br>10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.<br><br>10.2.Төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.<br><br>10.2.1.төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт боловсруулах, сурталчлах;<br><br>10.2.2.төмөр замын техник технологитой холбоотой журам, аргачлал, горим, заавар, техникийн даалгавар, жагсаалт, загвар батлах;<br><br>10.2.3.төмөр замын суурь бүтцүүдийн хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих;<br><br>10.2.4.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах;<br><br>10.2.5.төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвийг нэгдсэн удирдлагаар хангах;<br><br>10.2.6.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай | **13 дугаар зүйл.Төмөр замын тээврийн хяналтын алба, түүний бүрэн эрх**<br><br>13.1.Төмөр замын тээврийн хяналтын алба /цаашид “хяналтын алба” гэх/ нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд тавих захиргааны хяналтыг хэрэгжүүлнэ.<br><br>13.2.Хяналтын алба нь улсын ахлах байцаагч, улсын байцаагчаас бүрдэнэ.<br><br>13.3.Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагч олгоно.<br><br>13.4.Төмөр замын тээврийн улсын ахлах байцаагч нь хяналтын албаны дарга байна.<br><br>13.5.Хяналтын алба нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>13.5.1.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;<br><br>13.5.2.төмөр замын тээвэрт ашиглаж буй техник, тоног төхөөрөмж, байгууламж болон төмөр замын тээвэртэй холбоотой ажил, үйлчилгээ, технологийн горим нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг өмчийн хэлбэр, байршил харгалзахгүйгээр шалгах;<br><br>13.5.3.галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хянаж, сүйрэл, осол, гологдол гарах нөхцөл бий |

| | | |
|---|---|---|
| | тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах;<br><br>10.2.7.төмөр замын тээврийн тарифыг хянах, санал, дүгнэлт гаргах;<br><br>10.2.8.төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах;<br><br>10.2.9.төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийн зэрэг, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох;<br><br>10.2.10.төмөр замын тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацийг нэвтрүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;<br><br>10.2.11.төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг барих, өргөтгөх ажиллагаанд хяналт тавих;<br><br>10.2.12.хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, дугаар, гэрчилгээ олгох;<br><br>10.2.13.төмөр замын суурь бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх;<br><br>10.2.14.төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх;<br><br>10.2.15.төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж | болсон үед төмөр замын объектын ашиглалтыг хязгаарлах, түр зогсоох;<br><br>13.5.4.төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, гологдлын шалтгааныг судалж, мэргэжлийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авах;<br><br>13.5.5.тусгай зөвшөөрөл, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;<br><br>13.5.6.ачаа, чингэлэг, ачаан тээш, тээшний жин болон тээврийн бичиг баримт, түүнтэй холбогдох бусад мэдээллийг шалгах;<br><br>13.5.7.хяналтын албаны эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа төмөр замын тээвэрт ашиглаж байгаа барилга байгууламж, хөдлөх бүрэлдэхүүнд чөлөөтэй нэвтрэх, зорчих;<br><br>13.5.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.<br><br>13.6.Хяналтын албаны ажилтнууд тусгай дүрэмт хувцас хэрэглэнэ<br><br>**14 дүгээр зүйл.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, түүний чиг үүрэг, бүрэн эрх**<br><br>14.1.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв /цаашид “хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх/ нь төмөр замын байгууллагуудын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй.<br><br>14.2.Хөдөлгөөн зохицуулалтын төвийн ажиллах журмыг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тодорхойлно. |

| | | |
|---|---|---|
| | хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох;<br><br>10.2.16.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, гэрчилгээ олгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах.<br><br>10.3.Энэ хуулийн 10.2.8-д заасан хяналт шалгалтыг хийхэд ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.<br><br>10.4.Энэ хуулийн 10.3-т заасан байцаагчийн эрхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. | 14.3.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв нь дараахь бүрэн эрхтэй:<br><br>14.3.1.хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлах;<br><br>14.3.2.хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулж, зохицуулалт хийх;<br><br>14.3.3.суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангах;<br><br>14.3.4.галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх;<br><br>14.3.5.галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;<br><br>14.3.6.тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг боловсруулах;<br><br>14.3.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. |

----o0o----

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төсөлд өгсөн саналын нэгдсэн товчоо
/2022.10.07-2022.11.30/

| Д/Д | Төсөл | Ирүүлсэн санал | Саналыг тусгасан байдал | Байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | 43.2.Төмөр замын асуудал ~~эрхэлсэн~~ **<u>хариуцсан</u>** төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, төмөр замын дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна. | Аливаа төмөр зам дээр гарсан осол, сүйрлийн шалтгааныг тодруулж дүгнэлт гаргана. | Хуулийн төслийн 10.1.10-т заасан байх тул саналыг тусгаагүй. | УБТЗ РБтр Эрдэнэсүх |
| 2 | 43.3.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь байгалийн гамшиг, төмөр замын аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, дэд бүтцийг сэргээн босгох зориулалтын машин механизм, техник хэрэгсэл, материалын нөөцийг бүрдүүлсэн байна. | ... бүрдүүлж бэлэн байдлыг хангуулсан байна. | **<u>43.3.”Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь байгалийн гамшиг, төмөр замын аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, дэд бүтцийг сэргээн босгох зориулалтын машин механизм, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, материалын нөөцийг бүрдүүлсэн байна”</u> гэж найруулах.** | |
| 3 | 43.4.Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам эзэмшигч нь хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түргэн шуурхай хэрэгжүүлнэ. | дэд бүтэц эзэмшигч нь | ТЗ-ын тээврийн байгууллага гэдэгт тээвэрлэгч болон дэд бүтэц эзэмшигч хамаарна гэж заасан байх тул саналыг тусгаагүй. | |
| 4 | 43.6.Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулна: | үйл ажиллагааг зохион байгуулахад хяналт тавьж ажиллана. | 43.5-д заасан байх тул саналыг тусгаагүй. | |
| 5 | 43.6.2.галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах; | хасах | Аюулгүй байдлыг хангах нь гол агуулга тул саналыг тусгаагүй. | |
| 6 | 43.6.3.зорчигчийн галт тэргийг өртөө, зөрлөгт зөвхөн зориулалтын замаар хүлээн авч, явуулах; | хасах | ~~43.6.3.зорчигчийн галт тэргийг өртөө, зөрлөгт зөвхөн зориулалтын замаар хүлээн авч, явуулах;~~ | |
| 7 | 50.3.Төмөр замын ажилтан дүрэмт хувцас хэрэглэнэ. | хэрэглэж болох ба ажлын тусгай хувцас хэрэглэлээр заавал хангагдсан байна. | ХАБЭА-н тухай хуулиар зохицуулагдана. | |
| 8 | 51.1.1.төмөр замын тээврийн байгууллагад 25 болон түүнээс дээш жил ажилласан эрэгтэй, 20 болон түүнээс дээш жил ажилласан эмэгтэй ажилтан төмөр замын тээврийн байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол арваас | төмөр замын тээврийн байгууллагаас гэдгийг хасах | Бусад байгууллагаас тэтгэвэрт гарсан тохиолдолд ТЗ-ын тээврийн байгууллагын олгох нийгмийн баталгааг хангах боломжгүй тул саналыг тусгаагүй. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | доошгүй сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох; | | | |
| 9 | | 47.3. Хувийн өмчийн болон төрийн өмчийн концессын зүйлийн төмөр замыг барих, ашиглах, шилжүүлэх нөхцлөөр ашиглаж байгаа Төмөр замын суурь бүтэц эзэмшигч нь суурь бүтцийн тарифыг анхдагч хөрөнгө оруулалт, урсгал болон тогтмол зардлаа нөхөж ашигтай ажиллах үүднээс батлагдсан төслийн Техник эдийн засгийн үндэслэлийн дагуу бие даан тогтоох эрхтэй. | Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төмөр замын тээврийн тарифын нэгдсэн зохицуулалттай байна. Хуулийн төслийн 11.1.23-т төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, тээвэрлэлтийн тариф тогтоох аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага батлахаар зохицуулсан байх тул саналыг тусгаагүй. | БТЕГ ХХК Шижир |
| 10 | 1.1. Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, дэд бүтэц шинээр барих, шинэчлэх, дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. | хөдөлгөөний нэгдсэн зохицуулалт | Хуулийн төслийн 5.1.1-д заасан байх тул саналыг тусгаагүй. | "УБТЗ" ХНН НТП |
| 11 | 10.2.Төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалт болон сургалт, судалгаа шинжилгээ, төмөр замын тээврийн аюулгүй ажиллагааны хяналт, осол, зөрчлийг шинжлэн шалгах албатай байна. | Аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг ялгах | аюулгүй ажиллагааг аюулгүй **байдал** гэж сольсон. | "УБТЗ" ХНН НТП |
| 12 | 10.3.Төмөр замын тээвэрт аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих төрийн захиргааны хяналтыг Хяналтын алба хэрэгжүүлнэ. | Аюулгүй байдал | 10.3.Төмөр замын тээ~~вэрт~~рийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих төрийн захиргааны хяналтыг Хяналтын алба хэрэгжүүлнэ. | "УБТЗ" ХНН НТП |
| 13 | 15.1.Төмөр замын шугамын дагуух технологийн онцлог үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах газар нь төмөр замын зурвас газарт хамаарна. | онцлог үйл ажиллагаа гэж ямар үйл ажиллагааг хэлж байгааг тодруулах. | 15.1.Төмөр замын шугамын дагуух технологийн ~~онцлог~~ үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах газар нь төмөр замын зурвас газарт хамаарна. | "УБТЗ" ХНН НТП |
| 14 | 25.2.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь төмөр замын дэд бүтцийг шинэчлэх, засварлах, өргөтгөх ажлыг гүйцэтгэх зорилгоор галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарлах, түр хаах эрхтэй. | Төмөр замын дэд бүтэц эзэмшигчийн замд ашиглах хөдлөх бүрэлдэхүүний тоо нь өөрийн гол замын багтаамж, боловсруулах чадвараас хэтэрсэн тохиолдолд түүнийг нэмэх явдлаас татгалзах эрхтэй. | 25.1.3. **"тээвэрлэлтийн технологи, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, техникийн байдал нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахгүй, дэд бүтцийн** | "УБТЗ" ХНН НТП |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | **хүчин чадлаас хэтэрсэн тохиолдолд дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах"** гэж өөрчлөн найруулах. | |
| 15 | 25.3.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь тээвэрлэгчдэд ижил тэгш хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ. | Одоо УБТЗ-д вагоны хүрэлцээ байхгүйгээс ачилтын захиалга хангаж чадахгүй байна. | Хуулийн төслийн 25.1.3 дахь заалтад нэмж тусгасан. | "УБТЗ" ХНН НТП |
| 16 | | 41.2.3 "төмөр замын суурь бүтцийн технологийн үйл ажиллагааг саатуулах явдлыг гаргахгүй байх зорилгоор хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь өөрийн эзэмшлийн вагоныг (ашиглаагүй үед) зогсоох өөрийн болон түрээсээр ашиглах замтай байх" гэж шинээр нэмэх. | "41.2.3 хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглаагүй үед зогсоох өөрийн эзэмшлийн болон түрээсээр ашиглах салбар замтай байх" гэж шинээр нэмэх. | "УБТЗ" ХНН НТП |
| 17 | 44.1.Төмөр замын дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч, дэд бүтцийн эд анги, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах эрх бүхий этгээд нь тэмдэг, дугаар, бүртгэл бүхий тусгай зориулалттай багаж, хэрэгсэлтэй байна. | "Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд байгалийн гамшиг, аюулт үзэгдлээс шалтгаалан аюул учрахаас урьдчилан сэргийлэх мониторинг хийх, хамгаалах техник багаж хэрэгсэлтэй байна" гэж нэмэх. | Хуулийн төслийн 43.3-т заасан байх тул саналыг тусгаагүй. | "УБТЗ" ХНН НТП |
| 18 | 4.1.20."гол төмөр зам" гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын дэд бүтцийг; | Редакцийн 1-р хувилбар<br>"гол төмөр зам" гэж нийтэд болон улсын хил дамнасан тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын дэд бүтцийг;<br>Редакцийн 2 -р хувилбар :<br>"гол төмөр зам" гэж олон улсад болон нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын дэд бүтцийг; | Шинэчлэн найруулсан. | "УБТЗ" ХНН НТП |
| 19 | 20.1.Төмөр замын зураг төсөл нь төмөр замын дэд бүтцийг шинээр болон шинэчлэн барих, засварлахад шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, техникийн болон инженерийн нарийвчилсан зураг, төсөв зэргээс бүрдэнэ. | Дохиолол холбоо, эрчим хүчний зураг төсөв зэргээс бүрдэнэ гэж нэмэх. | Техникийн болон инженерийн нарийвчилсан зурагт дохиолол холбоо, эрчим хүчний зураг багтах тул саналыг тусгаагүй. | "УБТЗ" ХНН НТП |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20 | 32.1.төмөр замын дэд бүтцийг шинээр барих, шинэчлэн сайжруулахад авто зам болон бусад төрлийн дэд бүтэцтэй ижил түвшинд огтлолцуулахгүй, төмөр замын дэд бүтцийн чиг, хэвгийг өөрчлөхгүй байх зарчим баримтална. | Төмөр замын дэд бүтцийг шинээр барих, шинэчлэн сайжруулахад авто зам болон бусад төрлийн дэд бүтэцтэй ижил түвшинд огтлолцуулахгүй, **ашиглаж буй** төмөр замын дэд бүтцийн чиг, хэвгийг өөрчлөхгүй байх зарчим баримтална. | 32.1.төмөр замын дэд бүтцийг шинээр барих, шинэчлэн сайжруулахад авто зам болон бусад төрлийн дэд бүтэцтэй ижил түвшинд огтлолцуулахгүй, **ашиглаж буй** төмөр замын дэд бүтцийн чиг, хэвгийг өөрчлөхгүй байх зарчим баримтална. | "УБТЗ" ХНН НТП |
| 21 | 32.3.төмөр замын дэд бүтцийг бусад дэд бүтэцтэй огтлолцуулах зардлыг шинээр дэд бүтэц барих хуулийн этгээд хариуцна. | Төмөр замын дэд бүтцийг бусад дэд бүтэцтэй огтлолцуулах **болон түүнтэй холбоотой бусад** зардлыг шинээр дэд бүтэц барих хуулийн этгээд хариуцна. | 32.3.төмөр замын дэд бүтцийг бусад дэд бүтэцтэй огтлолцуулах **болон түүнтэй холбоотой бусад** зардлыг шинээр дэд бүтэц барих хуулийн этгээд хариуцна. | "УБТЗ" ХНН НТП |
| 22 | 35.1.5.өөрийн болон түрээсийн салбар замтай байх; | Өөрийн **эзэмшлийн** болон түрээсийн салбар замтай байх; | 35.1.5.өөрийн **эзэмшлийн** болон түрээсийн салбар замтай байх; | "УБТЗ" ХНН НТП |
| 23 | 35.1.6.зорчигч, тээш, ачаан тээшийн тасалбар, тээвэрлэлтийн падаантай байх. | Энэ заалтыг хасах. | Хасах үндэслэлийг тодорхойлж бичээгүй байх тул саналыг тусгаагүй. | "УБТЗ" ХНН НТП |
| 24 | 35.3.5.хууль тогтоомжид заасан бусад үүрэг. | "Хуулийн шаардлага хангасан мэргэжлийн боловсон хүчинтэй байх" гэж нэмэх | 35.1.2-т заасан байх тул тусгаагүй. | "УБТЗ" ХНН НТП |
| 25 | 39.3.аюултай ачааны ачилт, буулгалт хийх зориулалттай, нээлттэй өртөөг нутгийн өөрөө удирдах байгууллагын саналыг үндэслэн төмөр замын тээврийн асуудал ~~эрхэлсэн~~ **<u>хариуцсан</u>** төрийн захиргааны байгууллага тогтооно. | "нутгийн өөрөө удирдах байгууллагын саналыг үндэслэн" гэснийг хасах /нөхцөл бүдээгүй бол захиргаадалтаар шийдвэл эрсдэлтэй/ | нутгийн өөрөө удирдах байгууллага нь иргэдийн аюулгүй байдлыг хангаж байгаа эсэхийг харгалзан үздэг тул саналыг тусгаагүй. | "УБТЗ" ХНН НТП |
| 26 | 1.1.Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, дэд бүтэц шинээр барих, шинэчлэх, дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. | Энэ хуулийн зорилт нь төмөр замын **тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж**, ~~аар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн~~ **хөдөлгөөний** аюулгүй байдлыг хангах, **төмөр замын** дэд бүтэц ~~шинээр~~ барих, ~~шинэчлэх~~, ашиглах, төмөр замын байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон ~~дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой~~ харилцааг зохицуулахад оршино гэж өөрчлөх. | Агуулгыг шинэчлэн найруулсан. | "УБТЗ" ХНН Хуулийн алба |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 27 | 4-р зүйл | “төмөр замын объект” гэсэн нэр томъёог тусгалгүй орхисон байна.<br><br>3.1.1.“төмөр замын объект” гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зурвас газар, суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон бусад тоног төхөөрөмж, эд хөрөнгийг; гэсэн нэр томъёог 2007 оны хуулиас дахин тусгах. | **“төмөр замын объект” гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зурвас газар, суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон бусад тоног төхөөрөмж, эд хөрөнгийг;** | “УБТЗ” ХНН Хуулийн алба |
| 28 | 4.1.7.“төмөр замын дэд бүтэц” гэж төмөр замын шугамын дээд, доод бүтэц болон гүүр, хоолой, инженерийн байгууламж, өртөө, зөрлөг, эрчим хүч, усан хангамж, дохиолол, холбоо, мэдээлэл, сүлжээний барилга байгууламж, техник, технологийн иж бүрдлийг; | “Суурь бүтэц” гэсэн нэр томъёог хэрэглэх. Энэ нэр томъёо нь илүү өргөн утгаар хэрэглэгдэж хэвшсэн. | Дэд бүтэц гэсэн нэр томъёог хэрэглэх тул тусгаагүй. | “УБТЗ” ХНН Хуулийн алба |
| 29 | 4.1.20.“гол төмөр зам” гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын дэд бүтцийг; | Нэр томъёог дахин нягтлах. 2007 оны ТЗТТ хуулийн “суурь бүтэц” гэсэн нэр томъёотой адил утгатай ойлгогдож байна. | Суурь бүтэц гэдгийг “дэд бүтэц” гэж өөрчилсөн, дэд бүтцийг “гол төмөр зам”, “салаа төмөр зам” гэж ангилсан. | “УБТЗ” ХНН Хуулийн алба |
| 30 | 4.1.21.“салаа төмөр зам” гэж стратегийн ач холбогдолтой болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан, гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр замын дэд бүтцийг; | ... стратегийн ач холбогдолтой гэснийг хасах. “салаа төмөр зам”-ын нэр томъёо нь “гол төмөр зам”-ын нэр томъёоноос ялгагдахгүй байна. | 4.1.21.“салаа төмөр зам” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан, гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх, гол төмөр замтай холбогдох төмөр замын дэд бүтцийг; | “УБТЗ” ХНН Хуулийн алба |
| 31 | 10.1.4.төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгчийн үйлчилгээний тарифын өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах; | “Төмөр замын суурь бүтэц ашиглалтын болон төмөр замын байгууллагын үйлчилгээний тарифын хэмжээг хянаж батлах” гэж өөрчлөн найруулах. | Энэ хэсэг агентлагийн чиг үүрэгт хаммарах бөгөөд тарифыг агентлаг батлах нь зах зээлийн зарчимд нийцэхгүй тул тусгаагүй. | “УБТЗ” ХНН Хуулийн алба |
| 32 | 10.1.5.төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийн зэрэг, зүтгүүрийн жолоочийн эрх олгох ажлыг зохион байгуулах; | Төмөр замын байгууллага нь өөрийн хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, зүтгүүрийн жолоочийн зэрэг олгодог тул төслийн 10.1.5 дахь заалтыг хасах. | Төрийн захиргааны байгууллагын зохицуулах шаардлагатай харилцаа тул тусгаагүй. | |
| 33 | 11.1.10.төмөр замын зориулалттай газарт объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам; | Энэ журам нь төмөр замын байгууллагын үйл ажиллагаанд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг дахин нягтлан үзэх. | Журмын төслийг шинэчлэн боловсруулахад саналыг харгалзан үзнэ. | |
| 34 | 23.2.Гол төмөр зам нь төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байна. | Энэ заалт нь 50-аас доош хувийн төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгжийн эрх ашигтай зөрчилдөж байна. | Шинэчилсэн найруулгын төслийн концепцид гол төмөр замыг зөвхөн төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд өмчлөхөөр, эсхүл концессийн | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нөхцөлтэйгээр хэрэгжүүлэхээр, ингэхдээ концесс эзэмшигчээр төрийн өмчийн оролцоотой компани оролцоход нээлттэй байхаар тусгасан. | |
| 35 | 25 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтэц эзэмшигчийн эрх, үүрэг | Энэ зүйлд " төмөр замын суурь бүтцийн өмчлөгч" гэсэн нэр томъёог хэрэглэх. Тээвэрлэгч нь суурь бүтэц ашиглалтын гэрээний үндсэн дээр тээвэрлэлт хийхээс гадна "өмчлөгч" гэсэн нэр томъёог илүү өргөн утгаар хэрэглэдэг. Мөн төмөр замын өмчлөгч болон эзэмшигчид тавигдах шаардлагыг хуулийн төсөлд тодорхой тусгах шаардлагатай гэж үзэж байна. | Хуулийн төслийн 23 дугаар зүйлд төмөр замын дэд бүтцийн өмчлөл, эзэмшлийн харилцааг зохицуулсан. | |
| 36 | | Хуулийн төсөлд төмөр замын суурь бүтэц өмчлөгчийн гэрчилгээ, эзэмшигчийн гэрчилгээ, хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгчийн гэрчилгээ болон тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, эдгээр эрх зүйн баримт бичгийг барьцаалж арилжааны зээл авах, зээлийн баталгаа гаргахтай холбогдсон зүйл заалт шинээр нэмэх. | Судлах | "УБТЗ" ХНН Хуулийн алба |
| 37 | 34 дүгээр зүйл. Төмөр замын тээвэрлэлтийн гэрээ | Энэ зүйлд тээвэр зуучлагч байгууллага, түүний үйл ажиллагаатай холбогдсон заалт нэмж оруулах. | Тээвэр зуучлалын тухай хуулийн төсөл боловсруулахаар судалж байна. | |
| 38 | 51.1.1.төмөр замын тээврийн байгууллагад 25 болон түүнээс дээш жил ажилласан эрэгтэй, 20 болон түүнээс дээш жил ажилласан эмэгтэй ажилтан төмөр замын тээврийн байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол арваас доошгүй сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох; | төмөр замын тээврийн байгууллагад 25 болон түүнээс дээш жил ажилласан эрэгтэй, 20 болон түүнээс дээш жил ажилласан эмэгтэй ажилтан төмөр замын тээврийн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол ~~арваас доошгүй~~ арван найман сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох; гэж өөрчлөх | Хуулийн төсөлд аж ахуйн нэгж байгууллагаас авсан санал, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн тэтгэмжийн хугацааг тогтоосон болно.<br><br>51.1.1.төмөр замын тээврийн байгууллагад 25 **ба** түүнээс дээш жил ажилласан эрэгтэй, 20 **ба** түүнээс дээш жил ажилласан эмэгтэй ажилтан төмөр замын тээврийн байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол **арав ба түүнээс дээш** сарын **үндсэн** цалинтай тэнцэх хэмжээний **тэтгэмжийг** нэг удаа ~~буцалтгүй тусламж~~ олгох; | |

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
Зам, тээврийн хөгжлийн сайд, яамны удирдлага, холбогдох албан тушаалтан оролцсон хурлын саналын товчоо
2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

| д/д | Төслийн зүйл заалт | Санал | Саналыг тусгасан байдал |
|---|---|---|---|
| 1 | 1.1.Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, дэд бүтэц шинээр барих, шинэчлэх, дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. | Шинээр барих, шинэчлэх гэснийг барих гэж өөрчлөх. | 1.1.Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, дэд бүтэц ~~шинээр~~ барих, ~~шинэчлэх,~~ дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. |
| 2 | 3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын тээвэртэй холбоотой ~~бүх төрлийн~~ харилцааг зохицуулахад өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй үйлчилнэ. | бүх төрлийн гэснийг сэргээх. | 3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын тээвэртэй холбоотой бүх төрлийн харилцааг зохицуулахад өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй үйлчилнэ. |
| 3 | 4.1.3."аюултай ачаа" гэж төмөр замын тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулах, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, үхэл, хордлого, түлэгдэлт, өвчин, осол үүсгэж болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс түүний хаягдлыг; | Дахин томъёолох. | Өөрчлөн найруулсан. |
| 4 | 6.1.3.гол төмөр замын чиглэл, царигийн асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр шийдвэрлэх; | "Засгийн газрын өргөн мэдүүлснээр" гэснийг хасах. | **<u>6.1.3. энэ хуулийн 7.1.11-т заасан гол төмөр замын чиглэл, царигийн асуудлыг шийдвэрлэх;</u>** |
| 5 | 6.1.4.төмөр замын зурвас газар эзэмшигчийг газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх. | "хууль тогтоомжид заасны дагуу" гэснийг хасах | 6.1.4.төмөр замын зурвас газар эзэмшигчийг газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх. |
| 6 | 7.1.8.төмөр замын үндэсний тээвэрлэгчийн статусыг тодорхойлох; | Хасах | 7.1.8-ийг хассан |
| 7 | 7.1.4. төмөр замын зурвас газрын ашиглах хугацааг тогтоох;<br><br>7.1.5.төмөр замын зурвас газар эзэмшигчийг газрын төлбөрөөс хөнгөлөх асуудлыг ~~хууль тогтоомжид заасны дагуу~~ шийдвэрлэх; | Шалгах | Саналын дагуу тусгасан. |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | 22.1.Төмөр замын дэд бүтцийг ашиглалтад хүлээн авах ажиллагааг энэ хуулийн 12.3.5-т заасан журмаар зохицуулна. | Ашиглах тухай анхаарах. | Саналын дагуу тусгасан. |
| 9 | 10.1.3.төмөр замын дэд бүтэц ашиглах, тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх, төмөр замын дэд бүтцийн эд анги, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах, ашиглах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;<br>~~8.1.9.төмөр замын дэд бүтцийн эд анги, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах, ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох;~~ | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд оруулах. | Саналын дагуу тусгасан. |
| 10 | 8.2.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд төмөр замын тээврийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төрийн захиргааны байгууллагатай байна. | .... дэргэд “” бодлого гэснийг харах | Саналын дагуу тусгасан. |
| 11 | 9.1.4.төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсаны улмаас учирсан хор уршгийг арилгахад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал, мод, ус ашиглах зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай олгох;<br><br>9.1.5.төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсаны улмаас учирсан хор уршгийг арилгахад тухайн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эзэмшил, ашиглалтад байгаа техник, тоног төхөөрөмжийг нөхөн олговортойгоор дайчлах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах; | Холбогдох хуульд нийцүүлэх. | Нийцүүлсэн. |
| 12 | 10.2.Төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалт болон сургалт, судалгаа шинжилгээ, төмөр замын тээврийн аюулгүй ажиллагааны хяналт, осол, зөрчлийг шинжлэн шалгах албатай байна.<br><br>10.3.Төмөр замын тээвэрт аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих төрийн захиргааны хяналтыг Хяналтын алба хэрэгжүүлнэ. | Чиг үүргийг томъёолон үлдээж, алба нэгжтэй байна гэдгийг хасах. | Саналын дагуу тусгасан. |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | 8-р зүйл | Сайдын эрх үүрэгт агентлагын бүтцийг сайд батална гэж нэмж оруулах. | **Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батална.** |
| 14 | | Гэрчилгээжүүлэлтийн талаар анхаарах. | - |
| 15 | 31.2.Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ эрхлэх болон тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд олгохыг хориглоно. | Хуучин хуулийн заалтыг оруулах. | Саналыг тусгасан. |

**МТЗ ХХК-ийн санал**
**2022.10.21 01/1570**

| д/д | Төсөл | Санал | Саналыг тусгасан байдал |
|---|---|---|---|
| 1 | | Хуулийн төсөлд шинээр "Үндэсний төмөр замын байгууллага" гэсэн зүйл нэмж тусган дараах байдлаар томьёолох:<br>1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэсэн хэсгийн дараа ....1. Үндэсний төмөр замын байгууллага нь төмөр замын дэд бүтэц эзэмших, ашиглуулах, тээвэр, логистикийн цогц үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлнэ.<br>2. ....2. Үндэсний төмөр замын байгууллага нь компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно. | 4.1.13-д "төмөр замын тээврийн байгууллага" гэж тодорхойлсон. |
| 2 | 4.1.13."төмөр замын тээврийн байгууллага" гэж тээвэрлэгч, төмөр замын дэд бүтэц эзэмшигчийг; | 4.1.13-д заасныг "төмөр замын байгууллага" гэж тээвэрлэгч болон төмөр замын дэд бүтэц эзэмшигчийг" гэж өөрчлөх; | Төсөлд томъёолсон санал. |
| 3 | 4.1.20."гол төмөр зам" гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой, хилийн боомт хүрэх чиглэлийн төмөр замын дэд бүтцийг; | 4.1.20-д заасныг "гол төмөр зам" гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой болон хил дамнасан төмөр замын дэд бүтцийг" гэж өөрчлөх; | Өөрчлөн найруулсан. |
| 4 | 4.1.21."салаа төмөр зам" гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан, гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх, гол төмөр замтай холбогдох төмөр замын дэд бүтцийг; | 4.1.21-д заасныг "салаа төмөр зам" гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулсан, гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр замын дэд бүтцийг" гэж өөрчлөх; | Өөрчлөн найруулсан. |
| 5 | 4.1.23."хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч" гэж тээвэрлэлтэд зориулан хөдлөх бүрэлдэхүүнээр хангах үйлчилгээ үзүүлж буй хүн, хуулийн этгээдийг; | 4.1.23-д заасныг "хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч" гэж тээвэрлэлтэд зориулан стандарт, журам, суурь бүтэц эзэмшигчийн техникийн шаардлагыг хангасан хөдлөх бүрэлдэхүүнээр хангах үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдийг" гэж өөрчлөх; | Өөрчлөн найруулсан. |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | 9.1.2.тухайн нутаг дэвсгэрт орших төмөр замын зурвас газар, түүний гадна байрлах төмөр замын байгууламжид нийгмийн хэв журам сахиулах ажлыг төмөр замын тээврийн байгууллагатай хамтран зохион байгуулах; | 9.1.2-д заасныг "тухайн нутаг дэвсгэрт орших төмөр замын зурвас газар, түүний гадна байрлах төмөр замын байгууламжид нийгмийн хэв журам сахиулах, мал, ан амьтныг төмөр замын хамгаалалтын бүсэд нэвтрүүлэхгүй байх ажлыг төмөр замын тээврийн байгууллагатай хамтран зохион байгуулах" гэж өөрчлөх; | Журмаар зохицуулах тул хуулинд тусгаагүй. |
| 7 | 8.1.5.төмөр замын дэд бүтэц ашиглах, тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх, төмөр замын дэд бүтцийн эд анги, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах, ашиглах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох; | "Төмөр замын дээд, доод бүтэц угсрах, төмөр замын дэд бүтэц ашиглах, тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх, төмөр замын дэд бүтцийн эд анги, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах, ашиглах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох" гэж өөрчлөх; | 4.1.6-д заасан төмөр замын суурь бүтэц гэдэг нэр томъёонд дээд, доод бүтэц багтана. |
| 8 | 23.1. Гол төмөр зам нь төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байна. | 23.2-д заасныг "Гол төмөр зам нь Үндэсний төмөр замын байгууллагын эзэмшилд байна" гэж өөрчлөх; | Өөрчлөн найруулсан. |
| 9 | | Шинээр Төмөр замын тээврийн улсын хяналтыг хэрэгжүүлэх талаар тусгаж өгөх; | Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт тусгасан. |
| 10 | | Шинээр "Гол төмөр замын чиглэлийг тогтоохдоо хот болон бусад суурьшлын бүсийн зэргэлдээ өнгөрөх бодлого баримтлах" гэснийг Засгийн газрын бүрэн эрхэд тусгаж өгөх. | УИХ болон ЗГ-ын бүрэн эрхэд тусгасан. |
| 11 | | "Үндэсний төмөр замын байгууллага" гэж дан ганц төрийн өмчид суурилсан, мэргэжлийн төмөр замын байгууллагыг; гэж 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгт шинээр нэмж оруулах. | Өөрчлөн найруулсан. |
| 12 | 10 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэсэн хэсгийн дараа шинээр зүйл нэмэх | ... дүгээр зүйл. Үндэсний төмөр замын байгууллага<br>....1. Үндэсний төмөр замын байгууллага нь төмөр замын дэд бүтэц эзэмшиж ашиглуулах, тээвэр логистикийн цогц үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулна.<br>....2. Үндэсний төмөр замын байгууллага нь компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно. | Саналыг тусгаагүй. |
| **МТЗ ХХК: ТӨМАР ЗАМЫН ДЭД БҮТЦИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТАЛААРХ ӨГӨХ САНАЛ** | | | |
| 1 | | "Захиалагч" гэж төмөр замын дэд бүтцийн барилгын ажил гүйцэтгүүлэх сонирхол бүхий иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | Хуулийн төсөлд энэ нэр томъёог оруулах шаардлагагүй. Захиалагчтай холбоотой харилцааг энэ хуульд заагаагүй. |
| 2 | | "Гүйцэтгэгч" гэж захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр төмөр замын дэд бүтэц, дэд бүтцийн зураг төсөл, | Авто замын тухай хуулийн 4.1.10-д заасан нэр томъёо; Хуулийн төсөлд |

| | | | |
|---|---|---|---|
| | | барилгын ажил, засвар, арчлалт, техник, технологийн хяналтын ажлыг гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээдийг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | энэ нэр томъёог оруулах шаардлагагүй. Гүйцэтгэгчтэй холбоотой харилцааг энэ хуульд заагаагүй. |
| 3 | | "Зураг төсөл зохиогч" гэж төмөр замын дэд бүтцийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий хуулийн этгээдийг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | Хуулийн төсөлд энэ нэр томъёог оруулах шаардлагагүй. Зураг төсөл зохиогчтой холбоотой харилцааг энэ хуульд заагаагүй. |
| 4 | | "Зураг төсөл" гэж төмөр замын дэд бүтэц барих, засварлах, шинэчлэхэд шаардагдах хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, нарийвчилсан зураг, техникийн шаардлага, өртгийн тооцооны нэгдсэн баримт бичгийг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | Авто замын тухай хуулийн 4.1.18-д заасан нэр томъёо; |
| 5 | | "Техникийн хяналт" гэж төмөр замын дэд бүтцийн барилга угсралтын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | **22.3.4.захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт;** |
| 6 | | "барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт" гэж төмөр замын дэд бүтцийн зураг төсөлд хараат бус, бие даасан, мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргах иргэн, хуулийн этгээдийг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | Барилгын тухай хуулийн 4.1.6<br><br>11.1.6.төмөр замын зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх журамд уг агуулгыг тусгах. |
| 7 | | "Төмөр замын дэд бүтцийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа" гэж төмөр замын дэд бүтцийг ашиглалтад оруулах хүртэл захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд төмөр замын дэд бүтцийн барилгын хийц, бүтээц, эдлэхүүн, тоног төхөөрөмж, цэвэр, бохир ус, цахилгаан, дохиолол холбооны ашиглалтын хэвийн нөхцөлийг хариуцан хангах хугацааг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | Барилгын тухай хуулийн 4.1.3<br><br>Төмөр замын дэд бүтцийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаатай холбоотой харилцааг хуулийн төсөлд заагаагүй. |
| 8 | | "барилга байгууламжийн баримт бичиг" гэж барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилгын ажлыг гүйцэтгэхэд | Барилгын тухай хуулийн 4.1.4 |

| | | | |
|---|---|---|---|
| | | шаардлагатай энэ хуульд заасны дагуу боловсруулж, баталгаажуулсан техникийн нөхцөлүүд, зураг төсөл, ил далд ажлын акт, талбайн журнал болон холбогдох бусад баримт бичгийг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | барилга байгууламжийн баримт бичигтэй холбоотой харилцааг хуулийн төсөлд заагаагүй. |
| 9 | | "Магадлашгүй ажил" төмөр замын дэд бүтцийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх явцад зураг төсөлд тусгагдаагүй нэмэлтээр зайлшгүй хийх ажлыг; гэж шинээр нэр томъёонд нэмэх. | 11.1.6.төмөр замын зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх журамд уг агуулгыг тусгах. |
| 10 | | Төмөр замын дээд бүтцийн барилгын ажилд ажиллах ажилчдын жишиг цалингийн тарифийг батлах; гэж 8-р зүйлд нэмэх. | Норм, дүрмээр зохицуулна. |
| 11 | 11.1.5.төмөр замын дэд бүтэц, салбар замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам; | Хасах саналтай байна. | Эдгээр баримт бичгийг зайлшгүй боловсруулж батлуулна. |
| 12 | 11.1.6.төмөр замын дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам; | Хасах саналтай байна. | |
| 13 | 11.1.24.төмөр замын барилгын ажлын төсвийн суурь норм, дүрэм; | Хасах саналтай байна. | |
| 14 | 11.1.Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд дараах дүрэм, журам, аргачлал, нормыг баталж мөрдүүлнэ: | 11.2. Төмөр замын дэд бүтцийг барьж байгуулахад дараахь норм, дүрэм, журмыг мөрдүүлнэ:<br>11.2.1. Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын төсвийн суурь норм, дүрэм;<br>11.2.2. Төмөр замын дэд бүтэц, салбар замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл олгох дүрэм;<br>11.2.3. Төмөр замын дэд бүтцийг ашиглалтад оруулах дүрэм;<br>11.2.4.Төмөр замын дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм;<br>11.2.5.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажилд захиалагчийн техникийн хяналт тавих дүрэм;<br>11.2.6. Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын явцад зохиогчийн техникийн хяналт тавих дүрэм;<br>11.2.7. Төмөр замын дэд бүтцийн норм, нормативын сангийн журам;<br>Төмөр замын тээврийн үйл ажиллагаа, төмөр замын дэд бүтцийн барилга угсралтын ажил 2 нь тусдаа үйл ажиллагаанууд учраас хуульд салгаж тус тусад нь зааж оруулах саналтай байна. | Дүрэм, журмыг боловсруулна. |

| | | | |
|---|---|---|---|
| 15 | **13 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийн норм, нормативын баримт бичиг**<br>Энэ асуудал зохицуулалтгүй явж байгаа тул энэ хуулиар зохицуулахаар нэмж оруулж өгөх. | 13.1.Төмөр замын дэд бүтцийн барилга угсралтын ажлыг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна:<br>13.1.1. Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын төсвийн суурь норм, дүрэм;<br>13.1.2. Төмөр замын дэд бүтцийн барилгын болон техникийн дүрэм, заавар, шаардлага, цомог, аргачлал;<br>13.1.3.стандарт;<br><br>13.2. Төмөр замын дэд бүтцийн норм, нормативын сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:<br>13.2.1. Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын төсөвт өртгөөс 0.4 хувиар авсан орлого;<br>13.2.2 Норм, нормативын баримт бичгийн борлуулалтын орлого;<br>13.2.3 Норм, нормативыг боловсронгуй болгох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын орлого;<br>13.2.4. бусад орлого;<br>13.3. Төмөр замын дэд бүтцийн норм, нормативын сангийн хөрөнгийг салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулна.<br>13.4 Төмөр замын дэд бүтцийн норм, нормативын баримт бичгийг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хэвлэхийг хориглоно.<br>13.5.Төмөр замын дэд бүтцийн норм, нормативын сан бүрдүүлэх зарцуулах үйл ажиллагааг 11.2.7 дахь журмын дагуу Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна. | Хуулийн төслийн 13 дугаар зүйл.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сан-д туссан. |

---oOo---

"УБТЗ" ХНН-ийн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны
өдрийн 10/3788 дугаар албан бичгийн хавсралт

# ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

| № | Хуулийн төслийн зүйл, заалт | Ирүүлсэн санал | Сналын тайлбар, тусгасан байдал |
|---|---|---|---|
| 1 | 1.1.Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, дэд бүтэц барих, дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. | Энэ хуулийн зорилт нь төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, төмөр замын байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна. | Санал "... өмчлөх, эзэмших, зорчигч, ачаа тээвэрлэх...." гэдгийг хасах<br><br>Дэд бүтэц гэсэн томъёололыг "Суурь бүтэц" гэж өөрчлөх Зөвшөөрлийн тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд Суурь бүтэц гэсэн томъёололоор орсон байна.<br><br>Тайлбар:<br><br>1.Хуулийн нэгдсэн сангаас хайж үзэхэд Хуулийн зорилтод өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах гэж тодорхойлсон тохиолдол байхгүй байна.<br><br>Харин Автотээврийн тухай хуульд ... тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой харилцааг... гэж тусгасан нь агуулгын хувьд Тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхойлсон өмнөх заалттай нь холбоотой болов уу.<br><br>2.Дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой бүх харилцааг зохицуулах зорилт тавих нь хуулийн хувьд хэт өргөн зорилт бөгөөд биелэх боломжгүй, өмчлөл, эзэмшлийн асуудлыг заавал хуулиар бүрэн хамарч зохицуулах нь Үндсэн хуулиараа тунхагласан "...олон хэвшил бүхий эдийн засагтай байх, ...төр нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч..." гэх зарчмуудад нийцэхгүй.<br><br>3.Тээвэрлэлтийн харилцаа нь одоогоор Иргэний хууль, Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн хүрээнд зохицуулагдаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 4.Олон улсын жишгээс харахад ч энэ харилцаа нь Иргэний эрх зүйн харилцааны зохицуулалтад хамаардаг бөгөөд Тээвэрлэлтийн дүрэм, хэрвээ нарийвчлан зохицуулсан бол Тээвэрлэлтийн тухай хуулиар зохицуулагддаг.<br><br>5.Дээр дурьдсан зохицуулалтын хүрээний асуудал нь цаашдаа Хууль зүйн хувьд Иргэний хууль – Төмөр замын тээврийн тухай хуулийн алийг баримтлах вэ гэдэг ойлголт, зохицуулалтын зөрүүтэй асуудал үүсгэж болзошгүй.<br><br>Энэ хуулийн хууль тогтоомж гэх хэсгээс харвал энэ хуулийг эхний ээлжинд баримтлаад, бусад хууль, түүний дотор Иргэний хуулиас энэ хуульд заагаагүй зүйлсийг л баримтлахаар ойлгогдож байна.<br><br>Энэ нь Тээвэрлэлтийн үйл ажиллагааны зарим нийтлэг зохицуулалтыг энэ хуулиас хасахад хүргэхгүй гэж үзэж байна.<br><br>**Эзэмшигч өмчлөгчийг зорилгоос хасаж, ашиглах гэдэг агуулгыг авч, саналыг тусгасан.** |
| 2 | 2.1.Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | 2.1.Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Иргэний хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | Санал: “Иргэний хууль” гэж нэмэх.<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 3 | 4.1.1.Төмөр замын тээвэр гэж төмөр замын тээвэрлэлт болон түүнд зориулагдсан дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, бусад байгууламж, тоног төхөөрөмж бүхий үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний технологийн иж бүрдлийг | | Санал: Энэ нэр томъёог хасах<br><br>**Саналыг тусгаагүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | 4.1.2."төмөр замын тээвэрлэлт" гэж зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэхэд бэлтгэх, тээвэрлэх, тээвэрлэлтийг дуусгахтай холбоотой технологийн харилцан уялдаатай цогц ажил үйлчилгээг; | 4.1.2."төмөр замын тээвэрлэлт" гэж зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэхэд бэлтгэх, тээвэрлэх, тээвэрлэлтийг дуусгах зорилго бүхий өөр хоорондоо зохион байгуулалтын болон технологийн хувьд харилцан уялдаатай цогц ажил үйлчилгээг; | Санал: ".... дуусгах зорилго бүхий өөр хоорондоо зохион байгуулалтын болон технологийн хувьд харилцан уялдаатай цогц ажил үйлчилгээг;" гэж нэмэлт өөрчлөлт оруулах<br><br>**Процедурын шинжтэй тул тусгаагүй.** |
| 5 | 4.1.3."тээвэрлэгч" гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу төмөр замын зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг; | 4.1.3."тээвэрлэгч" гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу төмөр замын тээврээр зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг; | Санал: төмөр замын гэсний дараа "тээврээр" гэж нэмэх<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 6 | 4.1.4. "төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч" гэж төмөр замын дэд бүтэц ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг; | 4.1.4. "төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч" гэж төмөр замын суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг; | Санал: "дэд бүтэц" гэсэн томъёоллыг "суурь бүтэц" гэж өөрчлөх<br><br>**Саналыг тусгасан.** |
| 7 | 4.1.5."төмөр замын тээврийн байгууллага" гэж тээвэрлэгч, төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийг; | 4.1.5."төмөр замын тээврийн байгууллага" гэж тээвэрлэгч, төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийг ; | Санал: "...үзүүлэгч хуулийн эдгээдийг" гэж нэмэх<br><br>**Саналыг тусгасан.** |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | 4.1.6.“төмөр замын дэд бүтэц” гэж төмөр замын дээд, доод бүтэц болон гүүр, хоолой, инженерийн байгууламж, өртөө, зөрлөг, эрчим хүч, усан хангамж, дохиолол, холбоо, мэдээлэл, сүлжээний барилга байгууламж, техник, технологийн иж бүрдлийг; | 4.1.6.“төмөр замын суурь бүтэц” гэж холбогдох стандартын дагуу бүтээгдсэн төмөр замын дээд, доод бүтэц болон гүүр, хоолой, инженерийн байгууламж, өртөө, зөрлөг, эрчим хүч, усан хангамж, дохиолол, холбоо, мэдээлэл, сүлжээний барилга байгууламж, техник, технологийн иж бүрдлийг; | Санал: “төмөр замын суурь бүтэц” тогтсон нэр томъёог өөрчлөхгүй байх.<br><br>Тайлбар: Анх тээврийн үндсэн суурь гэдэг утгаар нь хэрэглэж эхэлсэн нэр томъёо бөгөөд Эдийн засагт Үйлдвэр, Уурхайн салбарын хувьд 2-дагч буюу “ДЭД “ бүтэц гэх нэр томъёо нь Салбарын гол суурийг тодорхойлоход тохиромжгүй гэж үзэж хэрэглэж эхэлжээ.<br><br>Нэр томъёог өөрчлөх нь төрийн болон салбарын, түүнчлэн ААН-ийн түвшинд маш олон хэм хэмжээ, дүрэм журам, тэмдэглэгээ, зураг өөрчлөх үр дагавартай.<br><br>Хууль тогтоомж, УИХ-с баталсан Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого, Төрийн байгуулсан гэрээ хэлцэлүүд гм томоохон баримт бичигт, ААН-ийн хувьд маш олон баримт бичиг, зураг тэмдэглэгээг өөрчлөх, багагүй зардал гарахад хүрнэ.<br><br>Иймд нэгэнт тогтсон нэр томъёог хэт алдаатай, буруу утга илэрхийлж төөрөгдөлд оруулаагүй бол заавал өөрчлөхгүйгээр хэвээр нь үлдээх саналтай байна.<br><br>**Саналыг тусгасан.** |
| 9 | 4.1.7.“нийтийн төмөр зам” гэж нийгэм,эдийн засгийнач холбогдол бүхий нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттайтөмөр замын дэд бүтцийг; | 4.1.7.“нийтийн хэрэглээний төмөр зам” гэж нийгэм,эдийн засгийн ач холбогдол бүхий нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттайтөмөр замын дэд бүтцийг; | Санал: Энэ нэр томъёог хасах эсвэл одоо хүчин төглдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу Нийтийн хэрэглээний төмөр зам гэсэн томъёололоор явах<br><br>Тайлбар: Төмөр зам нь мөн чанарын хувьд нийтэд үйлчилгээ үзүүлэх зориулалтай байдаг. Иймд шаардлагагүй нэр томъёо байна.<br><br>Хэрвээ өмчлөлийн тухай энд тусгах бэлтгэл хийж байгаа бол зөвхөн өмчлөлтэй холбоотой хэсэгт л тусгайлаад заах боломжтой.<br><br>Санал: 4.1.7-д заасан нэр томъёог хасах<br><br>**Саналыг тусгахгүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | 4.1.8."тусгай зориулалтын төмөр зам" гэж аж ахуйн нэгж,байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан, гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх, нийтийн төмөр замтай холбогдох төмөр замын дэд бүтцийг; | | Санал:"тусгай зориулалтын төмөр зам" гэсэн нэр томъёог хасах, эсхүл ирээдүйд бий болж болох тусгай зориулалтын замыг оновчтой тодорхойлж өгөх<br><br>Тайлбар: Бүх төмөр зам нь гэрээний үндсэнд нийтэд үйлчилгээ үзүүлнэ. Иймд хэрвээ гэрээний үндсэнд нийтэд үйлчилгээ үзүүлэх юм бол "Тусгай зориулалтын" гэж ялгах шаардлага байна уу.<br><br>Энэ нь анхнаас нь авч байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой байх ёстой. Тусгай зориулалтын төмөр зам гэж зөвшөөрөл авчихаад Нийтэд үйлчилгээ үзүүлж тээвэрлэлт хийгээд байж болохгүй байх.<br><br>Мөн тусгай зориулалтын гэдгийг хэмжээгээр нь ч хязгаарлаж болох юм. Тухайлбал Төмөртэйн хүдэрийн уурхай хүрэх, хэд хэдэн өртөөтэй төмөр замыг "Тусгай зориулалтын" гэж ангилах нь буруу болов уу.<br><br>Хуучин хуульд байсан Дагнасан хэрэглээний зам буюу Хувийн өмчийн салбар замын ойлголтой ингэж адилтгах нь буруу байх.<br><br>Үүнд Цэргийн, зөвхөн Түлш, эсвэл нүүрс тээвэрлэх гм тусгай зориулалтай төмөр замыг хэлж болно.<br><br>Одоогоор ийм утгаараа Тусгай зориулалтын төмөр зам байхгүй.<br><br>Санал: "тусгай зориулалтын төмөр зам" гэсэн нэр томъёог хасах, эсхүл ирээдүйд бий болж болох тусгай зориулалтын замыг оновчтой тодорхойлж өгөх<br><br>**Хэлэлцүүлэх** |
| 11 | **4.1.9."салбар зам" гэж** өртөөний замаас салбарласан ачаа ачих, буулгах, хүлээн авах, олгох, хадгалах үйлчилгээ үзүүлэх болон бусад зориулалт, байгууламж бүхий төмөр замыг; | **4.1.9."салбар зам" гэж** өртөөний зам болон *бусад салбар замаас* салбарласан ачаа ачих, буулгах, хүлээн авах, олгох, хадгалах үйлчилгээ үзүүлэх болон бусад зориулалт, байгууламж бүхий төмөр замыг; | Санал: ... бусад төмөр замаас салбарласан гэж нэмэх<br><br>Тайлбар: Салбар зам нь үзөвхөн өртөөний замаас салбарладаггүй, дагнасан хэрэглээний салбар замуудаас салбарлаж барьсан салбар замууд байгаа.<br><br>**Саналыг тусгасан.** |
| 12 | .1.11."хөдлөх бүрэлдэхүүн | 4.1.11."хөдлөх бүрэлдэхүүн | Санал: |

| | | | |
|---|---|---|---|
| | эзэмшигч" гэж тээвэрлэлтэд зориулан хөдлөх бүрэлдэхүүнээр хангах үйлчилгээ үзүүлж буй хүн, хуулийн этгээдийг; | эзэмшигч" гэж хөдлөх бүрэлдэхүүнийг хууль зүйн эрхтэй өмчлөгч болон<br><br>тээвэрлэлтэд зориулан хөдлөх бүрэлдэхүүнээр хангах үйлчилгээ үзүүлж буй хүн, хуулийн этгээдийг- хөдлөх бүрэлдэхүүнийг хууль зүйн эрхтэй өмчлөгч гэж нэмэх; | 1...хөдлөх бүрэлдэхүүнийг хууль зүйн эрхтэй өмчлөгч.. гэж нэмэх<br><br>2.*"Хөдлөх бүрэлдэхүүн түрээслэгч "Хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэгч" гэсэн тодорхойлолтууд нэмэх*<br><br>**Саналыг тусгасан.** |
| 13 | 4.1.12."галт тэрэг" гэж чиглэлийн дугаар, зүтгүүр бүхий хөдлөх бүрэлдэхүүнийг; | 4.1.12."галт тэрэг" гэж чиглэлийн дугаар, зүтгүүр бүхий хэд хэдэн хөдлөх бүрэлдэхүүнийг; | Санал: ...зүтгүүр бүхий гэсний дараа "хэд хэдэн" гэж нэмэх<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 14 | 4.1.14."ачаа" гэж ачааны вагон, чингэлгээр тээвэрлэхээр зохих журмын дагуу хүлээн авсан эд зүйлсийг; | 4.1.14."ачаа" гэж ачааны вагон, чингэлгээр тээвэрлэхээр урьдчилан бэлдэж , зохих журмын дагуу хүлээн авсан эд зүйлсийг; | Санал: "...урьдчилан бэлдэж..." гэж нэмэх<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 15 | 4.1.17."аюултай ачаа" гэж төмөр замын тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулах, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, ухэл, хордлого, түлэгдэлт, өвчин, осол үүсгэж болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс түүний хаягдлыг; | 4.1.17."аюултай ачаа" гэж төмөр замын тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтан, **бусад ачаа, тээш** хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулах, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, ухэл, хордлого, түлэгдэлт, өвчин, осол үүсгэж | Санал: "бусад ачаа, тээш" гэж нэмэх<br><br>**Саналыг тусгаагүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| | | болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс түүний хаягдлыг; | |
| 16 | 4.1.20."төмөр замын цариг" гэж төмөр замын хос зам төмрийн дотор талын ажлын ирмэг хоорондын зайг; | 4.1.20."төмөр замын цариг" гэж хөдлөх бүрэлдэхүүний дугуйг чиглүүлэх үүрэгтэй төмөр замын хос зам төмрийн дотор талын ажлын ирмэг хоорондын зайг; | Санал: "....хөдлөх бүрэлдэхүүний дугуйг чиглүүлэх үүрэгтэй.." гэж нэмэх<br><br>"Төмөр замын цариг" гэсэн тодорхойлолтын өмнө "Гол зам" "Салбар зам", "Салаа зам"-ыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулинд заасан томъёоллоор нэмж оруулах<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 17 | 5.1.1.хөдөлгөөний нэгдсэн зохицуулалттай, тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулсан байх; | | Санал: "тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай" гэснийг хасах<br><br>Тайлбар:<br><br>Энэ хуулиас харвал Хөдөлгөөний нэгдсэн зохицуулалт гэдэг нь зөвхөн Төмөр замын тээврийн хүрээнд л хамаарах ойлголт байна. Иймд Тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулах гэдэг нь энэ зарчимтай нэг агуулга илэрхийлэхгүй тул тусад нь оруулах саналтай байна.<br><br>Мөн тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулах гэхээр өнөөдрийн байдалтай нь уялдуулах гэж ойлгогдож байна.<br><br>Төмөр зам нь харьцангүй нүсэр хэмжээтэй, бусад тээврийн үйл ажиллагаатай уялдаж хөгжих гэхээсээ тэдгээрт шууд нөлөөлж, тодорхойлж байдаг.<br><br>**Саналыг тусгасан.** |
| 18 | 6.1.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийг батлах, биелэлтийг хянан шалгах; | 6.1.1.төмөр замын талаар төрөөс баримтлах баримтлах бодлогыг тодорхойлох тээврийн тухай хууль тогтоомжийг батлах, биелэлтийг хянан шалгах; | Санал : "төмөр замын талаар төрөөс баримтлах баримтлах бодлогыг тодорхойлох" гэж нэмэх<br><br>**Саналыг тусгаагүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| 19 | 8.1.7.энэ хуулийн 7.1.3-д заасан ачааны тээвэрлэлтийг зохион байгуулах; | | Санал: Энэ заалтыг хасах<br><br>Тайлбар: Төрийн байгууллага Аж ахуйн үйл ажиллагаанд ийм байдлаар оролцох нь зохимжгүй, эрсдэлтэй.<br><br>Онцгой ач холбогдолтой ачаа гэх жагсаалтыг Засгийн газар гаргахдаа Ерөнхий нэршлээр гаргана. Гол ачаа болох нефть, нүүрс, төмрийн хүдэр, барилгын материал орох болов уу.<br><br>Зохион байгуулах гэдэг нь хуулийн хувьд анхан шат хүртэл нь тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүх шийдвэрийг гаргана гэж ойлгогдоно.<br><br>Энэ нь бүх тээврийн үйл ажиллагааг салбарын яам зохион байгуулж оролцоход хүргэхээр болгож байна.<br><br>Цаашид төрийн оролцоог хэт өргөн нээж өгч байгаа нь тээвэрлэлтийн зохион байгуулж байгаа этгээдүүдийн үйл ажиллагаанд эрсдэлтэй.<br><br>Төрийн хувьд суурь бүтцийн өмчлөлд хувь эзэмшиж байгаа.<br><br>**Саналыг тусгасан.** |
| 20 | 8.1.8.төмөр замын осол, зөрчлийг шинжлэн шалгах.<br><br>11.1.7.төмөр замын осол, зөрчлийг шинжлэн шалгах журам; | 8.1.8.төмөр замын осол, гологдлыг шинжлэн шалгах.<br><br>11.1.7.төмөр замын осол, гологдлыг шинжлэн шалгах журам; | Санал: “зөрчлийг” гэснийг “гологдол” гэж өөрчлөх.<br><br>Тайлбар: Энэ салбар бий болсон цагаас эхлээд 70 гаруй жил хэрэглэж байгаа тогтсон нэр томъёог хэрэглэх<br><br>Хэн нэгэн албан тушаалтны буруугаас биш техникийн хувьд доголдол – гологдол гарахыг шууд зөрчил гэж үзэх нь буруу.<br><br>Хэрэв Зөрчлийн хуульд заасан зөрчлөөс өөр ойлголтоор орж байгаа гэвэл суурь хуулийн ижил нэр томъёотой адил нэр томъёо хэрэглэх нь ойлгомжгүй байдал үүсгэнэ.<br><br>**Саналыг тусгаагүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | | 11.1.28. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ, техникийн аудит хийх журам<br><br>11.1.29. Төмөр замын хэмжил зүйн дүрэм (журам) | Санал: 11.1.27 заалтын дараа 2 шинээр заалт нэмэх<br><br>Тайлбар:Төмөр замын тээвэрт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудал нэнэ тэргүүнд тавигддаг.<br><br>Монгол улсад төмөр замын тээвэрлэлтэд оролож байгаа бүх этгээдүүд нь нэгдсэн техникийн стандарт, шаадлагын хүрээнд үйл ажиллагаа явуулах шаардлагатай.<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 22 | 10.2.6.дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах; | | Санал: Энэ заалтыг хасах<br><br>Тайлбар: Засгийн газрын агентлаг талуудын хооронд байгуулсан гэрээний асуудал, маргаанд оролцох нь урьдчилж хараагүй сөрөг үр дагавар бий болгох, ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай.<br><br>Хэрэв гэрээ бүхий этгээдүүд болон гуравдагч этгээд нь тухай гэрээнээс үүдэлтэйгээр эрх ашгаа зөрчигдаж байна гэж үзвэл Хэрэглэгчийн төлөө газар, шүүхэд хандаж шийдвэрлүүлэх нь зүйтэй байх.<br><br>Мөн шаардлагатай тохиолдол гэх шалгуурыг тодорхойлоход хүндрэлтэй.<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 23 | 10.4-ийн дараа 10.5 гэсэн заалт нэмэх | 10.5. Суурь бүтэц эзэмшигч нь төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа тээш, ачаан тээшийг гэмт халдлагаас хамгаалах үүрэг бүхий харуул хамгаалалтын болон хууль тогтоомж төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн биелэлт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий дотоод хяналтын албатай байна. | **Саналыг тусгасан.** |

| | | | |
|---|---|---|---|
| 24 | 11-р зүйл | | Санал:<br>1.Тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам гэж нэмэх<br>2.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын шаардлага-регламент”<br>3.“Төмөр замын тээврийн суурь бүтцийн аюулгүй байдлын шаардлага-регламент”<br>4.Тээврийн аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл дамжуулах журам”<br>**1-р саналыг тусгасан.** |
| 25 | 14.1.5. Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах<br>14.1.6.Техник технологийн хяналт тавих | | Энэ хоёр тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулинд тусгахаар санал боловсруулах<br>**Саналыг тусгасан.** |
| 26 | 14.2.Энэ хуулийн 7.1.5-д заасан зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх шийдвэрийг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасны дагуу төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана. | | Санал: 7.1.5 гэснийг 14.1.5 гэж засах<br>**Саналыг тусгасан.** |
| 27 | 15-р зүйл /Тайлбар хийв/ | | Санал: 15, 17 дугаар зүйлд тусгасан Төмөр замын тээврийн зориулалттай газар, төмөр замын зурвас газар, төмөр замын аюултай бүс, төмөр замын обьектын талбайн хэмжээ, хил хязгаарыг тодорхой хуульчлах зүй ёсны шаардлагатай байна.<br>Тайлбар:<br>Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | зам"-ыг байгуулах тухай БНМАУ болон ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн болон 1952 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн хэлэлцээрээр төмөр замын бүх шугамын дагуу 120 метр өргөн зурвас газар ба харин өртөө, зөрлөгүүд дээр уртаашаа 2000 метр, өргөнөөрөө 300 метр газрын Нийгэмлэгт хугацаагүйгээр хэрэглүүлэхээр шилжүүлнэ гэж тохиролцсон байдаг.<br><br>Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Төмөр замын тээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтад "...төмөр замын зурвас газар" гэж төмөр замын шугамын дагуух технологийн онцлог үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий газрыг...", 3.1.1 дэх заалтад "...төмөр замын объект" гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зурвас газар, суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон бусад тоног төхөөрөмж, эд хөрөнгийг...", 6.1 дэх хэсэгт "...Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна...", 3.1.12 дахь заалтад "...төмөр замын аюултай бүс" гэж галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг дэвсгэр газрыг...", 3.1.13 дахь заалтад "...төмөр замын аюулгүйн бүс" гэж төмөр зам дээр тохиолдож болох осол, сүйрлээс хуулийн этгээд, иргэнд учрах хохирлыг багасгах, аюулгүй нөхцөлийг хангах зориулалт бүхий газрыг..." гэж тус тус хуулчилахдаа төмөр замын зурвас газар, төмөр замын аюултай бүс, төмөр замын обьектын талбайн хэмжээ, хил хязгаарыг тодорхой хуульчилж өгөөгүй.<br><br>Үүнтэй холбоотойгоор 1949, 1952 оны хэлэлцээрийн хүрээнд "УБТЗ" ХНН-д олгосон газрыг Нийслэлийн Засаг Дарга нар бусад иргэн, аж ахуй нэгжүүдэд эзэмшүүлсээр ирсэн. Үүнтэй холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхэд төмөр замын зурвас газрыг бусдад эзэмшүүлсэнтэй холбоотой газрын маргаан ихэссэн төдийг төмөр замын аюулгүй ажиллагаа, иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөхөд хүрээд |

| | | | |
|---|---|---|---|
| | | | байна.<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 28 | 16.1.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг тусгай тэмдэг, тэмдэглэгээ бүхий дэвсгэр газрыг төмөр замын тусгай бүсэд хамааруулна. | 16.1.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг тусгай дэвсгэр газрыг төмөр замын тусгай бүсэд хамааруулна | 16.1. "...тэмдэг тэмдэглэгээ бүхий..." гэснийг хасах.<br><br>Тайлбар:<br><br>Тэмдэг тэмдэглэгээгүй бол тусгай бүст хамаарахгүй байхаар ойлгогдож болзошгүй.<br><br>Тэмдэг, тэмдэглэгээг тавих нь Дэд бүтэц, Салбар зам эзэмшигчийн үүрэг байх ёстой болохоос Тусгай бүс мөн эсэхийг тодорхойлох шалгуур биш болов уу.<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 29 | 20.1.Монгол Улсын төмөр замын сүлжээний царигийн хэмжээ ижил байна.<br><br>20.2.Шинээр барих төмөр зам нь Монгол Улсын төмөр замын сүлжээнд холбогдох буюу огтлолцох нөхцөлд түүний царигийн хэмжээ ижил байна. | | Санал: 20.1, 20.2 дах заалтыг хасах<br><br>Одоог хүртэл шүүмжлүүлж байгаа асуудлыг ингэж эрс хуульчлах нь маргаан үүсгэх эрсдэлтэй.<br><br>УИХ-с царигийн асуудлыг шийдвэрлэнэ гэж тусгачихсан атлаа өөр цариг байж болохгүй гэж заасан нь ойлгомжгүй байна. Өөр цариг байж болох тухай заасан, одоо мөрдөж байгаа Төмөр замын бодлоготой ч зөрчилдөнө.<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 30 | **24.3.Нийтийн төмөр замыг концессоор барих тохиолдолд** төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг концессийн гэрээнд тусгасан байна. | 24.3.Нийтийн төмөр замыг концессоор барих тохиолдолд төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг концессийн гэрээнд тусгана. | "тусгасан байна<br><br>" гэснийг "тусгана" гэж өөрчлөх.<br><br>**Саналыг тусгаагүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| 31 | 26.1.5.Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвтэй байна. | 26.1.5. Төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэгч нь хөдөлгөөний удирдлагын төвтэй байна. | Санал: “Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь” гэснийг “Төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэгч нь” гэж өөрчлөх<br><br>Тайлбар: Дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь суурь бүтцийнхээ техникийн бэлэн байдлыг л хангах үүрэгтэй байдаг. Жишээ нь РЖД-ийн дирекция инфраструктуры-ЦИ-д удирдлагын төв байдаггүй. ЦД –д удирдлагын төв нь харъяалагддаг. КТЖ-ийн (казакстаны төмөр зам) суурь бүтэц нь АО “НК КТЖ” компанид харъяалагддаг бол ачаа тээвэр-хөдөлгөөн зохион байгуулалт нь АО “КТЖ Грузовые перевозки” компанид харъяалагддаг.<br><br>**Саналыг тусгасан.** |
| 32 | 36.5.Төмөр замын тээвэрлэлтэд саад учруулахааргүй бол ачаа илгээгч нь явуулах өртөө болон тээвэрлэлтийн явцад, ачаа хүлээн авагч нь хүрэх өртөөнд хаяг сольж болно.<br><br>36.6.Ачаа хүлээн авагч болон зорчигч нь ачаа, тээш, ачаан тээшийг хүрэх өртөөнд ирсний дараа тогтоосон хугацаанд хүлээн авна.<br><br>37.6.Ачаа илгээгч худал мэдүүлсэн бол тээвэрлэгч ачааг тээвэрлэхээс татгалзана. | | Санал: 36.5, 36.6, 36.7 –г хасах<br><br>Тайлбар: Энэ хэм хэмжээг Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрмээр зохицуулна.<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 33 | 38.4.6.тээвэрлэгч ачаа олгох бичиг баримтыг үйлдсэнээс хойш ачаа хүлээн авагчийн шаардсанаар 24 цагийн дотор ачааг буулгалтын замд тавиагүй. | “буулгалтын зам“ гэж тээвэрлэлтийн баримт бичигт заасан ачааг буулгах буюу ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгөх салбар зам | Санал: “буулгалтын зам” гэснийг нэр томъёонд оруулах эсхүл энд нь тодруулж оруулах<br><br>**Саналыг тусгаагүй.** |

| | | | |
|---|---|---|---|
| 34 | 36.9.Тээвэрлэгч нь ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хүн, хуулийн этгээдийн эзэмшлийн вагон, зөвшөөрөлгүй тээвэрлэлтэд ашиглахыг хориглоно. | . | *Энэ заалт ойлгомжгүй байна.*<br><br>**Саналыг тусгасан.** |
| 35 | 40.3.Аюултай ачааны ачилт, буулгалт хийх зориулалттай өртөөг сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллага тогтооно. | 40.3.Аюултай ачааны ачилт, буулгалт хийх зориулалттай өртөөг сум, дүүргийн Засаг дарга, суурь бүтэц эзэмшигч нарын саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллага тогтооно. | Санал: "суурь бүтэц эзэмшигч нарын" гэж нэмэх<br><br>**Саналыг тусгасан.** |
| 36 | 40.6.Аюултай ачааг тээвэрлэхэд бэлтгэх, ачих, буулгах үеийн аюулгүй байдлыг ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хариуцна.<br><br>40.8.Зорчигчийн галт тэргэнд аюултай ачаа биедээ авч явахыг хориглоно.<br><br>40.9.Аюултай ачааг ачиж, буулгах, хадгалахтай холбоотой хууль тогтоомж, стандарт, журмын шаардлага хангаагүй салбар замд аюултай ачаа ачих, буулгах үйл ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно. | | Санал: 40.8 гэснийг 40.7, 40.9 гэснийг 40.8 гэж дугаарлалт засах<br><br>**Саналыг тусгасан.** |
| 37 | 41.2.Хөдлөх бүрэлдэхүүний паркийг бүрдүүлэхэд засвар, ашиглалтын технологийн нийцлийг хангасан байна. | | Санал: Энэ заалтыг хасах<br><br>Тайлбар:<br><br>Төрийн захиргааны байгууллага Хөдлөх бүрэлдэхүүнийг гэрчилгээжүүлэхдээ Технологийн нийцэл, шинэчлэлийг нь тал бүрээс нь харгалзан үзэж байж гэрчилгээ олгоно. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | **Саналыг тусгаагүй.** |
| 38 | 42.1.Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч дараах эрхтэй: | 42.1.Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч нь дараах эрхтэй: | Санал: "... түрээслэгч.. "гэж нэмэх<br>**Саналыг тусгаагүй.** |
| 39 | 42.2.Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч дараах үүрэгтэй:<br>42.2.1.хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах;<br>42.2.2.хөдлөх бүрэлдэхүүнд зохих журмын дагуу засвар, техникийн үйлчилгээ хийх; | 42.2.Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч нь дараах үүрэгтэй:<br>42.2.1.хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдал, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах;<br>42.2.2.хөдлөх бүрэлдэхүүнд зохих журмын дагуу засвар, техникийн үйлчилгээ хийлгэх | Найруулгын засвар хийв<br>**Саналыг тусгасан.** |
| 40 | **43 дугаар зүйл.Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт**<br>43.2.Хөдлөх бүрэлдэхүүний хийц бүтээцийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно. | **43 дугаар зүйл.Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, засвар**<br>43.2.Хөдлөх бүрэлдэхүүний хийц бүтээцийг ~~эрх бүхий~~ төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно. | Санал: "... засвар" гэж нэмэх<br>"эрх бүхий байгууллагын" гэснийг төрийн захиргааны байгууллагын гэж өөрчлөх<br>Хөдлөх бүрэлдэхүүний үйлдвэрлэл, угсралтыг гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг нэмэх<br>**Саналыг тусгаагүй.** |
| 41 | **45.1.Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон** хөдлөх бүрэлдэхүүн **эзэмшигч, тээвэрлэгч,** дэд бүтцийн эд | **45.1.Төмөр замын дэд бүтцийнүйлчилгээ үзүүлэгч болон** хөдлөх бүрэлдэхүүн **эзэмшигч, тээвэрлэгч,** дэд | Санал: "...этгээд нь тусгай зориулалттай тоног төхөөрөмж..." гэж нэмэх |

| | | | |
|---|---|---|---|
| | анги, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах эрх бүхий **этгээд нь тусгай зориулалттай багаж, хэрэгсэлтэй байна.** | бүтцийн эд анги, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах эрх бүхий **этгээд нь тусгай зориулалттай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэлтэй байна.** | **Саналыг тусгаагүй.** |
| 42 | 47.1.Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ачаа эргэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. | 47.1.Төмөр замын тээврийн байгууллага нь улсын хөгжлийн бодлого, зорилтуудтай уялдсан төмөр замын тээврийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ачаа эргэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх стратеги хөгжлийн загвар, төлөвлөгөөтэй байна. | Санал: "...байгууллага нь улсын хөгжлийн бодлого, зорилтуудтай уялдсан... " гэж нэмэх<br><br>**Саналыг тусгаагүй.** |
| 43 | 47.2 заалтын дараа 47.3 гэсэн заалт шинээр нэмэх | | 47.3. "Төмөр замын тээврийн байгууллага нь салбарын хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хэмжил зүйн үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий нэгжтэй байж болно".<br><br>**Саналыг тусгасан.** |
| 44 | 50.2.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан ажилд анх орохдоо эмнэлгийн урьдчилсан үзлэгт, ажил гүйцэтгэх явцад хугацаат үзлэгт хамрагдах үүрэгтэй | 50.2. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны тав байгууллагын баталсан журмын дагуу ажилд анх орохдоо эмнэлгийн урьдчилсан үзлэгт хамрагдаж, ажил гүйцэтгэх явцад хугацаат үзлэгт хамрагдах үүрэгтэй | Санал: "... Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны тав байгууллагын баталсан журмын дагуу... " гэж нэмэх<br><br>**Саналыг тусгасан.** |
| 45 | 50.3.Төмөр замын ажилтан дүрэмт хувцас хэрэглэнэ. | 50.3. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн зохион | Санал: Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтнууд, тээврийн үйлчилгээний ажилтнууд дүрэмт хувцас хэрэглэхээр |

| | | | |
|---|---|---|---|
| | | байгуулагч, тээвэрлэлтийн үйлчилгээний ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцас хэрэглэнэ. | тусгах<br><br>Тайлбар:<br><br>Нийт ажилтан заавал дүрэмт хувцас хэрэглэх үүрэгтэй байхаар хуульчилж байна.<br><br>Гэтэл галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоогүй оффисийн цэвэрлэгч, УБТЗ-ын харъяанд байгаа цэцэрлэг /бие даасан хуулийн этгээд биш/, хэвлэл, дэлгүүрийн ажилтнууд, олон нийттэй харилцах үүрэггүй оффисын ажилтнуудыг дүрэмт хувцас хэрэглэхийг хуульчилсан нь зохимжгүй болов уу.<br><br>Харин Төмөр замын багц дүрмээрээ зохицуулаад явах боломжтой байна.<br><br>Хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохицуулалт 29.2.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн зохион байгуулагч, тээвэрлэлтийн үйлчилгээний ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцас хэрэглэнэ.<br><br>**Саналыг тусгасан.** |
| 46 | 51.1.1.төмөр замын тээврийн байгууллагад 25 болон түүнээс дээш жил ажилласан эрэгтэй, 20 болон түүнээс дээш жил ажилласан эмэгтэй ажилтан төмөр замын тээврийн байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол арваас доошгүй сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох; | 51.1.1.төмөр замын тээврийн тухайн байгууллагад 25 болон түүнээс дээш жил тасралтгүй ажилласан эрэгтэй, 20 болон түүнээс дээш жил тасралтгүй ажилласан эмэгтэй ажилтан тухайн төмөр замын тээврийн байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол зургаан сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох; | Санал: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн заалтыг хэвээр үлдээх<br><br>Тайлбар:<br><br>Энэ нь аж ахуйн нэгж бүр өөрийн санхүүгийн боломж, нөхцөлийг харгалзан үзэж байж, өөрийн байгууллагын хүрээнд дотоод хэм хэмжээгээр тус тусдаа зохицуулах асуудал юм.<br><br>Төрийн зохицуулалтын зорилт нь зүй ёсны хувьд нийтэд таалагдах, сөрөг нөлөөтэй байж болох нэг удаагийн тусламж биш харин тогтвор суурьшилтай ажилтнуудад өрсөлдөхүйц цалин олгох, тэтгэвэр нь хүний амьдралд хангалттай байх нөхцөлийг бий болгоход чиглэх учиртай.<br><br>Өмчийн олон төрөл хэлбэрийн төмөр замын байгууллагууд бий болж байгаа тул “төмөр замын тээврийн байгууллагад” гэж ерөнхий заах нь маргаан үүсгэх болон ойлгомжгүй нөхцөл үүсгэнэ. Иймд тухайн тухайн аж ахуйн нэгж байгууллагадаа тогтвор суурьшилтай |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ажилласан байхаар зохицуулах нь зүйтэй болов уу.<br><br>Том ААН-д ажиллаж байгаад сүүлийн 1 жил аль нэг жижиг байгууллагад ажилласан хүнд шинээр бий болсон ААН-үүд ийм хэмжээний тусламж олгох нь хүндрэлтэй.<br><br>Хууль батлагдсанаас гарч болох нийгэм эдийн засгийн нөлөөллийг зайлшгүй бүрэн тооцож үзэх шаардлагатай.<br><br>Жил бүр тэтгэвэрт гардаг ажилтнуудын тоог тооцвол /ихэнх нь салбартаа ажилласан төмөр замын мэргэжлийн ажилтнууд байдаг тул 90%+ нь ийм тусламж авах болохоор байна/ жилд хэдэн төгрөгийн зардал гарахыг тооцох.<br><br>Дунджаар нийт ажилтны 90% гэсэн хувилбараар тооцож баримжаа гаргаж үзэх хэрэгтэй.<br><br>Нөгөө талаас энэ заалт цаашдаа олон жил ажилласан туршлагатай хүнийг ажилд авахгүй байх сөрөг хандлагыг бий болгоно. Мөн удаан ажилласан хүнийг халах, шилжүүлэх хандлага ч гарах эрсдэлтэй.<br><br>Тооцоо, судалгаанд үндэслэхгүйгээр шинэ зохицуулалт тусгах нь салбарт бүхэлд нь сөргөөр нөлөөлөх, тооцоолоогүй үр дагавар гаргаж болзошгүй байгаа тул хэвээр үлдээх саналтай байна.<br><br>**Саналыг тусгаагүй.** |

-оОо-

# ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ УЛСЫН ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

| д/д | Нэрс | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Л.Халтар | - Зам, тээврийн хөгжлийн дэд сайд |
| 2 | С.Батболд | - Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 3 | М.Энхболд | - Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга |
| 4 | Б.Болор-Эрдэнэ | - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга |
| 5 | С.Мяндасмаа | - Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга |
| 6 | Л.Булганхүү | - Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч |
| 7 | П.Ганхүү | - “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал |
| | Х.Хэрлэн | - “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын дарга |

--- o O o ---